



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-22
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	23-127

1. Улсын Их Хурлын чуулганаар “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх	24-25
2. Улсын Их Хурлын чуулганаар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх	25-27
3. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2025.07.03-ны өдөр мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	27-43 90-94
4. Нийтийн өмчийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	43-67 95-101
5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	67-82 102
6. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	82-90 103
7. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	103-110 126
8. “Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	110-112 126
9. “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	113-120 127
10. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2025.07.03-ны өдөр мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	120-122 125-126
11. Зарим Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай	122-125

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
07 дугаар сарын 08-ны өдөр /Мягмар гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 73 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, Ж.Ганбаатар, Б.Дэлгэрсайхан, Л.Мөнхбаатар, Л.Мөнхбаясгалан, Б.Мөнхсоёл, Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин;

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Б.Батцэцэг, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Л.Гантөмөр, С.Лүндэг, Р.Эрдэнэбүрэн;

Хоцорсон: О.Алтангэрэл-28 минут, Т.Аубакир-3 цаг 13 минут, Ц.Баатархүү-24 минут, М.Бадамсүрэн-29 минут, Д.Батбаяр-04 минут, Р.Батболд-01 минут, Ж.Батсуурь-03 минут, П.Батчимэг-19 минут, Ж.Бат-Эрдэнэ-13 минут, Ж.Баярмаа-19 минут, Ж.Баясгалан-05 минут, Х.Болормаа-06 минут, Г.Ганбаатар-1 цаг 24 минут, С.Ганбаатар-1 цаг 47 минут, Д.Ганбат-17 минут, П.Ганзориг-18 минут, Ц.Даваасүрэн-40 минут, Б.Жавхлан-3 цаг 23 минут, Х.Жангабыл-27 минут, Б.Жаргалан-01 минут, Д.Жаргалсайхан-55 минут, Ж.Золжаргал-40 минут, Ц.Мөнхбат-23 минут, Т.Мөнхсайхан-27 минут, Ц.Мөнхтуяа-59 минут, З.Мэндсайхан-40 минут, М.Нарантуяа-Нара-40 минут, Ч.Номин-05 минут, Н.Номтойбаяр-03 минут, Э.Одбаяр-40 минут, Г.Очирбат-06 минут, Б.Пунсалмаа-57 минут, Д.Рэгдэл-01 минут, О.Саранчулуун-23 минут, Р.Сэддорж-18 минут, Ц.Туваан-23 минут, Б.Түвшин-52 минут, Г.Тэмүүлэн-15 минут, Ч.Ундрам-22 минут, Н.Учрал-23 минут, Г.Уянгахишиг-22 минут, Д.Цогтбаатар-08 минут, С.Цэнгүүн-05 минут, Б.Чойжилсүрэн-01 минут, Ө.Шижир-07 минут, Б.Энхбаяр-1 цаг 05 минут, Ж.Энхбаяр-3 цаг 29 минут, Д.Энхтуяа-02 минут, М.Энхцэцэг-05 минут.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хороонд хуваарилсныг мэдээлэх

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасны дагуу Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй

холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.07.04-ний өдөр мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд;

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг нарын 13 гишүүн 2025.07.04-ний өдөр өргөн мэдүүлснийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд;

“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас 2025.07.07-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд тус тус хуваарилсныг мэдээлэв./10:07/

Нэг.Улсын Их Хурлын чуулганаар “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ.” гэж заасны дагуу 2025.07.07-ны өдөр Засгийн газраас “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болохыг танилцуулав.

Д.Амарбаясгалан: “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	48
Татгалзсан:	28
Бүгд:	76

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын Их Хурлын чуулганаар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ.” гэж заасны дагуу Засгийн газраас 2025.07.07-ны өдөр Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болохыг танилцуулав.

Хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцүүлэхтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж тайлбар хийв.

Хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэх санал хураалтыг Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэний дараа явуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.07.03-ны өдөр мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, А.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Ж.Батжаргал, Ө.Шижир, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./11:11/

Дөрөв.Нийтийн өмчийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, А.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, П.Сайнзориг, О.Номинчимэг, Х.Баасанжаргал, Х.Булгантуяа, Ц.Баатархүү нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ж.Батжаргал нар үг хэлэв

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:33/

Тав.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн

хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга Ц.Ням-Очир, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Зам, тээврийн хяналт төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн дарга Б.Очирбат, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Ө.Жамбалсүрэн, хуульч, судлаач Д.Нагважамц нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх **Г.Алтанцэцэг**, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, О.Номинчимэг, Х.Баасанжаргал, Х.Булгантуяа, Ц.Баатархүү нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Ө.Жамбалсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, М.Мандхай нар үг хэлэв

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./13:23/

Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан 3 цаг 23 минут үргэлжилж, 13 цаг 23 минутад өндөрлөв.

Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан 14 цаг 50 минутад эхлэв.

Зургаа.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх И.Баттөгс нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын Байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, П.Мөнхтулга, Б.Хэрлэн, Р.Батболд нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./15:27/

Гурав дахь асуудал буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12-т заасны дагуу хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 50

Бүгд: 109

54.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийг дэмжсэнээр тооцож, 55.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв./16:00/

Уг асуудлыг 16 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв дэх асуудал буюу Нийтийн өмчийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12-т заасны дагуу хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Нийтийн өмчийн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 50

Бүгд: 109

54.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Д.Амарбаясгалан: 2.Байнгын хорооны саналаар Нийтийн өмчийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 46

Бүгд: 109

57.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 45

Бүгд: 109

58.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 50

Бүгд: 109

54.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 48

Бүгд: 109

56.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 43
Бүгд: 109

60.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

7.Байнгын хорооны саналаар Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 45
Бүгд: 109

58.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

8.Байнгын хорооны саналаар Генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 46
Бүгд: 109

57.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

9.Байнгын хорооны саналаар Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 49
Бүгд: 109

55.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

10.Байнгын хорооны саналаар Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 47
Бүгд: 109

56.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

11.Байнгын хорооны саналаар Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 46
Бүгд: 109

62.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

12.Байнгын хорооны саналаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 47

Бүгд: 109

56.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

13.Байнгын хорооны саналаар Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 45

Бүгд: 109

58.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

14.Байнгын хорооны саналаар Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 44

Бүгд: 109

59.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

15.Байнгын хорооны саналаар Кибер аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 43

Бүгд: 109

60.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

16.Байнгын хорооны саналаар Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 45

Бүгд: 109

58.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

17.Байнгын хорооны саналаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 43
Бүгд: 109
60.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

18.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 45
Бүгд: 109
58.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

19.Байнгын хорооны саналаар Музейн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 50
Бүгд: 109
54.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

20.Байнгын хорооны саналаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 46
Бүгд: 109
57.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

21.Байнгын хорооны саналаар Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 47
Бүгд: 109
56.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

22.Байнгын хорооны саналаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 48
Бүгд: 109
56.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

23.Байнгын хорооны саналаар Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 49

Бүгд: 109

55.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

24.Байнгын хорооны саналаар Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 49

Бүгд: 109

55.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

25.Байнгын хорооны саналаар Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 46

Бүгд: 109

57.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

26.Байнгын хорооны саналаар Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 47

Бүгд: 109

56.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

27.Байнгын хорооны саналаар Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 49

Бүгд: 109

55.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

28.Байнгын хорооны саналаар Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 50

Бүгд: 109

54.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

29.Байнгын хорооны саналаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 45

Бүгд: 109

58.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

30.Байнгын хорооны саналаар Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 43

Бүгд: 109

60.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

31.Байнгын хорооны саналаар Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 43

Бүгд: 109

60.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

32.Байнгын хорооны саналаар Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 45

Бүгд: 109

58.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

33.Байнгын хорооны саналаар Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 49

Бүгд: 109

55.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

34.Байнгын хорооны саналаар Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 48
Бүгд: 109

56.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

35.Байнгын хорооны саналаар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 45
Бүгд: 109

58.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

36.Байнгын хорооны саналаар Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 46
Бүгд: 109

57.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

37.Байнгын хорооны саналаар Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 46
Бүгд: 109

57.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

38.Байнгын хорооны саналаар Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 46
Бүгд: 109

57.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

39.Байнгын хорооны саналаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 44
Бүгд: 109

59.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

40.Байнгын хорооны саналаар Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 43
Бүгд: 109

60.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

41.Байнгын хорооны саналаар Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 43
Бүгд: 109

60.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

42.Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 46
Бүгд: 109

57.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

43.Байнгын хорооны саналаар “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 45
Бүгд: 109

58.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

44.Байнгын хорооны саналаар “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 47
Бүгд: 109

56.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Нийтийн өмчийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороодод шилжүүлэв./16:17/

Уг асуудлыг 16 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Тав дахь асуудал буюу Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12-т заасны дагуу хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 36

Бүгд: 109

67.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Д.Амарбаясгалан: 2.Байнгын хорооны саналаар Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 37

Бүгд: 109

66.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 39

Бүгд: 109

64.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв./16:20/

Уг асуудлыг 16 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа дахь асуудал буюу Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал:

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “бүсэд” гэсний дараа “нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц барилга байгууламжаас бусад” гэснийг “бүсэд” гэсний дараа “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8-д зааснаас бусад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 43
Бүгд: 109
60.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Долоо. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын гишүүн Ж.Хунан, Б.Энхболд, Я.Цэлмүүн, Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүн Ш.Үнэнтөгс нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, С.Эрдэнэболд нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, О.Алтангэрэл, П.Сайнзориг, О.Батнайрамдал, С.Эрдэнэбат, Ж.Батжаргал, М.Нарантуяа-Нара нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./16:40/

Найм. “Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан судлаач У.Хосжаргал, Н.Цэрэндаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ц.Идэрбат нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./16:48/

Ес. “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, мөн хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн, Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, А.Ариунзаяа, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Монголбанкны Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт

явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./17:15/

Байнгын хороодын хуралдааныг дуустал 17 цаг 15 минутаас 18 цаг 25 минутад чуулганы нэгдсэн хуралдааныг завсарлуулав.

Арав.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2025.07.03-ны өдөр мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, А.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./18:38/

Арваннэг.Зарим Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар тус тус танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Төсвийн байнгын хорооны

даргаар Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 45
Бүгд: 109
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарыг улируулан сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 46
Бүгд: 109
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны даргаар сонгох саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул “Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай”, “Байнгын хорооны даргыг улируулан сонгох тухай” тогтоолуудыг баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай”, “Байнгын хорооны даргыг улируулан сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолуудын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолуудын эцсийн найруулгатай танилцлаа./19:24/

Уг асуудлыг 19 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Арав дахь асуудал буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “дээд хэмжээг” гэсний дараа “нэгэн зэрэг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 37
Бүгд: 109
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулга бүхий зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 40
Бүгд: 109
63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Долоо дахь асуудал буюу “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 39
Бүгд: 109
64.2 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 19 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Найм дахь асуудал буюу “Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар “Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 36
Бүгд: 109
67.0 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 19 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Ес дэх асуудал буюу “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 42

Бүгд: 109

61.5 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 19 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 11 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 58 минут үргэлжилж, 126 гишүүнээс 110 гишүүн хүрэлцэн ирж, 87.3 хувийн ирцтэйгээр 19 цаг 35 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. 66 гишүүн бүртгэгдэж, ирц 52.4 хувьтай байна. 2025 оны хаврын ээлжит чуулганы 7 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр нийт 11 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын чуулганаар Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын чуулганаар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Гуравдугаарт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Дөрөвдүгээрт, Нийтийн өмчийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Тавдугаарт, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна

Зургадугаарт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Долдугаарт, Төсвийн байнгын хорооны хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг хийсний дараа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Наймдугаарт, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Есдүгээрт төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Аравдугаарт, зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэнэ.

Арваннэгдүгээрт, Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл нь хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Нэгдүгээрт, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд;

2.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэг нарын 13 гишүүн 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлснийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд;

3.Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас 2025 оны 7 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд тус тус хуваарилсан.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Улсын Их Хурлын чуулганаар Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын

Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Одоо Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд санал хураалтад бэлэн болсон байна. Санал хураалт.

1.Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт

Санал хураалтад оролцсон гишүүдийн 63.2 хувь нь дэмжиж, яаралтай хэлэлцэхийг дэмжлээ.

Төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалд оръё.

Улсын Их Хурлын чуулганаар эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг төслүүдийг өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол, Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдөр Засгийн газар 1/94 дугаартай албан бичгийг ирүүлсэн.

Одоо Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахаар байгаа.

Энэ өмнө нь яаралтай хэлэлцэхээр Ерөнхий сайдаас санал ирүүлсний дагуу яаралтай хэлэлцэх эсэхээр санал хураагаад тухайн үед дэмжигдээгүй. Тэгээд Засгийн газраас энэ тухайн хуулийн заалтыг үндэслээд ахиж хүсэлт ирүүлсэн.

Тэгээд энэ нь өөрөө бас Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн тодорхой зохицуулалтаар зохицуулагдаж байгаа гэж надад Ерөнхий нарийн бичгийн дарга тайлбар өгсөн. Энэ гишүүдийн бас нэг эргэлзээ байгаад байгаа дээр Баасандорж дарга тодорхой тайлбар өгөх үү? Өмнө нь нэг удаа хураагаад яаралтай хэлэлцэх эсэхээр хураагаад дэмжигдээгүй. Тэгээд дахиж Засгийн газраас Ерөнхий сайдаас хүсэлт ирсэн. Санал хураалт явуулах шаардлага үүссэн. Тэгээд Баасандорж дарга энэ дээр тайлбар өгье. 1 дүгээр микрофон.

Б.Баасандорж: Улсын Их Хурлын дарга, гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн. Энэ хуулийн хэлэлцэх эсэхийг Байнгын хороо 7 дугаар сарын 2-ны өдөр хэлэлцээд дэмжсэн. Чуулганаар хэлэлцэх эсэхийг 7 дугаар сарын 3-ны өдөр хэлэлцэх эсэхийг хийж дэмжсэн байгаа. Энэ хэлэлцэх эсэхийг дэмжсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газраас дахин хүсэлт ирүүлсэн. Засгийн газрын 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн ЗГ 1/94 тоот албан бичгээр хүсэлт хүргүүлэх тухай гээд энэ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу 33.1 дэх хэсэгт заасны дагуу энэ Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлж өгөөч ээ гэдэг хүсэлтийг ирүүлсэн байгаа.

Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль дээр энэ зохицуулалтыг хийсэн байгаа. Та бүхэн 33 дугаар зүйлийг бол мэдэж байгаа байх. Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлд Улсын Их Хурлын даргын эрх үүргийг зохицуулсан байгаа. Үүн дээр 13.1.6 дээр Ерөнхий сайдаас гаргасан хүсэлтийг үндэслэн хууль тогтоомжийн төслийг баталсан тов дараалал харгалзахгүйгээр чуулганы хуралдаанаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ ээ. Өөрөөр хэлбэл Ерөнхий сайдаас хүсэлт ирүүлсэн учраас гишүүд маань дахин хүсэлт ирүүлсэн учраас Улсын Их Хурлын гишүүд маань олонхоороо энэ асуудлыг яаралтай хэлэлцэх үү, үгүй юү гэдгийг шийдвэрлэгдэнэ ээ. 33 дугаар зүйлд заасан дэгийн дагуу.

Д.Амарбаясгалан: АН-ын бүлэгт үг өгье. Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Түрүүчийн 7 хоногт энэ хууль дээр яаралтайгаар хэлэлцэх эсэх дээр Улсын Их Хурал дэмжээгүй. Тэгээд ердийн горимоор хэлэлцэж байгаа. Ердийн горимоор хэлэлцэж байх процесс дунд дахиад хүсэлт ирээд, дахиад яаралтайгаар хэлэлцье гэдэг санал хураалт хэрвээ явах юм бол энэ практик тогтох гэж байна. Ямар ч хуулийг ердийн горимоор хэлэлцэж байх явц дунд нь дахиад яаралтай горим руу шилжүүлж болдог тийм жишиг тогтох гэж байна. Тэгээд ийм жишигтэй байх юм уу, үгүй юм уу. Энэ жишиг тогтвол бусад дараа дараагийн хуулиуд дээрээ адил хэмжээнд хэрэглэгдэх үү, үгүй юү гэдгээ нэг мөр болгоорой. Тэгэхгүй дабль стандарт тогтоно шүү. Ер нь Засгийн газар Засгийн газарт Улсын Их Хурал 1 удаа л хариу өгдөг байх ёстой. Улсын Их Хурлыг дахин дахин ингэж оролддог. Улсын Их Хурал дахин дахин өөрөө өөрийнхөө гаргасан шийдвэртэй холбогдуулж эргэж буцдаг байх юм бол энэ парламент гүйцэтгэх эрх мэдэл хоёрын чинь тэнцэл алдагдана шүү гэдгийг дахин сануулж хэлье.

Цаашид яг ийм жишиг тогтох юм уу. Эрүүгийн хууль өөр бусад хууль дээр ердийн горимоор явж байхад Засгийн газар гэнэт маргааш нэг хүнийг шийдэх хэрэгтэй байна, эсвэл юу гэдэг юм маргааш нэг ийм асуудлыг шийдмээр байна гэдэг байдлаар энгийн процесс дотор Улсын Их Хурлын хурал дахь дэгийг өөрчлөх хэмжээний ийм эрх мэдэлтэй хүчтэй байх ёстой юм уу гэдэг асуудал хөндөгдөж байгаа шүү. Ард нь хэлэлцүүлэг, ард нь судалгаатай асуудалд хандах олон улс олон нийтэд энэ чинь Улсын Их Хурал бол нэг хүнд зориулж шийдвэр гаргадаггүй. Дандаа нийтэд зориулсан шийдвэр гаргадаг. Тэгээд нөгөө бушуу туулай борвиндоо баастай гэдэг шиг юм болох вий гэдэг дээр болгоомжилж хэлж байна.

Д.Амарбаясгалан: Юу яая даа. Баасандорж дарга тодорхой хуулийн тайлбаруудыг бэлд. 13 цагаас даргын дэргэдэх зөвлөл зарлая. Даргын дэргэдэх зөвлөл дээр бас энэ хуулийн тайлбар, Улсын Их Хурлын тухай хууль болон Дэгийн тухай хуулийн тодорхой заалтуудтай холбоотой асуудлаар дэлгэрэнгүй ярилцах нь зүйтэй байх. Ер нь бол Их Хурлын тухай хуулиараа аливаа хуулийн төслийг хэлэлцүүлгийн аль ч шатанд Ерөнхий сайдын зүгээс хэлэлцүүлгийн хэлбэр горимыг өөрчлүүлэх санал хүсэлт ирүүлэх боломжтой гэсэн нэг ийм хуулийн заалт болбол Улсын Их Хурлын тухай хуулийн 13.6-гаар тиймээ ийм эрх бол Ерөнхий сайдад бас байгаад байгаа. Тэрийг нь оруулж санал хураалгах үүрэг нь бас Улсын Их Хурлын даргад бас байгаад байгаа ийм талтай.

Тэгэхээр 13 цагаас Баасандорж дарга аа, Даргын дэргэдэх зөвлөлийг зарлаж хуралдуулаад яг энэ асуудлаар нэгдсэн ойлголтод хүрсний дараа санал хураалтыг явуулъя аа.

Дараагийн асуудал руу оръё.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ням-Осорын, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт танилцуулна аа. Индэрт урьж байна. Эдийн засгийн форум дээр Учрал сайд ажиллаж байгаа юм байна. Ажлын хэсгийг оруулъя.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Тус хуулийн төсөлд нэгдсэн төсвийн 2025 оны тэнцвэржүүлсэн орлогыг 3.3 их наяд төгрөгөөр, нийт зарлагыг 1.9 их наяд төгрөгөөр тус тус бууруулахаар тусгасан. Нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахтай уялдан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026-2027 оны төсвийн төсөөлөл өөрчлөгдөх улмаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2027-2028 оны төсвийн хүрээний төсвийн төсөөллийн тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулах шаардлага үүсээд байна аа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг 2025 оны 4 дүгээр сард боловсруулах үед Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын

таамаглалд нүүрсний үнийг 2025 онд 85 ам.доллар, 2026 онд 88 ам.доллар, 2027 онд 92 ам.доллар, 2028 онд 96 ам.доллар байх таамаглал ирүүлсэн.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийг боловсруулахдаа тухайн үеийн олон улсын зах зээлийн нөхцөл байдал мэргэжлийн шинжээчдийн зарласан үнийн төсөөлөл зэргийг харгалзан нүүрсний үнийн төсөөллийг тус зөвлөлөөс ирүүлсэн төсөөллөөс бууруулж, 2025, 2026 онд 80 ам.доллар, 2027, 2028 онд 77 ам.доллар байхаар тус тус тооцсон. Гэсэн хэдий ч 2025 оны 4 дүгээр сард сэргэж эхэлж байсан уул уурхайн биржийн арилжааны идэвхжил 5 болон 6 дугаар саруудад эргэн саарч, нүүрсний үнэ үргэлжлэн буурч, 2025 оны эхний 5 сарын байдлаар нүүрсний дундаж үнэ 72 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 40 орчим хувиар буурахын зэрэгцээ эдийн засгийн өсөлт 2025 оны эхний улиралд 2.4 хувь болж саараад байна аа.

Цаашид дунд хугацаанд төсвийн орлого бидний төсөөлснөөс бага байх эрсдэл өндөр байна аа. Тухайлбал ОУВС нүүрсний үнийг 2025 онд 68 ам.доллар, 2026 онд 73 ам.доллар, 2027, 2028 онд 72 ам.доллар байх төсөөллийг зарлаад байна. Энэ хүрээнд макро эдийн засгийн болон төсвийн төлөв байдал, цаашдын хандлага, төсөөлөлд үндэслэн 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага үүссэн ч тус хуульд 2025 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хойш өөрчлөлт орсон тохиолдолд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт зааснаас заасан хязгаарлалтаас шалтгаалан Төсвийн тухай хуульд заасны дагуу Засгийн газар төсвийн төслийг .9 сарын 1-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх боломжгүй нөхцөл үүсэхээр байна аа.

Иймд макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал дунд хугацааны эдийн засгийн болон төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөлд үндэслэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг бууруулах өөрчлөлт орсонтой холбоотойгоор жилийн төсөв болон төсвийн тодотголыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэн батлахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт заасан хязгаарлалт хамаарахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Та бүхэнд танилцуулж байна аа.

Сүүлийн 10 жилд зөвхөн нэг удаа буюу 2015 онд экспортын түүхий эдийн үнийн уналттай байсан жилд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлагын хэмжээг нэгэн зэрэг бууруулах байдлаар төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилж байсан бол бусад жилүүдэд нь орлого, зарлагыг нэмэгдүүлэх өөрчлөлт хийж байсан гэдгийг энд тодотгон хэлье ээ.

Уг хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг бууруулах өөрчлөлт орсонтой холбоотойгоор жилийн төсөв болон төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх батлахад энэ хуулийн 7.5-д заасан хязгаарлалт хамаарахгүй байх агуулгатай заалтыг нэмэхээр тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар жилийн төсөв болон төсвийн тодотголыг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нөхцөл бүрэлдэх юмаа.

Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр ирүүлснийг Улсын Их Хурлын 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэж, Төсвийн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Хууль санаачлах дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг бууруулах өөрчлөлт орсонтой холбоотойгоор жилийн төсөв болон төсвийн тодотголлын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх батлахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5-д тусгагдсан хязгаарлалт хамаарахгүй байхаар хуулийн төслийг боловсруулсан байна аа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Батжаргал Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд орлогын доод хязгаар, зарлагын дээд хязгаар буурсан болон урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал үүссэн шалтгаанаар өөрчлөлт оруулж болох эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгагдсан төсвийн тусгай шаардлагыг өөрчлөх, хэрэгжих нөхцөл хугацаанд өөрчлөлт оруулахад холбогдох хуулиудын шаардлагад нийцэж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно. Монгол Улсын Их Хурлын гишүүн Батжаргал төслийг дэмжиж байна. Гэхдээ тодорхой давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэж хязгаарлалт тогтоох нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл улсын төсөв батлахдаа төсвийн орлогыг өөдрөгөөр төсөөлснөөс болж төсвийн орлогын дүн доод хязгаартаа хүрэхгүй нөхцөл байдал үүсэхээр байгааг анхаарч, төсвийн сахилга батыг баримталж, эдийн засаг, төсөв санхүүгээ сайтар төлөвлөж ажиллах нь зүйтэй гэх талаар үг хэлсэн байна аа.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаар Төсвийн байнгын

хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна аа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Лангааны Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа. Хариулт. За дарааллын дагуу Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар байнгын хорооны хуралд орсон байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн алга байна. Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Өглөөний мэнд хүргэе ээ.

Би нэг 2, 3 асуултуудыг асууя. Нэгдүгээрт нь энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль бол Монгол Улсын төсвийн сахилга батыг хангах, төсвийн бодлогоор дамжуулж хэрэгжиж байгаа энэ сангийн бодлогын зорилго, зорилт стратегийн хэрэгжилтийн үр дүнг хангахад чиглэсэн ийм гол хууль аа. Энэ хууль дотор байгаа энэ нэг заалт байгаа юм. Энэ заалтыг бол 2 жилийн өмнө өөрчлөлт оруулсан. Өөрөөр хэлбэл төсвийн төсөл өргөн барьснаас хойш 3 сарын хугацаанд дахиж өөрчлөлт өргөн барьж болохгүй ээ гэсэн ийм л хатуу заалтыг 2 жилийн өмнө оруулаад, 2 жилийн хугацаанд бэлдэж байгаад энэ оны 1 сарын 1-ээс эхлээд хэрэгжсэн хууль. Хэрэгжээд 6 сар өнгөрч байгаа. Энэ 6 сарын хугацаанд ингээд 2 дахь удаагаа зөвхөн яг энэ заалт дээр өөрчлөлт орж ирж байгаа юм. Яг энэ заалт дээр өөрчлөлт орж ирж байгаа. Тэгээд энэ хэдхэн сар хүрэхгүй хугацааны өмнө сар ч хүрээгүй байна даа. Энэ хоёр 7 хоногийн хугацааны өмнө яг энэ заалт дээр бас өөрчлөлт орсон. Одоо ингээд дахиад хоёр 7 хоногийн дараа дахиад ингээд өөрчлөлт орж ирж байна л даа. Тэндээс юу харагдаж байна гэхээр зэрэг Засгийн газрын сайд нар нь энэ холбогдох тухайн хуультай холбоотой өөрсдийн эрхлэх асуудалтай холбоотой заалтаараа ингээд ээлж дараалаад ингээд хуулийн өөрчлөлт оруулаад ирээд байх юм уу, нөгөө Засгийн газрын чинь нэгдмэл байдал нь хаачсан бэ гэдэг ийм асуудал үүсэж байгаа юм. Энэ дээрээ бас тодорхой хариулт өгөхийг хүсэж байна.

Хоёрдугаарт нь, Учрал сайд байгаа учраас бас нэг асуухад энэ Монгол Улсын энэ төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу батлагдсан өчигдөр, уржигдархан батлагдсан энэ хуулийн дагуу эдийн засгийн чинь өсөлт 5 хувь руу буулгана гэдэг ийм заалт орж ирсэн. 8 хувь байж байгаад 5 хувь руу болгоно гэдэг тэр. Миний хувьд энэ 5 хувиа ч гэсэн энэ жил хангахад аягүй хүндрэлтэй байгаа. Яагаад гэвэл 1 дүгээр улирлын эдийн засгийн өсөлт 2.4 хувьтай гарсан. Аль ч сүүлийн 5 жил, 10 жилийн эдийн засгийн энэ манай Монгол Улсын эдийн засгийн энэ өсөлтийн тооцоог аваад үзэхэд 1 дүгээр улирал дээрээ дандаа өндөр өсөлттэй

гардаг. Тэр нь дандаа ингээд жилийн турш ингээд хадгалагдаж явдаг. Гэтэл 1 дүгээр улирал нь 2.4 хувь гарчихаар энэ нь яг жилийн эцэст 5 хувь гарна гэдэг эргэлзээ нэг тун бага байгаа юмаа.

Дээрээсээ энэ гадаад нөхцөл байдлын асуудал байна. Оюу Толгой дээр энэ 8.9 гишүүн гарын үсэг зурчихсан байгаа. Онтрегийн хөрөнгө оруулалтын гэрээг ашиглахтай холбоотой асуудал дээр Оюу Толгой дээр үргэлжилсэн олон жил явсан маргааны асуудлууд байгаа. Энэ асуудлыгаа бид нар шийдэж чадахгүй бол эдийн засгийн өсөлтийг 5 хувьд хүргэхэд Оюу Толгой гол нөлөө үзүүлнэ гэсэн энэ нөлөөлөл чинь явж чадах уу. Уул нь энэ 8.9 гишүүний гарын үсэг зурсныг Засгийн газар ашиглаад богино хугацаанд Оюу Толгойтой ойлголцох асуудлаа хийх ёстой. Энэ дээр одоо ямар бодлого явж байгаа вэ?

Гадаад нөхцөл байдлыг юу гэж тооцож байгаа вэ? Трампын 4 сарын 9-нд гаргасан тариф чинь 3 сарын хугацаагаар хойшилсон. Одоо 7 сарын 9-өөр дахиад нэг шинэ сюрприз олон улсад гарч ирэх байх л даа. Энийгээ юу гэж тооцож байгаа вэ? Дээрээс нь энэ төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11.3 дээр байгаа юмаа. Гол нэрийн нэр төрлийн эрдэс баялгийн бүтээгдэхүүнийг энэ тэнцвэржүүлсэн үнээр тооцно гээд. Энэтэй чинь холбоотой тэнцвэржүүлсэн орлогоо тооцохоор зэрэг төсвийн орлого чинь өндөр гарч ирээд байна л даа. Тэгэхлээр энэ төсвөө тогтвортой байлгахын тулд бид нар энэ тооцоолол хэрэгжилд хэрэглэдэг энэ үнийгээ нэг тогтвортой авч тооцох ёстой. Тэгэхээр энэ заалт дээрээ ямар бодлого байгаа юм бэ? Уул нь би энийгээ өөрчлөөд, яг энэ тогтворжуулсан төсвийг тэнцвэргүй болгоод байгаа энэ үнэ тооцдог аргачлалыгаа өөрчилсөн бас ийм заалтыг давхар оруулж ирж болоогүй юм уу гэсэн ийм 3 дахь асуулт байгаа юмаа.

Дөрөвдүгээрт нь, энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар бид нар төсвийн орлого зарлагыг зааж өгдөг боловчиг Төсвийн тухай хуулиар бид нар энэ Сангийн яам Төсвийн ерөнхийлөн захирагчдын жилийн төсвийн хязгаарыг батлаад байгаа юм. Хэчнээн бид нар жилийн төсвийн хязгаарыг батлаад байгаа боловч Сангийн яам Төсвийн ерөнхийлөн захирагчдын энэ сайд нарын жилийн төсвийн хязгаарыг баталдагтай холбоотой...

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Заяабал гишүүний асуултад хариулъя аа.

Энэ төсвийн тогтвортой байдлын хууль бол энэ төсвийн сахилга бат хариуцлагыг нэмэгдүүлэхэд маш том шинэчлэл авчирсан хууль. Ингээд Төсвийн тогтвортой байдлын хууль энэ оноос хэрэгжиж эхлээд бид анх удаа хэрэглэлээ л дээ. Тэгэхээр өнгөрсөн жил 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад яг энэ одоо тооцож болохгүй урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал тогтоогдоогүй байсан учраас нүүрсний үнийг 105 доллароор тооцоод нэлээн өөдрөгөөр ингээд төсөөлсөн. Гэсэн хэдий ч ер нь нэг 5 сарын байдлаар бол нүүрсний үнэ 3.9 хувиар буурчихсан. Ингээд ирэх оны төсвийн хүрээний мэдэгдэл буюу 2025 оны 5 дугаар сарын 30-нд Их Хурлаас батлагдсан Төсвийн хүрээний мэдэгдэл дээр бид бол ирэх жилийн нүүрсний үнийг нэг 80 доллароор буюу тухайн үед Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нэг 88 доллароор санал илгээсний дараа энэ нүүрсний төсөөллийнхөө тэр дундаж үнийг бол нэг 80 доллароор бодоод, 5 сарын 30-нд батлагдсан баталсан. Гэсэн хэдий ч энэ экспортын голлох бүтээгдэхүүний үнэ бол яг энэ олон улсын геополитикийн мөн одоо энэ Ойрх

Дорнодын мөргөлдөөн гээд олон асуудлаас болоод энэ нүүрсний үнэ өдөр өдрөөр хэлбэлзэж байна.

Тэгэхээр бид ирэх оны төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөхгүйгээр ирэх онд хэрвээ .9 дүгээр сарын 1-нд төсвөө оруулах юм бол бид ямар байдалд очих вэ гэвэл нэлээн өөдрөг төсөөлөлтэй нүүрсний үнийг 80 доллароор бодчихсон, эдийн засгийн өсөлт 8 хувь байна ч гэдэг юм уу ийм байдлаар ингээд тооцоод явах гэхээр ийм ашигтай төсөв оруулж ирэх бололцоо бол байхгүй.

Тийм учраас Төсвийн тогтвортой байдлын хуулийг харахаар 7.5 дээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл баталснаас хойш 3-аас доошгүй сарын хугацаанд тухайн жилийн төсвийн төсөл тодотголын төслийг өргөн мэдүүлэх батлахыг хориглоно оо гээд 5 дугаар сарын 30-ны төсвийн хүрээг энэ 3 сард хамааруулж авч үзэх юм шиг ийм нөхцөл байдал бол үүсчхээд байгаа юм. Эдийн засгийн өсөлтийн хувьд бол 2025 оны ер нь ирэх жилийн төсөв эдийн засгийн өсөлтийг бол нэг 6 хувь, 2026 онд 5..9 хувь байна гэдэг ийм албан бичгээр бол Монгол банк бидэнд бол ирүүлсэн. Зүгээр валютын сан бол нэг 6 хувь гэж үзэж байна. Дэлхийн банк нэг 6.3 хувьтай, Азийн хөгжлийн банк нэг 6.6 хувьтай байна гэж ингэж эдийн засгийн төсөөллийг бол авч үзэж байгаа.

Тийм учраас бид нар бол мэдээж богино хугацаандаа энэ уул уурхайн бүтээгдэхүүн тэр дотроо нүүрснээс хамааралтай эдийн засгаа цаашдаа өсөлтийг хангахын тулд хөдөө аж ахуйн салбарыг бол голлож дэмжих бодлогуудыг барих ёстой. Дээрээс нь зэсийн олборлолт бол бас харьцангуй сайн байгаа. Тэгэхээр энэ зэсийн олборлолт сайн байгаатай...

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Н.Учрал: Тэгээд зэсийн олборлолт сайн байгаатай холбогдуулаад эдийн засгийн өсөлтөд бол тодорхой нөлөө үзүүлнэ гэсэн ийм төсөөлөлтэй бол байгаа. Сая Заяабал гишүүний хэлж байгаа тэр Онтретой холбоотой хэлэлцээрүүд, Засгийн газар энэ Засгийн газар дээр хэрэгжүүлэх шаардлагатай нөгөө мега төслүүд гээд аваад үзэхээр Засгийн газар дээр үүсгээд байгаа өр төлбөрүүдийг барагдуулах, энэ хэлэлцээрүүдийгээ дуусгах ажил руу бол бид голлон анхаарах ёстой. Тийм учраас энэ Онтретой холбогдуулаад Засгийн газар хэлэлцээрт орно. Тэгээд Их Хурлын гишүүдийн түр хороотой хамтраад ажиллаад үр дүнд хүрнэ ээ л гэдэг ийм байдалтай байгаа. Зүгээр өмнө нь бол Хэрэг эрхлэхийн сайдаар ажиллаж байхдаа эхний хэлэлцээрүүдийг эхлүүлж байсан. Тэгэхээр одоо ч гэсэн Эдийн засгийн сайдын хувьд үүнд бас л голлож анхаараад хэлэлцээрийг үр дүнд хүргэхийн төлөө ажиллана гэдгээ хэлье тийм.

Д.Амарбаясгалан: Батжаргалын Заяабал гишүүн тодруулж асууя.

Б.Заяабал: Би тодруулга асуултаа голчлон Төсвийн тогтвортой байдлын зөвлөл рүү хандаж асууя гэж ингэж бодож байна. Тэгэхлээр би ингэж бодож байгаа юм. Төсвийн тухай хуулиар энэ төсвийн ерөнхийлөн захирагчдын жилийн төсвийн хязгаарыг Сангийн яам хүлээж аваад Засгийн газраар орж батлаад байна л даа. Тэгэхлээр би энийг юу гэж хараад байгаа вэ гэхээр зэрэг энэ Засгийн газар Улсын Их Хурлын гишүүдийн энэ Улсын Их Хурлын бүрэн эрх рүү халдаад байгаа юм биш үү гэдэг ийм байдлаар харж байгаа юм. Уул нь Улсын Их Хурлаас бид нар энэ төсвийн тогтвортой байдлын хуулийн дагуу улсын жилийн төсвийн орлого, зарлагын

хэмжээг л баталж өгөөд байдаг. Гэтэл Засгийн газар өөрсдөө ингээд дур мэдээд Засгийн газрын сая байнгын хороонууд дээр ч гэсэн Засгийн газрын юу Их Хурлын гишүүд хүртэл нэг сайдын багцаалсан мөнгийг хасаад нөгөө сайдын багц руу шилжүүлэхтэй холбоотой ингээд асуудлууд үүсгээд байгаа юм. Тэгээд энэтэй холбоотой ер нь энэ зарлагыг нь тухайн ДНБ-ээр нь, салбараар нь хувиар нь зааж өгвөл ямар вэ гэдэг дээр нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь танайх энэ энэ удаагийн хуулийг энэ...

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд нэмж хариулья.

Н.Учрал: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс бидэнд энэ хуультай холбогдуулаад хуулийг өөрчлөхдөө нэг удаагийн шинжтэйгээр ч юм уу, ийм нарийвчилсан зохицуулалтуудыг хийж энэ удаа батлах нь зөв өө гэдэг байдлаар санал ирүүлсэн. Тэгэхээр яг одоо бол энэ уул уурхайн бүтээгдэхүүний үнэ ийм хэлбэлзэлтэй байгаа үед нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого нийт зарлагын хэмжээг аль алиныг нь бууруулсан тохиолдолд төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилж, түүнийгээ дагалдуулж ирэх оны төсвийг барих ийм гарцыг бол хуулиар нээж өгөх нь цаг үеийн шаардлагатай байна. Тэгээд сүүлийн 10 жилд зөвхөн нэг л удаа буюу 2015 онд экспортын түүхий эдүүдийн үнэ уналттай байсан жилд орлого, зарлагыг аль алиныг нь бууруулж байсан. Тэгэхээр энэ жишгээрээ бид ажлын хэсэг дээр ярилцаад явах нь зөв байх аа гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хариулт өгье. 3 дугаар индэр.

Ж.Дэлгэрсайхан: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Дэлгэрсайхан. Заяабал гишүүний эхний асуултад бол бид нар санал нэг байна. Учир нь Улсын Их Хурлаас төсвийн хязгаарыг баталж байгаагийн дагуу ерөнхий хязгаарыг баталж байгаа боловч хязгаарууд хэтрэх, дээрээс нь салбар хооронд шилжүүлэг хийгдэж байгаа байдал нь ерөнхийдөө төсвийн бодлогыг алдагдуулж байгаа хэрэг мөн гэж үзэж байна. Тийм учраас цаашдаа Эдийн засаг, хөгжлийн яамнаас ч юм уу, бид төрийн эдийн засгийн бодлогыг боловсруулсны үндсэн дээр тухайн салбарт ямар хэмжээний төсвийг зарцуулах ёстой вэ гэдгийг нь хатуу зааж өгөх нь төсвийн бодлогыг зөв хэрэгжүүлэхэд илүү их нэмэртэй зүйл болно гэж хэлж байна.

Хоёрдугаарт манай зөвлөл энэхүү хуулийн өөрчлөлт дээр харьцангуй эсрэг байр суурьтай байгаа. Энэ дээр гол нь 6 сарын 25 болон одоо орж ирж байгаа хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн орлого зөв төлөвлөх, орлогыг бид нар төлөвлөснийхөө дагуу түүндээ нийцсэн зарлагыг төлөвлөх энэхүү үндсэн зарчимд тодорхой хэмжээний ухралт болж байна гэж үзэж байна. Иймээс нэг удаагийн шинж хэрвээ баталбал нэг удаагийн шинж чанар...

Д.Амарбаясгалан: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн баригдаж орж ирсэн. Төсвийн байнгын хороон дээр хэлэлцэх эсэхийг нь хэлэлцэх үед тодорхой асуулт асууж, саналаа илэрхийлсэн. Үнэхээрийн амьдрал үргэлжилж байгаа юм болохоор урьдчилан таамаглагдах боломжгүйгээр орлого, зарлага хоёр хоёулаа зэрэг буурч байгаа энэ тохиолдолд яах юм бэ гэдэг асуудал

байгаад байгаа юмаа. Тогтвортой байдлын тухай хууль бол макро түвшиндээ энэ улс орны эдийн засаг төсвийнхөө үндсэн үзүүлэлтүүдийг тогтвортой дунд хугацаанд нь барих замаар эдийн засгийнхаа өсөлтийг дэмжих ийм л үндсэн агуулгатай хууль. Гэтэл хуулийн үндсэн үзэл санаанд тулгуурлаад бодит байдлаас зөрсөн байдлаар ирэх оныхоо төсвийг боловсруулах нөхцөл байдлыг Засгийн газарт үүсгэхэж таарахгүй байгаад байгаа. Хэрэв зэхээ ингэж төсөв боловсрогдох юм бол орлогоо их өөдрөгөөр гэдэг юм уу өндөр төлөвлөнө. Дагуулаад зарлагын асуудал гарч ирнэ. Гэтэл хэрэгжих явцдаа энэ улс орны эдийн засаг нийгмийн амьдралд нэлээн тийм эрсдэлийг авчрах ийм нөхцөл байдал харагдаад байгаа.

Тийм учраас би юу гэж дахиж тодруулах гээд байна гэхээр зэрэг энэ гол нэр төрлийн эрдсүүдийн үнэ дэлхийн зах зээл дээр унаж байна, буурч байна. Энэ нь цаашаа тогтвортойгоор нэг хэсэг хугацаанд хадгалагдаж болох нь ээ гэж олон улсын байгууллагууд, судлаачид төсөөлөөд байгаа. Тэгэхдээ бид хэдийн ярьж байгаа төсвийн хүрээний мэдэгдэл энэ онд биш ирэх онд хэрэгжих төсвийнхөө асуудлыг зохицуулж байгаа хүрээ шүү дээ. Тийм учраас ирэх онд энэ байдал яг баттай хадгалагдана гэсэн тийм тооцооллыг манай дотоодын судалгааны гэдэг юм уу, эрх бүхий байгууллагууд, олон улсын байгууллагуудаас хийсэн төсөөлөл, таамаглал, энэ хоёрын хоорондын нийцэл энэ тэр ер нь ямархуу байдалтай байна аа? Энэ дээр нэг тодорхой хариу авмаар байна.

Хоёр дахь асуудал одоо орж ирчхээд байгаа хуулийн төслийг анхны хэлэлцүүлгийнх нь явцад жоохон сайжруулах шаардлага байна гэж ингэж хараад байгаа. Одоо байж байгаа юугаа төслөөрөө бол магадгүй мөнхийн хэрэглээний нэг тийм цонх үүсгэхэж мэдэхээр ийм заалт байгаад байгаа. Энүүнийг бол ямарваа нэгэн байдлаар таамаглах боломжгүй, давтагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас тэр орлого зарлага хоёр чинь зэрэг буусан тохиолдолд л ашиглагддаг байдлыг нь хангаж өгсөн тийм цоож хязгаарлалттай заалт болгож л оруулах ёстой болов уу. Энэ дээр төсөл өргөн баригч ямар байр суурьтай байна? Нэг ийм 2 асуудал дээр тодорхой хариулт авъя аа.

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Энэ 2025 оны төсвийн төсөөлөл энэ оны төсвийг боловсруулахдаа 2024 онд батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлд суурилж энэ оны төсвийг баталсан. Тухайн үед бол 2024 оны 3 сард, 2025 оны өсөлтийн төсөөллийг нэг 6.7, доод нь 3.1, 2025 оны нүүрсний үнийг 107 болон 132 ам.доллар байхаар 2 хувилбартай. Экспортын биет хэмжээг 50 сая тонн гэж тухайн үед Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлж байсан. Ингээд яг энэ ирүүлсэн санал дээр нь үндэслээд 2025 оны эдийн засгийн төсөөллийг нэг 8 хувь, нүүрсний үнийг 105 доллар, биет хэмжээг нэг 83.3 сая тонноор нь аваад, 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулж, энэ төсвийн хүрээний мэдэгдэлд суурилаад ирэх энэ оны төсвийг боловсруултал 5 дугаар сарын байдлаар буюу эхний улиралд гэхэд нүүрсний үнэ 3.9 хувиар буурчихсан. Ингээд бид нар төсвийн тодотголыг өргөн барихад төсөв бараг 3.3 их наядаар тасраад ингээд 2.1 орчим их наядаар бид нар хэмнэлт хийгээд, ингээд төсвийн тэнцэл дээр бол тодорхой алдагдал тооцоод энэ төсвийн тодотголыг бид Их Хурлаар баталж байгаа. Гэтэл 5 дугаар сарын 30-нд ирэх оны төсвийн хүрээгээ баталчихсан байгаа Төсвийн хүрээгээ хартал бас эдийн засгийн өсөлт нь 8 хувь гээд үзчихсэн байхад яг Валютын сан ч бай, Дэлхийн банк ч бай бол ер нь нэг 6, 6.3, 6.6 орчим өсөлттэй байна гээд үзчихсэн.

Монгол банк сүүлийн байдлаар бид нарт 6 хувь гээд өгчихсөн. Гэтэл .9 дүгээр сарын 1-нд төсөв барихад, барих гээд ирэхээр бид нар яг энэ тоонд тохируулаад төсвийн тэнцлийн хувьд ямар нэгэн алдагдалгүй төсөв оруулна гэх боломжгүй болчихоод байгаа учраас ер нь ингээд нэг төсөөллүүдийг харахад цаашдаа бол экспортын орлого бол мэдээж буурна. Ийм төсөөллүүд бол дэлхийн байгууллагууд ч гаргаж байна. Тэгээд тэр Блүүмбергийн терминал дахь тэр 14 байгууллага бол нүүрсний үнийг нэг 13-30 хувиар буурна гэдэг ийм тооцооллыг бол гаргачихсан. Тэгэхээр бид төсвийн хүрээний мэдэгдлийг яг өнөөдөр ирэх оны төсвийн хүрээг батлах ч гэсэн цаг алдах магадлалтай болчихоод байгаа юм.

Тийм учраас ирэх оны төсвийг барихдаа төсвийн хүрээг нь тухайн цаг үеийн яг тэр экспортын голлох бүтээгдэхүүнийхээ үнийг тэр олон улсын байгууллагуудаас авч байгаад зөвөөр төсөөлөөд явах хэрэгтэй. Дээрээс нь эдийн засаг агшиж байгаа үед бол төсвийн бодлого бол өөрөө тэлэх ёстой гэдэг бодлогоо барьж байгаа учраас нөгөө зэсний, алтны үнэ өсөж байгаа. Худалдааны салбарыг үйлдвэржилт рүү явуулах энэ гэрээ хэлцлүүдээ урагшлуулах, хөтөлбөрүүдээ явуулах чиглэл рүү анхаарч агшиж байгаа бол тэлэх бодлого барина. Тийм учраас зөвхөн төсвийн тэнцлийг алдагдалтай биш алдагдалгүй биш тодорхой...

Д.Амарбаясгалан: Учрал сайд гүйцээж хариулъя.

Н.Учрал: Тэгэхээр тэр ирэх оны төсвийг барихдаа ч, төсвийн хүрээг барихдаа ч гэсэн бид нар тэр экспортын бараа бүтээгдэхүүнийхээ үнийн төсөөллийг харж байгаад бодитой, худлаа биш дахиж тодотгол хийх нөхцөл үүсгэхгүйгээр төсвийн хүрээгээ барихдаа тодорхой төсвийн тэнцлийн алдагдалтайгаар баталж байж яг ийм эдийн засаг агшиж байгаа үед бол нөгөө тэлэх бодлогоо авч хэрэгжүүлнэ. Тэгээд үүнд бол мэдээж л нөгөө гадаадын хөрөнгө оруулалт нөгөө төрөөс явуулаад байгаа зохицуулалт, хяналт шалгалтыг бууруулах, хувийн хэвшлийг дэмжих, баялаг бүтээгчдийг дэмжих энэ орон зайг нээж өгөх чиглэл рүү хандаж байж л тэр эдийн засгийн өсөлтийг тогтвортой авч явах, байгаа ажлын байрыг хадгалах зарчмаа хадгалах нь нэгдүгээр зорилт болохоос биш зөвхөн төсвийн тэнцлийг алдагдалгүй баталлаа гээд бол тодорхой өөрчлөлт гарахгүй. Зүгээр ингээд хумиад, хэмнээд байвал эдийн засагт тийм тогтвортой байдал үүсэхгүй ээ. Тийм учраас ирэх онд бол үүн дээр голлон анхаарна гэж хэлье ээ.

Д.Амарбаясгалан: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Тийм. Их Хурал бол энэ төсвийн зардлын тэлэлтийг хязгаарлаад бууруулах тухай их ярьж байгаа. Тэгэхээр энэ нөхцөл байдал өөрөө бараг биднүүсийн яриад байгаа, хүсэмжлээд байгааг хангуулахаар шахуу юм болж байгаа байхгүй юу. Тийм учраас гадаад нөхцөл байдал сайжраад, орлого нэмэгдвэл сайн л биз дээ. Тийм учраас би орлогын доод хязгаар, зардлын дээд хязгаар 2 нь хоёулаа буурч ирэх онд төлөвлөгдөхөөр тооцогдож байгаа энэ үйл явцыг нь хангасан төсвийн хүрээг нь ийм байдлаар өөрчлөх боломжийг нь Засгийн газарт өгчих ёстой юм байна. Тэртээ тэргүй бид орлогын доод хязгаар, зардлын дээд хязгаар хоёрыг нь баталж өгөөд, төсвийн тэнцлийнх нь асуудлыг тодорхой тоогоор хязгаарлаад өгчхөж байгаа учраас гадаад нөхцөл байдал сайжирвал тодорхой хэмжээний хуримтлал гэдэг юм уу юм үүсэх тэрүүнийгээ хэрхэн зарцуулах вэ гэдэг асуудлаа Их Хурал дээр орж ирж яригдах учраас...

Д.Амарбаясгалан: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Мэдээж ирэх оны төсвийг боловсруулахдаа бид нар төсвийн тогтвортой байдлын хуулийн тусгай шаардлагуудыг бол хангах ёстой. Тэгээд бид их олон жил яг нөгөө экспортын орлого нэмэгдэж байгаа үедээ хумьж чадаагүй, хуримтлал үүсгэж чадаагүй. Тэгээд олохынхоо хэрээр үрээд байдаг. Нэг ёсондоо зарлага дээрээ тэр тусгай шаардлагуудыгаа барьдаггүйгээсээ болоод нөгөө орлого нэмэгдэж байх үед хумих бодлогоо хэрэгжүүлээгүйгээсээ болоод л яг ийм байдалд хүрсэн. Тийм учраас ирэх оны төсвийн хүрээ боловсруулахдаа тэр нь заавал төсвийн тэнцлийн алдагдалтай байх эсэх бол нэг их чухал биш. Төсвийн бодлого гэдэг бол өөрөө тэр алдагдалтай эсэхээс үл хамаараад цаашаа нийгэмд тэр ажлын байруудаа яаж хадгалж авч үлдэх вэ, өсөлтийгөө хэрхэн хадгалах вэ гэдэг зарчим руу л одоо хандах учраас төсвийн хүрээ ирэх оны төсөвтэй хамт төсвийн бодлогын хүрээнд бол авч хэрэгжүүлж орж ирэх нь бол би бас Батжаргал гишүүний хэлж байгаагаар зөв өө л гэж бас үзэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Уг нь энэ хуулийн маань хамгийн чухал зохицуулалт бол эрдэс баялгийн орлогоо нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх гэсэн уг нь хуулийн заалттай юм. Даанч энэ хуулийн хэрэгжилтийг нь хэзээ ч хэрэгжүүлж хангаж байгаагүй. Яагаад гэхээр энэ хууль батлагдсан цагаасаа хойш яг өнөөдөр 20 дахь удаагаа нэмэлт, өөрчлөлт орох гэж байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль өөрөө 20 дахь удаагаа батлагдсан цагаас орж байна гэдэг чинь төсөв 20 удаа тогтворгүй байсан буюу Засгийн газар төсвөө хэзээ ч зөв тооцоогүй ээ гэсэн үг.

Тийм учраас Төсвийн тогтвортой байдлын хуульд 20 дахь удаагаа өөрчлөлт орж байгаа юм. 20 дахь удаагаа батлагдсан цагаасаа хойш. Хамгийн тогтворгүй хууль болсон. Энэ хуулийн нэрэндээ огт зохицоогүй. Уг нь энэ цаад утга санаа нь төсвийн сахилга батыг л тогтвортой байлгах гэсэн утга санаа л даа. Тэгээд харамсалтай нь үе үеийн Засгийн газар энэ хуулийг баталсан цагаас хойш нэг ч удаа төсвөө зөв тооцож ирсэнгүй. Нэг ч удаа Төсвийн тогтвортой байдлын хуулийг биелүүлсэнгүй. Нэг ч удаа баталсан төсвийнх нь дагуу үйл ажиллагаа явуулж үзсэнгүй. Энэ бол сүүлийн 10 хэдэн жилийн Засгийн газрын хариуцлага.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гээд зөвлөл гаргадаг, санал дүгнэлт гаргадаг. Хэрвээ та бүхэн санаж байгаа бол 2025 оны улсын төсвийг батлах үеэр Сангийн сайд Жавхлан төсвийн тогтвортой байдлынхныг нэг хүний үгээр улс төр хийж байна, нэг хүний үгэнд орж байна. Та нар улс төржиж байна, улс төрждөг байгууллага болсон байна гээд шүүмжилж байсан. Яг энэ чуулганд энэ төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхнийг загнаад, микрофонгүй загнаад хэг ёг гээд хэрэлдээд сууж байсан. Яг тухайн үеийн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт дээр одоо та нарын сайд нарын яриад байгаа нөхцөл байдлыг бичсэн шүү сайд нар аа, Засгийн газрынхан. Яг бичсэн байсан шүү. Би сүүлийн 4 жилийн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг харьцуулж үзлээ. Та нар энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөө дүгнэлт санал дүгнэлтийг ёстой нохой хуцаж байна даа чинээ тоогоогүй. Яг энийг нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гэж бичсэн байна лээ шүү дээ.

Тийм учраас та нар 20 дахь удаагаа энэ Төсвийн тогтвортой байдлын хуулийг өөрчилж байгаа байхгүй юу. Сүүлийн төсвийн тодотголд ярьсан сүүлийн 14 хоногт төсвийн орлого чинь дахиад 1.1 наядаар тасрах эрсдэл үүсчихлээ. Намар дахиад

төсөв тодотгохгүй гэх гэдэг нөхцөл байдал үүсэх үү? Зөвхөн Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагуудын зардал 2020 оноос хойш хамгийн багадаа 2.3, хамгийн ихдээ 10.7 буюу 11 дахин дунджаар 7 дахин өссөн байна.

Зөвхөн Улсын Их Хуралд зардлаа тайлагнадаг байгууллагуудын урсгал зардал 7 дахин өссөн байна гэдэг чинь бид нар олж байгаа жоохон орлогодоо ханаад, зардлаа хэтэрхий их тавиад өнөөдрийн нөхцөл байдал үүсчихсэн гэсэн үг. Эхлэх хугацаа төсөвт өртөг нь тодорхойгүй 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэлд ороогүй, хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй, 2024 оны хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд огт тусгагдаагүй 342.6 тэрбум төгрөгийг төсөвлөөд түүнээсээ одоогоор 175 тэрбум төгрөгийг захиран зарцуулчихсан байна. Төсвийн алдагдал нэмэгдээд ирэхээр бид нар эргээд хувийн хэвшлээ л дарамталдаг, татвараар дарамталдаг, нийгмийн даатгалаар дарамталдаг, цаг хугацаандаа нийгмийн даатгал шимтгэл татвараа төлөхгүй бол дансыг нь хаадаг, үйл ажиллагааг нь боомилдог, хяналт шалгалт явуулдаг энэ байдал чинь хэрээс хэтэрлээ.

Хувийн хэвшил бол төсвийн алдагдлыг нөхдөг, тэдний буруу тооцоолсон тооцооллыг зөв болгохын тулд илүү татвар төлж дарамтлуулдаг ийм байгууллагууд бас биш ээ. Өнгөрсөн жилийн мөн онтой харьцуулахад ААН-үүдийн орлогын албан татвар 1 их наядаар тасарчихсан явж байгаа. Энэ юу вэ гэхээр бид нар эдийн засгийн тооцооллоо төсвөө буруу тооцоод байна аа л гэсэн үг. Татварын хууль дээр 30 гаран төрлийн татвар байдаг. МАН 2020 онд, 2016 онд Улсын Их Хуралд орохдоо татвар нэмэхгүй гэж орсон. Түүнээс хойш .9 төрлийн татвар нэмсэн. Ганцхан нийгмийн даатгалын шимтгэлийг хоол, хүнс, унааны мөнгөнөөс нь авахаа больё гэхээр улс төржөөд өргөн бариагүй хуулийн төслөөр манай Түвшин гишүүнийг ятгасаар байгаад хойшлуулаад хэлэлцээгүй. Тэгээд одоо ингээд төсвийн тогт...

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Тийм ер нь энэ төсвийн тогтвортой байдлын хуулийгаа барьж ажиллах ёстой. Би тэрэн дээр санал нэг байгаа. Гэхдээ төсвөө хумь гээд яриад байж болно. Тэгэхдээ төсөв тогтвортой байдлын зөвлөл өөрөө энэ макро үнүүдийг өгдөг үнүүдийг өгдөг. Үүн дээр нь Эдийн засаг, хөгжлийн яам ажиллаж байгаад олон улсын тэр байгууллагуудынхаа үнийн төсөөлөл дээр нь ажиллаж байгаад эцэслээд төсвийн хүрээгээ боловсруулаад оруулж ирж байгаа.

2026 онд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс орлогын хэмжээг 34.8 их наядаар, зарлагын хэмжээг 35.7 их наяд байхаар таамаг ирүүлсэн байдаг юм байна лээ тухайн үед. Тэгэхэд Эдийн засгийн хөгжлийн яам тухайн үед Гантөмөр сайд ажиллаж байхдаа төсвийн орлогын хэмжээг нь 33.5 их наядаар авсан. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлснээс нь багаар авсан гэсэн үг. Ингээд зарлагын хэмжээг бас 33.5 гээд төсвийн тэнцлийн ямар ч алдагдалгүй төсвийн хүрээг оруулж ирсэн. Энд тохируулаад төсөв батлагдсан. Нэг ёсондоо зөрүү бол орлогын хэмжээ 1.3 их наяд, зарлагын хэмжээ нь 2.3 их наяд байхгүй юу. Ингэж авч байсан. Тухайн үед нүүрсний үнийг 88 доллар өгөхөд нь Эдийн засгийн хөгжлийн яам 80 доллар болж оруулж ирсэн. Түүн дээр энэ оны төсөв хийгдсэн. Гэтэл 5 дугаар сарын байдлаар нүүрсний үнэ дал руу буучихсан. Одоо сүүлд валютын сан 68 байна л гэж байна. 13-30 хувиар буурна л гэж байна. 8 дугаар сард энэ үнэ хэд рүү очихыг мэдэхгүй байна. Харин сайн мэдээ алт, зэс бол өсөх хандлагатай ийм байгаад байна.

Тэгэхээр төсвийн хүрээ гэдэг чинь тухайн цаг үеийнхээ байдалдаа тэр нөгөө экспортын бүтээгдэхүүнүүдийнхээ үнийн өнөөдрийн нөхцөл байдал дээр төсөөлөл дээр нь оруулж ирэх ёстой болохоос биш ирэх оны 9 сарын 1-нд угаасаа нэг 80 доллар хүрэхгүй нүүрсийг 80 доллар гэж төлөвлөхөөд олохгүй орлогоо тавьчихаад түүндээ тохирсон зарлага хийнэ гэж нэг баахан юм зарлагадаад тавьчихаад ингээд цаг үрвэл харин жинхэнэ төсвийн тодотгол хийх байдал руу бол шилжинэ гэж ингэж бодож байгаа. Тийм учраас төсвийн бодлого гэдэг бол маш тийм энгийн логик байгаад байгаа шүү дээ. Эдийн засгийн агшилтын үед тэлдэг, халалтын үедээ хумьдаг. Тэгээд тэр мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлэх л ёстой.

Гэтэл бид нар нөгөө халаад эхлэхээрээ хумьдаггүй, хуримтлал үүсгэдэггүй, олохынхоо хэрээр зардаг, тэгээд төсвийнхөө тэр тусгай шаардлагуудыг барьдаггүй. Ингэж явсаар байгаад олохын хэрээр зарсаар байгаад ингээд 33.5 их наядын орлоготой тэгээд зарлагатай. Гэтэл ийм орлого олох бололцоогүй байж байж .9 сарын 1-нд 33 их наядын орлого олно гэж хэлчхээд түүндээ тохирсон баахан барилга байгууламж, худалдан авалт хийнэ гэж ингээд зарлага тавьчих юм бол энэ худлаа л юм болох гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр яг тантай би санал нэг байна. Цаашдаа энэ хуулиа бариад төсвөө зөв төлөвлөхийн тулд үнэнээрээ л хэлж, цаг үетэйгээ нийцүүлж явъя л гэж бодож байгаа юм.

Д.Амарбаясгалан: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууя.

Г.Тэмүүлэн: Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулахаар Засгийн газар өргөн барьсан байна. Шинэ Засгийн газар шинэ Засгийн газрын бүрэлдэхүүн хуулийн төслийг өргөн барилаа. Тэгээд уг нь тогтвортой л барьж байх ёстой хуулийнхаа дүрмийг нь өөрчлөх гээд, хуулиа өөрчлөх гээд ингээд орж ирж байгаа асуудлыг би дэмжихгүй байгаа. Тэгээд бид нар дүрмээрээ л тоглоё л доо л гэдэг асуудлыг уг нь яриад байгаа шүү дээ. Хуулиа л барья л даа. Тэгээд хууль дүрмээрээ л байцгаая даа гээд асуудлыг яриад байгаа шүү дээ. Яагаад энэ хуулийг ингэж өөрчлөх гэж орж ирээд байгаа юм бэ. 6 сарын 25-нд Засгийн газрын зүгээс Тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулсан. Тэр хууль дээр энэ асуудал агуулгыг та хэд хөндөж яриагүй шүү дээ. Яагаад 7 хоногийн дараа буюу дөнгөж саяхан 7 хоногийн өмнө батлагдсан хууль дээр энэ агуулга асуудлыг хөндөөгүй байж байж дахин дахин ингээд 7 хоногийн дараа энэ хуульд өөрчлөлт оруулаад байгаа юм бэ? Тэгээд би эсвэл одоо Засгийн газар энэ холбогдох хүмүүс нь асуудлаа сайн мэдэхгүй байна уу? Эсвэл яарч сандрахдаа ингээд асуудлыг алдаж онож хийгээд байгаа юм уу? Юу болоод байгаа юм бэ нэгдүгээрх нь.

Хоёрдугаарх нь би Их Хурлаас асуух гээд байгаа юм. Их Хурлын дарга аа, энэ Тогтвортой байдлын тухай хууль дээр би өөрөө энэ өөрчлөлтийг хийж энэ хууль дээр энэ заалтуудыг оруулсан хүний хувьд нэг зүйлийг онцолж хэлэх гээд байгаа юмаа. Тогтвортой байдлын тухай хуулийн 7.7 дээр энэ төсвийн тухай хуулийн тусгай шаардлагыг нь өөрчлөх, хэрэгжих нөхцөл хугацаанд нь өөрчлөлт оруулах юм бол Улсын Их Хурлын нийт гишүүд буюу 126 гишүүн байж байж хэлэлцэж эхлэх ёстой байгаад байгаа юм. Би энэ дэгийн асуудал болох вий гэдэг асуудал яриад байгаа юм. Яагаад би энэ асуудлыг хийсэн гэхээр Үндсэн хуулиас илүү бид нар энэ хуулиа мөрдөж байх ёстой юм байгаа юм. Улсын Их Хурлын бүх гишүүд энэчээ хүрэлцэн ирж байж энэ хуульд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хэлэлцдэг байх ёстой гэдэг асуудлыг тавьж байгаа юм. Өндөр босго шалгуурыг тавьж байгаа юм.

Үндсэн хууль лугаа адил одоо энэ хуулийг бид нар мөрдөж бүх Их Хурлын гишүүд бүгдээрээ энэ дээр байр сууриа илэрхийлж ирцэд орж байж байх ёстой гэдэг 100 хувийн ирцтэй байх энэ асуудлыг тавьж өгсөн байгаа юм. Энэ магадгүй өөр хууль дээр ийм бид нар ийм босго шалгуур тавиагүй. Тэгэхээр энэ магадгүй Улсын Их Хурлын Тамгын газар хуулийнхан бид нар энэ дэг зөрчиж болохгүй шүү. Энэ зөрчиж байгаа юм биш үү. Энэ чинь яг оруулж ирж байгаа өөрчлөлтийнх нь асуудал нь бол бүр 2 дугаар бүлэг дээр буюу төсвийн тусгай шаардлагатай холбоотой асуудлууд. Тэр дотроо төсвийн тусгай шаардлагыг баримтлах зарчим дээр 7.8 гэдэг зүйл заалт орж ирж байгаа асуудлууд. Энэ чинь өртэй холбоотой асуудлыг ярьж байна. Орлого, зарлагатай холбоотой асуудлууд дээш нь доош нь хэлбэлзүүлэх асуудлуудыг ярьж байна. Тэгэхээр ийм нөхцөл байдлууд дээр бол бид нар цаашид хэзээ ч ийм өөрчлөлт оруулж болохгүй. Энэ хууль бол хатуу босготой, энэ шинэ Засгийн газар энэ хатуу босготой хууль болсон гэдгийг бол та нар анхаарч энийг бол ойлгох ёстой байгаа. Дахин дахин энийг оруулаад ирж чадахгүй. Улсын Их Хурлын босгыг давахгүй.

Тэгэхээр энэн дээр би Улсын Их Хурал бол энэ тайлбар бол хийх ёстой. Бид нар энэ асуудлыг хэлэлцэж эхлэхдээ 126 хүн ирцтэй байх ёстой, яг одоогийн байдлаар 126-аас 101 ирцтэй байна. 25 гишүүн хаачихсан. Энэ 25 гишүүн ирж байж бараг энэ хуулийн хэлэлцүүлгийг бол бид нар өнөөдөр өрнүүлэх ёстой байгаад байгаа юм. Тэгэхээр энийг бол тусгай шаардлагыг бид нар өөрчилж байгаа асуудал биш гэж хэлэхгүй биш. Энэ бол 2 дугаар бүлэг тэр чигээрээ тусгай шаардлагатай холбоотой бүлэг. Энэ бол тусгай шаардлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг заасан асуудлууд байгаа. Энийг хэзээ баримтлах юм, баримтлахгүй гэдэг нөхцөлийг зааж байгаа асуудал байгаа. Тэгэхээр ийм онцгой асуудлыг бид нар бол хариуцлагатай хандах ёстой. Хариуцлага хаана байна? Энэ дээр Засгийн газар жоохон энэ яаруу сандруу орж ирээд нөгөө сандруу хүн савнаасаа халина гэж нэг үг байдаг шиг ингээд алдаатай оноотой зүйл хийгээд байгаа юм биш үү? Энийг зөв болгож нэг оруулж ирж хийх ийм асуудлууд зайлшгүй байгаа юм уу яагаад?

Д.Амарбаясгалан: Эхний асуултад Учрал сайд хариулт өгье. Дараад нь Тамгын газраас Тэмүүлэн гишүүний хөндөж байгаа Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Дэгийн тухай хуультай холбогдох заалтуудын талаар тайлбар хэлнэ. За Учрал сайд.

Н.Учрал: Тийм. Би Тэмүүлэн гишүүний энэ Байнгын хороон дээр хэлсэн саналыг ч гэсэн, чуулган дээр хэлж байгаа байр суурийг ч гэсэн хүндэтгэж хүлээж авч байгаа. Энэ Төсвийн тогтвортой байдлын хуулийг Эдийн засаг, хөгжлийн сайдаар томилогдсоны хувьд хатуу барина. Тусгай шаардлагуудаа ч барина. Гэхдээ сая энэ экспортын орлого буурсантай холбогдуулаад бид нар нөгөө ирэх оны энэ төсвийн тодотголыг батлахдаа, төсвийн хүрээгээ өөрчлөхдөө Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний хуульд хэрвээ өөрчлөлт орсон тохиолдолд төсвийн хүрээг хөндөж болох энэ 3 сарыг барихгүй байх заалтыг оруулж ирсэн. Яг тэр заалтыг оруулж ирэхдээ бид нар дагуулаад ирэх оны төсвийн хүрээ буюу 5 дугаар сарын 31-нд баталсан төсвийн хүрээ, ирэх оны төсвийн төсөөллийг хамт өргөн мэдүүлсэн. Гэтэл энэ ирэх оны төсвийн хүрээ төсвийн төсөөлөл чинь энэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнтэй хамааралгүй байна гэдэг ийм шаардлагыг бас Их Хурлаас тавиад, ингээд нөгөө 2026 оны төсвийн хүрээ төсвийн төсөөлөл нь хуулийн төсөл санаачлагчид нь буцчихсан. Тэрнээс бид нар бариагүй биш хамт мэдүүлсэн. Ингээд буцчихсан.

Ингээд төсөл буцчихаж байгаа учраас бие дааж ингэж оруулж ирж байж ирэх оныхоо төсвийн төслийг өргөн мэдүүлэх юм байна гэдэг утгаар нь бол дахиад өргөн мэдүүлсэн болохоос биш анх бол Засгийн газраас хуулийг өргөн мэдүүлэхдээ хамтад нь өргөн мэдүүлсэн гэдгийг бас хэлэх ёстой байх гэж бодож байна.

Дээрээс нь төсвийн тусгай шаардлагуудыг Төсвийн тогтвортой байдлын хуулийн 6 дээр зохицуулсан. 6.1.1, 1.2, 1.3, 1.4 гэж. Нөгөө нэгдсэн төсвийн урсгал зардлын хэмжээ тухайн жилийн GDP-ээс 30 хувь хэтрэхгүй байх. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн ДНБ-ний 2 ба түүнээс дээш хувийн ашигтай байх, төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх. Өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ний 60 хувиас хэтрэхгүй байх гэсэн 4 тусгай шаардлага байдаг. Энэ тусгай шаардлагууд дээр өөрчлөлт орж байгаа тохиолдолд буюу 7.7 дээр нөгөө Их Хурлын бүх гишүүд хүрэлцэн ирж санал хураалтад оролцох ёстой гэдэг шаардлага байдаг. Бидний энэ хөндөж байгаа заалт бол төсвийн тусгай шаардлагад яг хууль дээрээ хамаарахгүй учраас бид нар энэ хуулийг өргөн мэдүүлсэн. Энэ заалт бол яг Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнтэй холбогдуулаад төсвийн хүрээ өргөн мэдүүлсэн тохиолдолд 3 сарын заалтыг хамаарахгүй гэдэгтэй яг адилхан гэж бол яг хэлж болно. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дээр оруулж ирсэн заалт бол энэ хуулийн заалтад хамаарахгүй.

Дээрээс нь энэ бол тэлэхтэй огт холбоогүй. Орлого, зарлага аль аль нь буурч байгаа тохиолдолд л төсвийн хүрээг оруулна, бусад тохиолдолд биш. Тэгэхээр Тогтвортой байдлын зөвлөлийн саналуудыг ч гэсэн...

Д.Амарбаясгалан: Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ариунхур дарга хариулт өгье. 1 дүгээр микрофон.

Ч.Ариунхур: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.7-д Төсвийн тусгай шаардлагыг өөрчлөх, хэрэгжих нөхцөл хугацаанд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.20-д зааснаас бусад тохиолдолд чуулганы хуралдаанд товлосон хугацаанд заавал хүрэлцэн ирж оролцоно гэж заасан байгаа. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.20-д Улсын Их Хурлын гишүүн өвчтэй, чөлөөтэй, дотоод, гадаад томилолттой ажиллахаас бусад тохиолдолд Нэгдсэн, байнгын, дээд, хянан шалгах түр хорооны хуралдаанд товлосон хугацаанд хүрэлцэн ирж оролцох оролцохоор зохицуулсан. Өөрөөр хэлбэл гишүүн хуралдаандаа оролцох асуудлыг өргөжүүлсэн. Энэ Их Хурлын хуультай нийцэж байгаа зохицуулалт байгаа.

Гэхдээ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулдаг. Дэгийн тухай хуулийн 3.3-д чуулганы хуралдааныг хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуралдааны дэгийн дагуу зохион байгуулна гэж заасан байгаа. Тэгэхээр хуралдааны ирц бол Дэгийн тухай хуульд нийцэж байгаа. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ гэж заасантай нийцэж байгаа.

Д.Амарбаясгалан: Тийм. Тэмүүлэн гишүүн тусгай шаардлагад орно гэж хэллээ шүү дээ. Тэрэн дээр Ариунхур дарга яах юм. Одоо тусгай шаардлагад орж байна аа гэх юм бол өвчтэй, чөлөөтэйгөөс бусад гишүүд заавал оролцох шаардлага тавигдана гэсэн үг болох гээд байна шүү дээ. Ариунхур дарга нэмж хариулъя. За Ариунхур дарга хариулт өгье.

Ч.Ариунхур: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 7.8 дахь заалт дээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг бууруулах өөрчлөлт орсонтой орсон тохиолдолд тэр 3 сарын хугацаа хамаарахгүй гээд 7.5 дахь зохицуулалтад өөрөөр хэлбэл хугацаанд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд явчихъя. Төсвийн тусгай шаардлагын 7.7 дээр төсвийн тусгай шаардлагыг өөрчлөх, хэрэгжих нөхцөл хугацаанд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхэд гэж байгаа юм. Тэгэхээр энэ 3 сарын хугацаа хамаарахгүй гээд хугацаатай холбоотой асуудал хөндөгдөж байна гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: Тогтвортой байдлын зөвлөлөөс нэмж тайлбар хийх хүн байна уу? 3 дугаар индэр. Тэгэхдээ ер нь яах вэ хууль тайлбарлах зөвлөх эрх энэ Баасандорж даргыг дуудах юм уу Ерөнхий нарийн бичгийн даргыг. 3 дугаар индэр.

Ж.Дэлгэрсайхан: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Дэлгэрсайхан.

Бид хуулийн хүрээнд зөвхөн өөрсдийн байр суурийг илэрхийлье. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 2 дугаар бүлэг өөрөө тэр чигээрээ төсвийн удирдлагын зарчим, тусгай шаардлага гэсэн ийм нэртэй байгаа. 2 дугаар зүйлийн 6 дээр тусгай шаардлагуудыг заасан боловч 7 дугаар зүйл бол өөрөө тусгай шаардлагыг баримтлах асуудалтай холбоотой. Тэгэхээр тусгай шаардлагыг баримтлах хүрээнд төсвийн хүрээний мэдэгдэл гарцаагүй хамаардаг. Төсвийн тусгай шаардлага нь өөрөө төсвийн хүрээний мэдэгдэл нь тусгай шаардлагад нийцсэн байдаг учраас бидний зүгээс үзэх зүгээр бидний байр суурь бол энэ асуудал яах аргагүй төсвийн тусгай шаардлагатай шууд хамааралтай асуудал байна аа гэж харахаар байгаа.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хороо хуралдах гээд байна аа. Төсвийн байнгын хорооны дарга байна уу. Баасандорж дарга энэ асуудал дээр тайлбар хийгээч. Төсвийн байнгын хороо хэдэн хүн оролцсон юм. Одоо энэ тусгай шаардлага гээд саяын Тэмүүлэн гишүүний хэлж байгаагаар хэрвээ Тэмүүлэн гишүүний хэлж байгаагаар ярих юм 126 гишүүнээс өнөөдөр өвчтэй, чөлөөтэй 11 гишүүн байгаа юу. 11 гишүүн байгаа тэгээд 115 байж байж асуудал хэлэлцэх ёстой гэдэг асуудал яригдлаа шүү дээ. 3 гишүүн нь яасан юм. Өвчтэй, чөлөөтэй байсан юм уу. Баасандорж дарга хариулт өгье. 1 дүгээр микрофон.

Б.Баасандорж: Улсын Их Хурлын дарга, гишүүддээ дахин энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл байгаа. Энэ 7 дугаар зүйл бол тэр чигтээ ер нь төсвийн тусгай шаардлагыг баримтлах асуудлыг зохицуулж байгаа. 7 дугаар зүйл бүхэлдээ. Яг энэ 7 дугаар зүйлийн 7.7 дээр төсвийн тусгай шаардлагыг өөрчлөх нэгд нь. Хоёрт нь хэрэгжих нөхцөл, гуравт нь хугацаанд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.20 буюу өвчтэй, чөлөөтэй албан томилолтоор явснаас бусад тохиолдолд чуулганы хуралдаанд товлосон хугацаанд заавал хүрэлцэн ирж оролцоно оо л гэж байгаа юм.

Тэгэхээр өөрөөр хэлбэл энд хугацааны асуудлыг хөндөж байгаа шүү дээ. Тэгэхээр гишүүддээ нөгөө талаас энд нэг талаасаа зүгээр гишүүд маань энэ асуудлыг хэлэлцэхэд оролцох ёстой шүү гэдэг үүргийг л зүгээр энэ хуулиар яаж байгаа байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүн орж ирлээ. Даваасүрэн гишүүнд микрофон өгье, хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе. Энэ асуудал Төсвийн тогтвортой байдлын хуулиар заасан 4 тусгай шаардлагад хамаарахгүй байгаа. 7.5 нь тусдаа. Тийм учраас бол заавал бүх гишүүд байлц гэдэг ийм шаардлага тавихгүй. Тэр 4 тусгай шаардлагад өөрчлөлт ороход тавигдана.

Д.Амарбаясгалан: Сая ингээд хариулчихлаа шүү дээ. Тогтвортой байдлын зөвлөл Тамгын газраас Тэргүүн дэд даргын хариулт дээр чинь 3 сар гэдэг зүйл дээр өөрчлөлт орж байгаа учраас тэр чинь тусгай шаардлага гэдэг асуудал хөндөгдөөд байна шүү дээ. Алив Тэмүүлэн гишүүн ахиад тодруулаад нэг хэлээдхээч.

Г.Тэмүүлэн: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.7 дээр ерөөсөө ийм л асуудал байгаа шүү дээ. Төсвийн тусгай шаардлагыг өөрчлөх таслал тэгээд хэрэгжих нөхцөл таслал тэгээд хугацаанд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхэд гэж оруулж байгаа юм. Тэгээд энэ бол нэг талдаа манай тамгын газрынхан ч гэсэн энэ заалтын агуулгыг нь сайн ойлгох ёстой. Товлосон хугацаанд заавал хүрэлцэн ирж оролцоно гэж оруулж өгч байгаа юм.

Тэгэхээр нөгөө өвчтэй, чөлөөтэй, гадаад, дотоодод томилолтоор байснаас бусад хүмүүс бол энд оролцож байж энийг хэлэлцэж эхлэх ийм бол хатуу босгыг тавьж өгсөн шүү. Энэ бол тухайн үед бид нар ийм хуулийн чагт түгжээ цоож хийхээс өөр гарц гаргалгаа бол тухайн үедээ байгаагүй юм. Хуучин 4-ний 3-аар шийдэгддэг байсан асуудлыг 2015 онд Цэц дээр аваачаад дүгнэлтээр энийг байхгүй болгочихсон юм. Хатуу босго өндөртэй байсан асуудлыг. Тэгэхээр энэ дээр бол бид нар ямар ч бай ийм зүйл заалт бол байгаа шүү. Энийг бид нар яг хуулийнх нь хүрээнд ойлгож тавих ёстой.

Д.Амарбаясгалан: Алив Баасандорж дарга маш тодорхой нэг хэлээдхээч. Яг энэ асуудал өөрөө тусгай шаардлагад орж байгаа юм уу, орохгүй байгаа юм уу? Төсвийн байнгын хороон дээр Даваасүрэн.

Б.Баасандорж: Гишүүд ээ би маш тодорхой хэлье ээ. Энэ Тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7 дээр 3 асуудал байгаа шүү дээ. Энэ тусгай шаардлагад хамаарахгүй Даваасүрэн даргын зөв. Гэхдээ нэгд Даваасүрэн дарга аа нэгд төсвийн тусгай шаардлагыг өөрчлөх энэ нэг тал нэг дэх нөхцөл нь байхгүй юу. Хоёрт нь хэрэгжих нөхцөл, гуравт нь хугацаанд өөрчлөлт оруулах гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хугацааны асуудлыг хөндөөд байгаа байхгүй юу. Гэхдээ эрхэм гишүүд ээ, би дахиад нэг зүйлийг хэлье. Улсын Их Хурлын үйл ажиллагааг хүчин төгөлдөр үйлчилж байгаа чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулна гэж манай дэгийн хууль дээр байгаа. Үндсэн хууль дээр Улсын Их Хурлын чуулган хуралдаанд олонх нь хүрэлцэн ирэхээр асуудлаа шийдвэрлэнэ гэсэн зүйл байгаа. Би бол энэ дээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.7-д ийм заалт байгаа шүү, оролцох ёстой юм байна шүү гэдэг тогтвортой байдлын

хуулийн асуудлыг л хөндөж тавьж байгаа байхгүй юу. Чуулган бол чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиараа л зохицуулагдана.

Д.Амарбаясгалан: За ингэе. 1 цагаас тэртээ тэргүй даргын дэргэдэх зөвлөл зарлачихсан байж байгаа. Энэ 3 гишүүний асуултыг үлдээгээд дараачийн асуудлаа хэлэлцээд, 2 цагаас энэ асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцье. Түр завсарлуулна энийг.

Дараачийн асуудалд оръё. Баасандорж дарга даргын дэргэдэх зөвлөл дээр энэ маргаантай асуудлуудыг эцэслэн шийдвэрлэнэ. Даргын дэргэдэх зөвлөл дээр санал хурааж шийднэ. Тийм зөвлөгөө өгнө харин тийм. Тэгэхээр зөвлөгөө өгөөд энэ асуудлаа тийм. Тэгэхээр даргын дэргэдэх зөвлөл дээр энэ зөрүүтэй байр сууриудаа нэгтгэж байгаад асуудлаа шийдэх нь зүйтэй маргаангүйгээр. Ер нь хууль тайлбар хийдэг байгууллага Цэцээс.

Дараагийн асуудалд оръё.

Нийтийн өмчийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт танилцуулна аа. Индэрт урьж байна. Зүгээр нэг иймэрхүү маргаантай асуудлыг хэдүүлээ даргын дэргэдэх зөвлөл дээрээ яриад нэг мөр болгоод цааш нь үргэлжлүүлээд явах нь зүйтэй. Бямбацогт сайд танилцуулгаа хийе.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд 201.9 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан, төрийн нийтийн өмч байх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх, аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх эрхтэй гэсэн зарчмыг хуульчлан баталгаажуулсан.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.4.2-т төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, үр өгөөж, хяналтыг сайжруулах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчилнэ гэж заасан. Монгол Улс 1990 оноос зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбогдуулан 1996 онд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг анх баталсан бөгөөд уг хууль нь шилжилтийн үеийн төрийн болон орон нутгийн өмчийн талаарх төрийн байгууллагын эрх хэмжээг тогтоон өмч хувьчлалыг зохицуулахад чиглэсэн байдаг аа.

Уг хууль батлагдсанаас хойш хуулийн нийт зүйлийн 80 орчим хувьд 3.9 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд дийлэнх нь хуулийн гол зохицуулалттай холбоотой тулгарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэхэд бус харин салбарын бусад хуульд шинэчлэгдсэн тэдгээрт нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой байна аа. Ийнхүү Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зохицуулалтын хийдэлтэй болон эрх зүйн шинэчлэлээс хоцорсон, хууль цаг үеийн шинжтэй бусад салбарын хуулийн

өөрчлөлттэй уялдуулсан нэмэлт, өөрчлөлтийг удаа дараа оруулсан зэрэг нь хуулийн зохицуулалтын нэгдмэл цогц байдлыг алдагдуулахад хүргэжээ.

Иймд эрх зүйн шинэчлэл бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилтын хүрээнд нийтийн өмч, түүний дотор төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн хууль хоорондын давхардал, хийдлийг арилгах, төрийн болон орон нутгийн өмчийн ангилал, хэлбэрийг зохистой тогтоож, өмчийн удирдлага, бүртгэл, ашиглалт, хамгаалалт, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хуулийн нэрийг Иргэний хуульд заасан өмчийн төрөлд нийцүүлэн өргөжүүлж, нийтийн өмчийн суурь харилцааг зохицуулах хүрээнд нийтийн өмчийн хууль гэж өөрчилж, төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг тус хуулиар харин олон нийтийн болон шашны өмчийн харилцааг уг хуульд нийцүүлэн тухайлсан хуулиар зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ ээ.

Хуулийн төсөл 9 бүлэг, 81 зүйлтэй бөгөөд дараах зарчмын өөрчлөлтийг тусгалаа. Үүнд:

1. Нийтийн өмч түүний дотор төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалт, хяналтын нэгдмэл байдлыг хангах зорилгоор хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэхийн зэрэгцээ хуулийн үйлчлэлд хамаарахгүй боловч тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулах харилцааг бусад хууль тогтоомж эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан тодорхойлсон. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн өмч, удирдлага, зохион байгуулалттай холбоотой асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулиар тухай бие даасан хуулиар зохицуулахаар тусгасан.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн ангиллыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн шинэчилж, төрийн өмчийн өмчлөгч Улсын Их Хурал орон нутгийн өмчийн өмчлөгч нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-д байх зарчмыг хэвээр хадгалж, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх этгээдүүдийн эрх хэмжээний давхцал ойлгомжгүй байдлыг арилгаж, харилцан уялдаатай байхаар тусгасан. Төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөгч, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, өмчийн эзэмшигч этгээдийн эрх зүйн байдлыг хөрөнгийн эрхийн байдалтай нь уялдуулан оновчилж тогтоосон.

4. Төрийн өмчийн хороо орон нутгийн өмчийн газрын хяналтын чиг үүргийг тодруулан хуульчилж, Төрийн өмчийн хорооны бүрэлдэхүүнд хөрөнгийн удирдлага, хөрөнгийн үнэлгээ, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэшсэн иргэнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилж ажиллуулах боломжийг бүрдүүлээ.

5. Төрийн болон орон нутгийн өмчит хөрөнгө олж авах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх асуудлыг үр ашигтай, нээлттэй, ил тод байдлаар хэрэгжүүлэх журам аргыг нарийвчлан тусгасан. Энэ хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийтийн эрх ашгийг хангах зорилгоор өмчийг ашиглуулах, шилжүүлэх, үндэслэл зорилгод гэрээний нөхцөл, талуудын хүлээх эрх, үүргийг тодорхой хуульчилж, өмчийн бусдын

өмчийг бусдын өмчлөлд шилжүүлсний дараа хэрэгжүүлэх хяналтыг зохицуулалтыг шинээр тусгасан.

6.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн нэгдмэл тогтолцоо түүний бүрдэл хэсгийг тодорхойлж, хөрөнгө бүртгэх, тоолох, үнэлэх ажиллагааг нарийвчлан зохицуулсан. Төрийн өмчийн нэгдсэн бүртгэл, тооллого, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн дагнасан бүртгэлийг хийх, хөрөнгийн өөрчлөлт, хөдөлгөөн, хөрөнгө эзэмшигчийн мэдээллийг нээлттэй байлгах зохицуулалтуудыг бий болгосон.

7.Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалтын хяналт шалгалт, сахилга, хариуцлагын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлж, өмчлөгч болон төрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг нарийвчлан зохицуулж, Улсын Их Хурал Засгийн газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал дарга болон ТӨХ орон нутгийн өмчийн газраас хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндэслэл журмыг тодорхойлсон.

8.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого, үнэлгээ, өмчийн хөдөлгөөн, тайлан, хяналт шалгалттай холбоотой мэдээллийг төвлөрүүлсэн цахим систем мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, эрхлэн хөтлөх, хөгжүүлэх, мэдээллийг баталгаажуулах болон хадгалалт, хамгаалалт хэрэгжүүлэх журмыг тодорхой хуульчилсан. Хууль батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчийн төрөл, хөрөнгийн ангилал, өмчлөх эрх болон өмчийн удирдлага хэрэгжүүлэх субъектийн чиг үүрэг, үйл ажиллагааны үндэслэл, журам тодорхой болж, төрийн болон орон нутгийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, үр ашиг, үнэлгээг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ ээ.

Мөн төрийн болон орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой хууль хоорондын хийдэл зөрчил арилж, төрийн нийтийн өмчид хамаарах газар, байгалийн баялаг болон бусад өмч хөрөнгийн удирдлагын нэгдмэл тогтолцоо хангагдаж, Монгол Улсын Үндсэн хуулиар тодорхойлсон байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчим бодитой хэрэгжих суурь нөхцөл бүрдэнэ ээ.

Төрийн болон орон нутгийн өмчтэй холбоотой шийдвэр хариуцлагатай, ил тод, нээлттэй байх, төрийн үйлчилгээ, түргэн шуурхай, хүнд суртлаас ангид байх зарчмын хэрэгжилт хангагдаж, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үнэлэх, бүртгэх, бусдад ашиглуулах, шилжүүлэх үйл ажиллагаа нийтийн эрх ашигт нийцсэн үр ашигтай байх хууль зүйн үндэслэл бүрдэнэ ээ. Өөрөөр хэлбэл төрийн болон орон нутгийн өмчийн үр ашигтай байдлыг дээшлүүлж, хөрөнгийн бүрэн бүртгэж, өмчлөх эрхийг баталгаажуулснаар төрийн өмч нэрийн доор хэн нэгэн эрх мэдэлтэн, албан тушаалтан хувьдаа шамшигдуулах хууль бус үйлдэл гаргахаас сэргийлэх улмаар төрд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юмаа.

Хуулийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан түүнчлэн хууль хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалт шилжилтийн үеийн бэлтгэл хангах мөн хуульд заасан нэр томъёог жигдлэх, зохицуулах хоорондын уялдааг сайжруулах зорилгоор хуулийн төслийг дагалдуулан 41 хуулийн төсөл, 22 Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулсан болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхэнд хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслүүдийн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна аа. Индэрт урьж байна.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн өмчийн тухай хуулийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Нийтийн өмчийн хууль батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчийн төрөл, хөрөнгийн ангилал, өмчлөх эрх болон өмчийн удирдлага хэрэгжүүлэх субъектийн чиг үүрэг, үйл ажиллагааны үндэслэл, журам тодорхой болж, төрийн болон орон нутгийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, үр ашиг, үнэлгээг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ гэж төсөл санаачлагч үзжээ.

Түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн үр ашигтай байдлыг дээшлүүлж, хөрөнгийн бүрэн хөрөнгийг бүрэн бүртгэж, өмчлөх эрхийг баталгаажуулснаар төрийн өмч нэрийн доор хэн нэгэн эрх мэдэлтэн, албан тушаалтан хувьдаа шамшигдуулах, зүй бус үйлдэл гаргахаас урьдчилан сэргийлэх улмаар төрд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ гэж уг хуулийн төслийг боловсруулсан байна аа. Зардлын тооцооны хувьд тус хуулийн төсөл төслөөр хувь хүн, хуулийн этгээдэд ямар нэгэн нэмэлт үүрэг хүлээлгээгүй тул хуулийн хэрэгжилттэй холбоотой тэдгээрээс нэмэлт зардал шаардахгүй гэж үзжээ.

Иймд энэхүү хуулийн төслийн хүрээнд иргэн хуулийн этгээд үүсэх зардлын тооцоолол хийгдээгүй байна аа. Харин төрийн байгууллагад шинээр хүлээлгэсэн зарим чиг үүрэгтэй холбоотойгоор шинээр үүсэх тодорхой зардлыг тогтоож, түүнийг хялбарчлах боломжтой эсэх талаар дүгнэлт хийж боломжит хувилбарыг санал болгоно гэж үзжээ. Хуулийн төслийг Dparliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтээс саналыг авч байна аа.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нийтийн өмчийн хуулийн зохицуулалт тодорхойлолтын талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Соронзонболд төрийн болон орон нутгийн өмчийн нийт 5484 хуулийн этгээд бүртгэлтэй байгаа бөгөөд энэ хуулийн төсөл батлагдсанаар хэрхэн өөрчлөлт орох, нийтийн болон шашны өмчийн харилцааны талаар, Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа хуулийн төсөлд тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр ямар заалт тусгасан талаар, нийтийн өмчийн барилга байгууламжийн ашиглалтын зардлыг бууруулах чиглэлээр ямар алхмууд хийгдэх талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Иргэний хуульд заасан олон нийтийн өмч гэсэн тодорхойлолтын талаар. Үүнийг энэ хуульд тусгаагүй талаар сум дүүргийн олон нийтэд нээлттэй байгууламжуудыг өмчийн удирдлага менежментийг уг хуульд хэрхэн тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай олон нийтийн өмчийн тухай ойлголт, орон нутгийн оролцооны талаар ТӨК-иудын

хувьцааг зах зээлд гаргах зохицуулалтыг хуульд хэрхэн тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн төсөлд яагаад орон нутгийн эрх мэдлийг хумьж тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн өмч хувьчлалаар хувьчлагдсан барилга байгууламжийн байршлын талаар гаргасан судалгаа байгаа эсэх, төрийн нийтийн өмчийг ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхай, газрын тосны компаниуд өмчлөлийн хэлбэрээс үл харгалзан худалдан авах ажиллагааны ил тод нээлттэй зарладаг болох зохицуулалтыг энэ хуулийн төсөлд оруулсан эсэх талаар төсөл санаачлагчаас асуулт асууж, хариулт авлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нийтийн өмчийн талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох, төрийн болон орон нутгийн өмчит компанийн асуудлыг энэ хуульд зохицуулалттай уялдуулах чиглэлээр Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын ахалсан төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийн Байнгын хорооны чуулганаас бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт энэ хуулийн төслийг хариуцуулан ажиллуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай хуулийн төслийг Байнгын хорооны чуулганы хуралдаанд бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, хуулийн төслийн зохицуулалтыг холбогдох хууль дахь ойлголтуудтай нийцүүлэх талаар саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлыг санал хураалт явуулахад Нийтийн өмчийн тухай хуулийг төслийг 64.3 хувь, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 64.3 хувь, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 64.3 хувь, Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 64.3 хувь, Гадаад иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 64.3 хувь, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Генетикийн нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Ерөнхий боловсролын сургуулийн Хоол үйлдвэр үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслүүдийг тус тус 64.3 хувиар хэлэлцэхийг дэмжсэн болно.

Түүнчлэн Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Кибер аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг 64.3 хувиар дэмжсэн болно.

Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 57.1 хувиар дэмжсэн. Музейн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 64.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 64.3 хувь, Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 64.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 64.3, Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн

төслийг 64.3, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 64.3, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ус, цаг уур, орчны шинжилгээний хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг 64.3 хувиар хэлэлцэхийг дэмжлээ.

Мөн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг 64.3 хувиар дэмжсэн Шинжлэх ухаан, технологийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 57.1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 64.3, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 64.3, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 57.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төслийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн тогтоол тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг 57.1, Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг 64.3, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн бүдүүвчийг шинэчлэн батлах тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг 64.3 хувийн саналаар тус тус хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, хууль тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Нийтийн өмчийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Сандагийн Бямбацогт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын дарга, Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Нарангэрэл Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх газрын зөвлөх, Төрбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын референт, Оюунзул Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга, Дэлгэрмаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Нарангэрэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтсийн дарга.

Энэ тамгын газраас энэ ирүүлж байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүний танилцуулгыг нэг форматаар ирүүлж байхгүй бол заримдаа овог нэр нь, заримдаа овгийн эхний үсэгтэйгээр орж ирээд болж өгөхгүй юм. Энэ дээрээ бас анхаараарай. Энэ удаа дараа давтагдаж байна аа.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа. Нийт 13 гишүүний нэр ирсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн алга байна. Нанзадын Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Их Хурлын гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг Нийтийн өмчийн тухай хууль болгоод өөрчлөөд оруулж ирж байгаа юм байна. Яах вэ цаг үе нь бол өөрчлөх болсон гэдэгтэй санал нэг байгаа. Миний хувьд бол хэлэлцэх эсэхийг нь дэмжээд ард нь ажлын хэсэг нэлээн сайн ажиллахгүй учир дутагдалтай юм маш их байна. Зүгээр би хуулийг нэг л уншсан. Тэгээд юуг нь голлож харсан бэ гэхээр зэрэг орон нутгийн өмчтэй холбоотой заалтуудыг л жаахан харлаа. Тэгээд эндээс харахад хуучин Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиасаа дордсон. Юу нь дордсон гэхээр зэрэг орон нутгийн өмчийн эрх мэдлийг хязгаарласан, хаасан, боогдуулсан, сулруулсан тийм зүйлүүд харагдаад байгаа юмаа. Тийм зүйлүүд байна.

Бид чинь орон нутгийнхаа хөгжлийг дэмжинэ, бүсчилж хөгжүүлнэ гээд л Их Хурлын сонгуулиа ч хүртэл бүс болгоод л, олон зөвлөгөөн хийгээд л одоо бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гээд л, төвлөрлийг сааруулна гээд л яриад байдаг мөртөө яг нөгөө хууль бодлого боловсруулж, хууль батлахдаа орон нутгийнхаа эрх мэдлийг улам хумиад байх юмаа. Өнөөдөр удирдлагын эрх мэдэл гэж байхгүй. Аймагт 26 агентлагийн 20-ийг нь яам агентлаг нь томилдог даргыг нь. 6-г нь л орон нутаг төсвийн эрх мэдэл байхгүй, улсын нэгдсэн төсөвтэй манай холбооны улс биш гээд бүх АМНАТ-өөс өгсүүлээд бүх татварын хураамжийг нь төр татаад авчихдаг. Эргээд хуваарилж байгаа зүйл гэж өчүүхэн. Одоо ингээд өмчийн эрх мэдлийг нь татаж авч болохгүй ээ.

Тийм учраас би ажлын хэсэг дээр нэлээн сайн ажиллах ёстой. Тухайлах юм бол орон нутагтаа аялал жуулчлалын зориулалтаар өмчтэй байдаг эрхийг нь энэ дээр шинэ хуулийн төсөл дээр аваад хаячихсан байх юм. Дээрээс нь нэмээд орон нутаг чинь энэ хувьцаа эзэмшиж өмчилж болохгүй юм уу? Тийм зохицуулалт энэ хууль дээр чинь байхгүй байх юм. Тухайлбал зарим аймгууд чинь орон нутгийн өмчит компанитай шүү дээ. 51 хувь нь өөрийн орон нутгийн мэдлийн бусад нь хувийн аж ахуйн нэгж байдаг ч юм уу. Тэгэхээр орон нутаг үнэт цаас гаргах эрх байгаа юм уу? Одоо зарим аймгууд чинь бонд гаргаад тэгээд тулгамдсан асуудлуудаа шийдье гэж. Бонд үнэт цаас эзэмших эрх байх ёстой. Хувьцаа эзэмших эрх байх ёстой. Тэгээд дээрээс нь нийтийн эрх ашгийн төлөө Улсын Их Хурал шууд орон нутгийн өмчийг шилжүүлж авна гээд зүгээр бүдүүлгээр хэлбэл булааж авна гэсэн заалт орчихсон байх юм. Гэх мэтчилэн энэ орон нутгийнхаа өмчийн эрх мэдэл тэгээд гаднын зээл тусламжаар өмч орон нутагт бий болгож болохгүй ч гэж байх шиг.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт сайд хариулт өгье.

С.Бямбацогт: Наранбаатар гишүүний асуултад хариулъя аа. Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 1996 онд батлагдсан. Үндсэндээ бараг 30 жилийн дараа шинэчилж найруулж Их Хуралд өргөн барьж батлуулах гэж байгаа. Тухайн үед хэрэгжиж байсан хууль бол ер нь зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш энэ төрийн өмчийг удирдаж зохион байгуулах, хяналт тавих шинэ тогтолцоог бүрдүүлэх, нөгөө талаасаа өмч хувьчлалыг хурдтай хэрэгжүүлэх ийм л агуулга дээр

үзэл баримтлал дээр суурилж батлагдсан хууль байсан юм байна лээ. Үүнээс 30 гаруй жилийн хугацаанд үндсэндээ бол энэ хуулийг шинэчилж, найруулж өөрчлөх ийм шаардлага үүссэн. Энэ хуульд 80 гаруй удаа өөрчлөлт орсон байдаг боловч яг юу гэдэг юм нэгдмэл цогц байдал нь алдагдсан. Өнөөдрийн цаг үеийн хөгжил нийгмийн тавьж байгаа шаардлага, Засгийн газар, Улсын Их Хурлаас явуулж байгаа төрийн өмчийн талаар явуулж байгаа бодлого олон нийтийн хүлээлтэд нийцэхгүй байгаад байгаа юм. Тийм болохоор өөрчлөх асуудлыг 10 хэдэн жилийн өмнөөс ярьсан юм байна лээ, 10 хэдэн жилийн өмнөөс. Явж явж өнөөдөр үндсэндээ Улсын Их Хурал дээр хэлэлцэх эсэх нь орж ирж байгаа юмаа гэдгийг юуны өмнө хэлье ээ.

Орон нутгийн өмчтэй харилцаа, орон нутгийн өмчийн удирдлагатай холбоотой харилцаан дээр бас өмнөх одоо хүчин төгөлдөр байгаа харьцангуй юу гэдэг юм зохицуулалт байхгүй. Үүнээсээ болоод орон нутгийн өмчийн хяналт, орон нутгийн өмчийн тийм үү төлөөлөл хэрэгжүүлэх асуудал нэлээн орхигдчихсон байгаад байгаа. Үүнийг бол энэ хуулиар илүү боловсронгуй болгоод, илүү нарийвчлаад илүү зохицуулалттай болгох ийм асуудлуудыг бас хөндөж оруулж ирсэн. Тухайлах юм бол бас орон нутгийн өмчийн өмчлөгч нь Засаг дарга байх. Орон нутгийн өмчийн асуудлыг Иргэдийн хурал нь шийдвэрлэх, орон нутагт тодорхой яг асуудлаа хэрхэн, яаж шийдвэрлэх вэ гэдгийг маш тодорхой зохицуулсан зохицуулалтууд хуулийн төсөлд болбол өмнөх хүчин төгөлдөр хуультай харьцуулаад орж ирсэн байгаа гэдгийг танд хэлье ээ.

Гэхдээ таны ярьж байгаа тэр эрх мэдлийг хумих гээд байна гэдэг асуудал яг тодорхой ямар заалт дээр яригдаж байгаа бол? Мөн ажлын хэсэг байгуулаад хуулийг сайжруулаад явъя гэдэг дээр бол санал нэг байна аа. Тэгээд орон нутаг хувьцаа гаргах, орон нутаг бонд гаргах энэ боломжийн талаар манай ажлын хэсэг нэмээд хариулчихгүй юу.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн алга байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн нэмж хариулт байгаа юм уу хэнээс? Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Цолмон 4 дүгээр индэр.

Д.Цолмон: Наранбаатар гишүүний асуултад нэмж хариулъя. Нийтийн өмчийн тухай хууль болон төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглал, ил тод байдал, бүтээмжийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл хоёулаа уялдаж бичигдэж боловсруулагдсан байгаа. Таны асуусан энэ төрийн орон нутаг бол энэ бие дааж энэ компани байгуулах асуудал бол хязгаарлагдсан уу гэдэг асуудлуудад хариулъя. Энд бол хязгаарлагдсан зүйл байхгүй. Харин ямар тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит компанийг байгуулах үндэс суурийг бол тухайн хуулиараа бид нар тодорхой болгож өгсөн юмаа. Төрийн компанийн хувьд нэг 5 үндэслэл байгаа. Орон нутгийн компанийн хувьд гэх юм орон нутаг тодорхой энэ нийгмийн дэд бүтэц, нийгмийн энэ үйлчилгээг хүрэх зорилгын хүрээндээ өөрийнхөө чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгын хүрээндээ бол компани байгуулж болно гэдэг энэ үндэслэлийг бол бид нар тавьж өгсөн байгаа.

Энэ чиг үүргийн хувьд бол Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд орон нутгийн чиг үүрэг хэрэгжүүлэх хүрээнд өмчтэй байна гэдэг ийм зохицуулалт байгаа. Гэхдээ энэ төрийн...

Д.Амарбаясгалан: Нанзадын Наранбаатар гишүүн тодруулж асууя.

Н.Наранбаатар: Тэгээд хэлэлцэх эсэх нь хэрвээ дэмжигдээд явах юм бол дараах хэдэн зүйлүүд дээр та бүхэн анхаараарай гэж хэлье. Өмнөговь аймаг жишээ нь орон нутгийн өмчит 5 толгойтой, 51 хувийг нь аймгийн иргэдийн хурал нь эзэмшдэг. Үүнийг цааш нь баталгаажуулж тэр үнэт цаас эзэмших тэр эрхийг нь баталгаажуулж өгөх хэрэгтэй. Аялал жуулчлалынхаа салбарт Өмнөговь хөрөнгө оруулалт хийгээд орон нутгийн төсвөөсөө жорлон, хогийн савнаас өгсүүлээд маш олон зүйлүүдийг хийдэг. Тэрийгээ эзэмших эрхтэй байх ёстой. Мөн аймаг өөрөө бонд гаргаад ДЦС-ыг шинээр барих гэж байгаа иргэдийн хурлаар. Энэ одоо бий болгоод ирэхлээр зэрэг бонд нь өөрийнх нь өмч, үнэт цаас нь өөрийнх нь өмч, дулааны станц нь өөрийнх нь өмч нь байхаар зохицуулж өгөх ёстой. Мөн орон нутгийн өмчийг төрд шилжүүлэхдээ заавал аймгийн ИТХ-ын санал дүгнэлтийг үндэслэж байж шилжүүлдэг гэх мэтчилэн орон нутгийн өмчийн эрхтэй холбоотой хэд хэдэн асуудлыг та бүхэн...

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Энэ ингээд 1992 оноос хойш Монгол Улс нийгэм эдийн засгийн томоохон өөрчлөлт, тогтолцооны өөрчлөлт хийсний дараа нэг орхигдуулсан салбар нь энэ өмчийн асуудал юмаа. Энэ өмчийн асуудлыг хэрхэн яаж зохицуулж бүртгэж зөв менежмент хийх нь нөгөө ард түмэн байгалийн баялагтаа эзэн байх, төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх, орон нутгийн хөгжил, эдийн засаг, ажлын байр тэлэлт хэрхэн зөв явагдах, эргээд энэ хувийн хэвшил бизнесийн орон зай гаргаж өгөх үү, үгүй юү гэдэг гээд маш олон уулзвар дээр энэ асуудал байгаа юм. Өнөөдөр энэ хууль зөв гарвал төрийн албаны шинэчлэлийн үзэл баримтлал энд тодорхойлогдож байгаа. Байгаль орчны багц хуулийн үзэл баримтлал энд тодорхойлогдож байгаа. Байгалийн тэр нөөцийг болон тэр дагалдах байдлыг хэрхэн яаж ашиглах вэ гэдэг асуудал энэ хуулиар тодорхойлогдох гэж байгаа байхгүй юу. Дээрээс нь газрын багц хуулийн үзэл баримтлал сууриараа энд яригдана гэх зэрэг уг нь ийм чухал хууль байж байгаа. Тэгээд мэдээж гишүүд түрүүчээсээ хэлж байх шиг байна.

Энэ хуулийг Нийтийн өмчийн тухай хууль гээд нэрлэхсэн мөртөө нийтийн өмчийн 2 төрөл болох олон нийтийн болон шашны өмчийн талаар зохицуулсан нэг ширхэг ч заалт байхгүй. Тэгэхээр хуулийн төслийн нэрнээс эхлээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль гээд явах энэ зохицуулах хүрээ хязгаар энэ тэрдээ зөв орох хэрэгтэй. Бид хэд төрийн байгууллагаас энэ шашны өмч болон олон нийтийн өмчийг зохицуулахгүй. Энийгээ харин бид нар иргэний хууль болон төрийн бус байгууллага шашны хуулиараа зохицуулна аа. Энэ зэргээсээ эхлээд нэрүүдийг өөрчлөх зайлшгүй шаардлага байгаа гэдгийг би юун түрүүнд хэлмээр байна. Энэ доторх маш олон заалтуудыг бас эргэж авч үзэх ёстой. Жишээ нь төрийн нийтийн өмч дээр байгалийн дагалдах баялгуудыг тавьчихсан байна лээ. Эцсийн дүндээ байгалийн дагалдах баялгийн асуудал бол илүү их орон нутагтайгаа уялдаж бас яригдах ёстой. Энэ төрийн нийтийн өмчийн ангиллын цаана орон нутгийн эрх мэдлүүд хумигдах энийг бас ийм зүйл рүү явчих талууд байгаа. Тэгэхээр энийг ажлын хэсэг гарвал анхаарна биз.

Хоёрдугаарт энэ хуулийн үйлчлэх хүрээний том зүйл энэ хуультай л нийцүүлж бусад хуулиудыг гаргах гэдэг агуулгын цаана төрийн болон орон нутгийн өмчит компанийн хуулийн дагуу шийдэгдэх IP гэх асуудал энэ дээр жишээ нь хаягдчихаж байгаа юм. Гэх зэрэг би одоо тоочоод байвал маш олон асуудал байгаа. Тийм учраас яах вэ зүгээр хэлэлцэхийг гишүүд маань дэмжээд гаргах нь зүйтэй. Энхбаяр

гишүүнээр ахлуулсан ажлын хэсэгтэй нэгтгээд хэлэлцье гэсэн ийм горимын саналтай байна. Энэ дээрээ бид нар асуудлуудыг ултай суурьтай хандаад, яг энэ өмчийн харилцаа бүх юмнуудыг шийдмээр байгаа. Тэгээд яг хууль санаачлагчаас энэ хуулийн нэг 5 онцлогийг, 5 ач холбогдлыг энэ яг энэ парламентын чуулган үзээд сууж байгаа иргэд олон нийтэд өгөөч ээ. Энэ хуулиар батлаад явуулсан тохиолдолд яг ямар 5 асуудлыг шийдэх гэж байгааг бас олон нийтэд хүргэж өгөөч ээ гэж хүсэж байна. Ямар 5 ач холбогдолтой асуудлыг эрэмбэлж дурдаж болох вэ?

Тэгээд төслийг хэлэлцэхийг дэмжиж байна. Анхаарах зүйлүүд байна. Эргээд энийг тал талын төлөөлөл баймаар байна. Тал талын төлөөлөл. Тэгээд энэ бол үндсэндээ зөвхөн Эдийн засгийн байнгын хорооны асуудал биш шаардлагатай гэвэл Хууль зүйн байнгын хороо эсвэл Төрийн байгууллагын байнгын хороотой хамтарч хэлэлцэх ёстой. Энэ өөрөө эргээд цаана нь төрийн байгууламжийн нэгдмэл байдлын асуудал. Энэ хууль зүйн буюу өмчлөх эрхийг өмчүүдийг эдийн засгийн эргэлтэд яаж оруулах вэ гэдгийг иргэний эрх зүйн суурь асуудлууд энд яригддаг. Байгаль орчны эрх зүй цаашдаа буюу байгалийн баялаг ард түмэн үр өгөөжийг нь хүртэх үү, үгүй юу гэдэг асуудал. Эндээс орон нутаг ямар эрх хэмжээтэй байх юм бэ гэдэг асуудлыг энэ сууриар нь шийдэх гэж байгаа шүү. Тийм учраас энэ дээр хөнгөн гоомой хандаж болохгүй.

Тийм учраас Эдийн засгийн байнгын хороон дээр нэмэх нь бараг Хууль зүйн байнгын хороог хамтарсан байдлаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй болов уу гэж би бодож байна. Тэгээд хурлын дарга энэ дээр чиглэл өгөөч ээ гэж хүсэж байна. Тэгээд хууль санаачлагчаас хариултаа авъя.

Д.Амарбаясгалан: Эдийн засгийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдаан болж байгаатай холбогдуулаад Байнгын хорооны гишүүдийг орж ирж санал хураалтад оролц гэдэг зарыг хэлж өгөөч ээ гэж Байнгын хорооны дарга нараас хүсэлт ирсэн. Сандагийн Бямбацогт сайд хариулт өгье.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн нэлээн чухал асуудлууд хөндөж байна аа. Тэгээд нийтийн өмчийн хууль гээд яагаад нэрлэчихэв гэж. Нийтийн өмчийн бид Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Түүнд бас Монголын газар газрын хэвлийн баялаг, усны нөөц нийтийн өмч байна Монгол төрийн, ард түмний мэдэлд байна гээд заачихсан. Мөн бас Иргэний хуульд нийтийн өмч гэсэн тодорхой ойлголт байдаг. Энэ зохицуулалтуудад нийцүүлж Нийтийн өмчийн тухай хууль гэж энэ хуулийн нэрийг өөрчилсөн. Үүний өмнө та мэдэж байгаа байх. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх хууль гээд Их Хуралд өргөн баригдсан байгаа. Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр гишүүн ахалж байгаа. Энхбаяр гишүүн бас энэ хууль Төрийн нийтийн өмчийн хууль энэ ТӨК-ийн тухай хууль хоёр бол харилцан уялдаатай байх ёстой юмаа гээд одоо Их Хуралд өргөн барихаас нь өмнө энэ хуулийн ажлын хэсэгт ажилласан. Энэ хүрээндээ нийтийн өмч гэсэн нэршлээр явах нь зөв юмаа гэсэн саналыг бас Энхбаяр гишүүний зүгээс гаргаж байсан. Манай ажлын хэсэг хүлээж авсан гэдгийг нэгдүгээрт нь хэлье.

Тэр шашны өмч хөрөнгө, ТББ-ын өмч хөрөнгө эдгээртэй холбоотой асуудал энэ хуульд тухайлсан хуулиар зохицуулна аа. Нийтийн өмчийн тухай хуульд зохицуулагдаагүй асуудал заалтууд нь тухайлсан тэр шашны өмчийн тухай ТББ-ын тухай хуулиудаараа зохицуулна гэж орсон байж байгаа. ТӨК-удын IP хийх асуудал

бол ТӨК болон төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль Их Хуралд өргөн баригдсан хууль дээр Компанийн засаглалыг сайжруулах, компанийн тийм үү үйл ажиллагааг өргөтгөх энэ хүрээндээ бас ингээд боломж нь нээлттэй байгаа учраас тэр хуульд орчихсон учраас энэ хууль руу нэмж оруулах шаардлагагүй гэж үзсэн. Шинэлэг зохицуулалтууд юу байна гэж. Яах аргагүй өнөөдөр ингээд үндэсний баялгийн сантай болсон. Бид нар энэ байгалийн баялгийн өгөөжийг Монголын ард түмэн ирээдүй болон өнөөдөр амьдарч байгаа иргэддээ тэгш шударга хүртээх зарчмыг Үндсэн хуульд суулгаж өгсөн. Үүнийг хэрэгжүүлж байгаа стратегийн ордуудын, төрийн эзэмшиж байгаа тийм үү хувь хэмжээнээс иргэд маань ноогдол ашиг хүртдэг болох ёстой. Байгалийн баялгийн өгөөжийг. Үүнийг зохицуулах шаардлага байна.

Хоёрдугаарт нь ТӨК-иуд дээр эрх мэдэлтнүүдийн гар хөл болсон хүмүүс янз янзын асуудал тавьж очдог. Тэгээд тэндээсээ янз янзын хэл аманд ордог ийм асуудлууд их яригддаг аа. Тэгээд очиж байгаад л хулгай хийдэг, асуудал үүсдэг. Очиж байгаад л шахаа хийдэг. Очиж байгаад л шаардлага хангахгүй хүмүүсийг томилдог гээд иймэрхүү юмнуудыг цэгцэлье. Төрийн өмчийн үр өгөөжийг сайжруулъя, ашиглалтыг сайжруулъя, бүртгэл, хяналтыг сайжруулъя. Дээрээс нь тийм үү одоо еще илүү сайжруулах зүйлүүд олон байж байгаа. Үүнтэй холбоотой төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн зааг ялгааг тодруулъя. Улсын Их Хурал нь ямар эрхтэй байх. Засгийн газар нь ямар эрхтэй байх, өмчлөгч нь хэн байх, өмчийн удирдлагыг хэн хэрэгжүүлэх, өмчийн эзэмшигч нь хэн байх, орон нутагтаа ямар эрх мэдэлтэй байх вэ гэдгээс бүгдийг нь энэ хуулиуд дээр маш тодорхой зааглаж, ялгаж өгсөн байгаа. Мөн бас одоо энэ...

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

О.Номинчимэг: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Өчигдөр Эдийн засгийн байнгын хороон дээр хэлэлцэх эсэх асуудал дээр бас тодруулж асуусан. Ер нь яах вэ энэ хуулийг төрийн болон орон нутгийн өмчийн хуулийг шинэчилж найруулж орж ирж байгаа нь зөв зүйтэй. Энийг бид нар шинэчлэх цаг нь болсон. Гэхдээ бид нар ингээд нийтийн өмчийн тухай хууль гэж оруулж ирж байгаад ер нь нөгөө өмчийн ангилал гэдэг юмаа бүүр сууриар нь ойлгож байж явахгүй бол ингээд нэг үг үсгийг өөрчилснөөр бид нар энэ шинэчлэлийг нэгдүгээрт хийж чадахгүй болов уу л гэсэн байр суурьтай байгаа.

Тэгээд манайх нөгөө иргэний хуулиа нэг 2002 онд байгуулахад юу гаргахдаа нийтийн өмч гэдгийг нэг дотор нь 4 хуваагаад, хувийн өмч гээд ингээд нэг явчихсан юм байгаа. Тэгээд би болохоор энэ дээр бас жоохон шүүмжлэлтэй ханддаг хүмүүсийн нэг. Онолын хувьд энэ өөрөө энэ тодорхойлолт чинь зөв юм уу? Тэгээд яг үнэндээ манай салбарын мэргэжилтнүүд ч гэсэн, салбарын яам маань ч гэсэн яам маань ч гэсэн энэ олон нийтийн өмч гэдгийг тэгвэл юу ойлгох юм бэ гэдэг дээр нэгдсэн ойлголт байхгүй л сууж байгаа шүү дээ. Олон нийтийн өмчтэй холбоотой нэг л хууль гарсан. Тэр нь яг ийм онолын хувьд яг юу гэж ойлгох юм гэдэг нь тодорхойгүй тиймээ ийм байгаа.

Дээр нь 201.9 онд Үндсэн хуульд төрийн нийтийн өмч гэдэг нэг ойлголт орж ирсэн. Тэгээд яг энэ ойлголтууд иргэний хууль дээр байгаа ойлголтууд болон Үндсэн хууль дээр байгаа ойлголтуудын нэг зааг ялгааг гаргах гээд баахан ийм хуваарилалт юу гэдэг юм өмчийн ийм зааг ангилал гарч ирж байгаа нь бид нар яг сууриараа энэ чинь ямар утга учиртай, төрийн өмчийн, нийтийн өмчийн ямар

зориулалттай байх юм гэдэг юм руугаа орж чадахгүйгээр л зүгээр нэр томъёоны өөр юм руугаа л ингээд л нэр томъёондоо тааруулж нэг ийм нэг хуваарилалт хийсэн юм харагдаад байна гэж харсан энэ хууль дээр. Тэгэхээр энийгээ ер нь бол нэг засмаар байгаа юм.

Иргэний хуулийн хэрэгжилтийн дүн шинжилгээг одоо Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаад 42 салбарын судлаач мэргэжилтнүүдтэй хамтраад энийг дүгнэлт гаргасан. Тэгээд намар .9 сарын сүүлээр юм уу 10 сард энэ талаар салбарынхантайгаа нэлээн том эрдэм шинжилгээний хурал хийе гэж бодож байгаа. Энэ үед ер нь бид нар энэ нийтийн өмч гэдэг ойлголтыг яаж харах ёстой юм. Ямар ангилал байх ёстой юм, ямар зориулалтаар нь ангилаад байгаа юм уу, юугаар нь эх үүсвэрээр нь ангилаад байгаа юм уу. Энийгээ нэг тодорхой ярьж байж энэ дээр байгаа энэ нэг нийтийн өмч, төрийн өмч төрийн нийтийн зориулалттай өмч орон нутгийн өмч гэдэг юмаа нэг ялгаж зааглаж авахгүй бол ерөөсөө энэ ялгаа заагийг ерөөсөө сайн гаргаж чадахгүй байна.

Орон нутгийн өмч гэдэг ойлголт манай Үндсэн хуульд байхгүй. Анх төрийн болон орон нутгийн өмчийн хуулиар орж ирсэн. Энэ иргэний хууль дээр бас нэг ийм юм байгаа юм. Тэгэхээр орон нутгийн өмч яаж бий болдог юм бэ гэдгээ ч гэсэн бид нар харах ёстой. Орон нутаг л юм чинь заавал өмчтэй байх ёстой гэдэг бас биш. Орон нутгийн бид нар нөгөө эх үүсвэрээр нь өмчөө ялгаад байна уу, зориулалтаар нь ялгаад байна уу гэдгээсээ хамаараад энийгээ хийхгүй орон нутаг төсөв л гаргасан юмыг чинь манай өмч, бид нар л хариуцах ёстой гэдэг бас нэг юм байж боломгүй байгаа юм зарчмын хувьд. Тэгээд энийг харж байж бид нар энэ хууль дээр байгаа сум, дүүргийн өмч гэж юуг хэлэх гээд байгаа юм гэдгийг бас нэг нарийвчилж харахгүй энэ өөрөө түрүүн Сайнзориг гишүүний хэлсэн Засаг даргын нутаг дэвсгэрийн нэгжтэйгээ яаж холбогдох юм гээд нэлээн том асуудал байгаа. Тэгэхээр энийг яах вэ мэдээж хэлэлцэх эсэхийг нь шийдэх хэрэгтэй байх дэмжээд. Ажлын хэсэг бол энэ дээр маш нарийн ажиллах ёстой.

Дээр нь энэ бол бараг Эдийн засгийн байнгын хорооны асуудал гэхээсээ илүү энэ бараг Төрийн байгуулалт, Хууль зүйн байнгын хорооны асуудал харагдаад байгаа юм. Нийтийн өмчийн тухай хууль ерөөсөө тэр чигээрээ нийтийн эрх зүй хувийн эрх зүй ч биш нийтийн эрх зүйн асуудал. Энийг яаж менежмент хийж регуляц хийж, нийтэд ашиг тусыг нь өгөхийн төлөө энийг хийх вэ гэдэг зорилго байх ёстой. Тэгэхээр энэ маань өөрөө энэ захирах засаг захиргааны нэгжтэйгээ холбогдож байгаа асуудал. Менежментийн асуудал эд нар нь орж ирж байгаа учраас энийг Хууль зүйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо хэрвээ шаардлагатай бол хамтарч бас хэлэлцээд нарийн хэлэлцэхгүй энэ маш том суурь хууль. Суурь хуулиа бид нар онолын суурь ялгааг нь бас нэг талдаа гарч ойлгож байж хийхгүй дараа нь дахиад л нэг өмнөх хууль шигээ нэг зэрэмдэг хууль болчих вий дээ гэсэн болгоомжлол байна. Тэгэхээр энийг яах вэ хэлэлцэхийг нь дэмжээд дараа нь нэлээн нарийвчилж ажиллах ёстой шүү л гэдэг байр суурийг илэрхийлье дээ.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт сайд хариулт өгье.

С.Бямбацогт: Тантай санал нэг байна аа. Энэ нийтийн өмч гэсэн ойлголтыг цэгцлэх ёстой гэж. 201.9 онд бид Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийж байхад энэ газар газрын хэвлийн баялаг, ойн усны нөөц тийм үү ард түмний мэдэлд байна аа, Төрийн нийтийн өмч байна гээд заалт орохоос авхуулаад л нийтийн өмчийн талаар

маргаан нэлээн их яригдаж эхэлсэн. Үүнтэй холбоотой өнөөдөр яг таны ярьж байгаа сая тийм үү нийтийн эзэмшлийн зам, талбай, гудамж, цэцэрлэгт хүрээлэн, гэрэл чийдэн гээд юу байдаг юм энэ бүгдийг нийтийн өмч гээд бид нар ингээд бүртгэдэг. Үндсэн хуульдаа бол тэр саяын ярьсан асуудлуудыг нийтийн өмч гээд бүртгэдэг. Гэтэл нийтийн өмч гээд Иргэний хуульд заасан томъёолол дээр бол тэр ТББ шашны байгууллагуудын өмч бол нийтийн өмч өө гээд заачихсан байдаг.

Тэгээд үүнийг бол бид энэ хууль дээр төрийн нийтийн өмч гэдэг нь энэ юмаа гэдгийг бол маш тодорхой зааж өгчхөөд. Тухайлсан хуулиар тэр ТББ-ын нийтийн өмч нь энэ юмаа, шашны байгууллагууд нийтийн өмч нь энэ юмаа, улс төрийн намуудын нийтийн өмч нь ийм юмаа гэдгийг тухайлсан тухайлсан хуулиар нь. Одоо Үндэсний олон нийтийн радио телевиз гэхэд чинь бас олон нийтийн байгууллага нийтийн өмчтэй. Улс төрийн намууд чинь өөрсдийн байшин барилгатай, сав хөрөнгөтэй, нийтийн өмчтэй тэрийг одоо хуваагаад тараагаад аваад явчихдаггүй. Тэгээд энэ бүгдийг бас нэлээн сайн нарийвчилж зохицуулах шаардлага үүсэж байгаа. Энэ хуулийг хэлэлцэж байх явцад шаардлагатай бол Засгийн газраас мөн Улсын Их Хурлын гишүүд тухайлсан хуулиудыг шашны байгууллагуудын нийт нийтийн өмч гэж ийм зүйл байх юм. Энийг ингэж зохицуулна. Төрийн бус байгууллагуудын нийтийн өмч ийм зүйл байх юм. Энийг ингэж зохицуулна гээд тухайлсан хуулиудыг хамтад нь ингээд Улсын Их Хуралд өргөн бариад хэлэлцүүлээд явчих. Тэгээд ингээд нэг тийшээ олон жилийн үргэлжилсэн энэ тодорхой бус ойлгомжгүй байдлыг нэг цэгцлэх нь зөв байх аа. Энэ дээр та бүхэн анхааралдаа аваасай гэдгийг нэгдүгээрт нь хэлье.

Хоёрдугаарт нь орон нутгийн өмчийн ойлголт Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хууль нь ч нутгийн удирдлагын байгууллага байдаг. Нутгийн удирдлагын байгууллага, аймгийн иргэдийн хурал, нийслэлийн иргэдийн хурал, аймаг, нийслэлийн Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд тодорхой тийм үү шаардлагатай хүч, нөөц хэрэгсэл хэрэгтэй. Үүнтэй холбоотойгоор орон нутгийн өмчийн асуудал үүсэж байгаа. Урьд нь ч ийм байсан. Урьд нь байсан харилцаа нь хамгийн гол нь тодорхойгүй, ойлгомжгүй, зохицуулсан зохицуулалт байхгүй, үүнээсээ болоод орон нутгийн өмч хөрөнгө шамшигддаг, үрэгддэг, орон нутгийн өмчийг бий болгож байгаа төсвийн хөрөнгөөр бий болгож байгаа мөртөө эцэст нь ингээд нэг мэдэхэд алга болчихсон, бүртгэл хяналт байхгүй. Ийм байдаг байсан бол үүнийг бас энэ хуульдаа нэлээн тодорхой оруулж өгье. Орон нутгийн өмчийн орон нутгийн захиргааны байгууллагыг тийм үү энэ бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай орон нутгийн өмчийг хяналтад авах, бүртгэх, дээрээс нь шинээр бий болгох энэ асуудлыг энэ хуулиар илүү тодорхой...

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Дагалдаж гарч байгаа хуулиудтай хууль тогтоомжуудтай холбоотой илүү асуултыг асууя. Нэгдүгээрт энэ нийтийн өмчийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4.4 дээр Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагаас бусад төрийн байгууллагын дэргэд үйл ажиллагаа явуулж байгаа амралт, сувиллын газар, спорт соёлын төв зэрэг чиг үүрэгт нь хамаарахгүй хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдана гэсэн нэг ийм зохицуулалт орж ирж байна. Тэгээд яг үүнтэй холбоотой одоо жишээ нь тухайлбал Эрдэнэт үйлдвэрийн дэргэдэх том спорт цогцолбор байгаа. Энийг жишээ нь хувьчилна гэсэн үг үү? Тэгэхээр үүнтэй холбоотой үүсэх хэчнээн байгууллага, хэчнээн өмч хөрөнгө байгаа юм, ямар хугацаанд юм, хэрхэн энэ дуудлага худалдааг зохион байгуулах

юм, энд ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын эрх ашгийг хэрхэн дордуулахгүй, хохироохгүй байх юм гэдэг ийм бодлого тодорхой зохицуулалт ерөөсөө энд ороогүй байна аа. Энэ дээр судалгаа мэдээлэл байвал өгөөч гэж байгаа юм нэгдүгээрт.

Хоёрдугаарт бас яг энэ дагалдаж байгаа хуулийн 6.1 дээр энэ орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, МСҮТ, Политехникийн коллежийг нийтийн үйлчилгээний байгууллага гэнэ гээд заачихсан. Их дээд сургуулиуд яах юм. Их, дээд сургуулийн асуудлыг ер нь хэрхэн харж байгаа вэ энэ хуулиар. Үүнтэй холбоотой бас нэг зүйл ерөөсөө дандаа орхигдоод явдаг дотуур байрны асуудал. Энэ сургуулийн дотуур байрны асуудал бүх аймаг, сумдад байгаа энэ дотуур байрны асуудлыг яах вэ гээд. Яг энэ нийтийн өмчтэй холбоотой дагалдаж гардаг мэдээж өмчлөл захиран зарцуулалтай холбоотой зүйлүүд дээр манай гишүүд саналаа хэлчихлээ. Энэ урсгал зардлын асуудал маш хүнд байдаг. Ялангуяа урсгал зардал өндөртэй сургууль, цэцэрлэг гээд ингээд эдгээр зүйлүүдийг орон нутагт нь өгөөд, орон нутаг нь өөрөө тэр ардчилал хамгаалалт гээд ингээд бүх зүйлүүдээ хариуцах болдог. Эргээд нөгөө талаар энэ маань өөрөө нөгөө цэцэрлэг, сургууль, боловсролын үйлчилгээ, эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний чанарыг дордуулах, чанар муутай байх энэ дотуур байрны хүүхдүүдийн асуудал гээд олон нийгмийн сөрөг үр дагаврыг дагуулаад байдаг аа. Тэгэхээр яг энэ хуулиар зардлын асуудлыг ер нь яаж харж байгаа вэ. Одоогийн байгаа концепцоороо явж байгаа хэвээрээ юу гэдэг нэг ийм асуулт байна.

Гуравт нь, нэг дагалдаж байгаа нэг хууль нь жаахан анхаарал татаад байна. Би буруу ойлгосон байж магадгүй. Хэрвээ буруу ойлгосон бол залруулаад хэлээрэй. Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд дагаад өөрчлөлт орж байна. Энэ дээр банкны салбарын энэ хуулийн 12.3 дахь хэсгийг хүчингүй болгоно буюу өөрөөр хэлбэл ТУЗ-үүдийг байхгүй болгож байгаа юм уу гэсэн ийм асуулт үр дагавар нь гарч ирээд байна. Тэгэхээр жишээ нь Төрийн банкны асуудал энүүгээр хэрхэн зохицуулагдах юм. ТУЗ-тай байх юм уу, ТУЗ-гүй байх юм уу. Энэ тогтвортой байдлыг хангах тухай хуулийн энэ үйлчлэлд энэ төрийн өмчийн банк нь яах юм, орох юм уу, орохгүй юм уу гэдэг ийм асуудал урган гарч байна. Тэгэхээр энэ хуулийг хэлэлцэх эсэхийг мэдээж дэмжээд явах явна. Тэгэхдээ манай Хууль зүйн байнгын хороогоор орох, хоёрдугаарт, гэвэл бас энэ яг энэ хууль хэрэгжсэнтэй холбоотой үүсэн гарах энэ хөрөнгийн хөдөлгөөний асуудал бас нэлээн анхаарал татаж байна аа. Тэгээд мэдээлэлд ойр хэн нэгэн хэсэг бүлэг этгээдүүдийг завших ийм цонх үүсэж байгаа байх вий гэдэг болгоомжлол байна.

Д.Амарбаясгалан: Бямбацогт сайд хариулт өгье.

С.Бямбацогт: Таны тэр сүүлийн асуултаас эхэлье. Санаа зовж байгаа. Яах аргагүй одоо гэдэг юм. Мэдээлэлд ойр хүмүүс нь илүү завшдаг, хождог, мэдээлэлгүй иргэд нь хохирдог ийм зүй тогтол юу гэдэг юм өнгөрсөн энэ өмч хувьчлал эхэлсэн цагаас хойш 1990 онд цэнхэр, ягаан тасалбар аваад, түүгээрээ баахан үйлдвэр завод төрийн өмчит томоохон компаниудыг хувьчлаад авчихсан, дараад нь одоо бас дуудлага худалдаа яваад үүгээрээ бас мэдээлэлд ойр хүмүүс нь түрүүлээд хожчихсон, мэдээлэлгүй иргэд нь хохирчихсон ийм асуудлууд байдаг. Энэ асуудлууд одоо ч байгаа ер нь энэ цаашдаа ч байж болзошгүй. Ерөөсөө иргэдийн төрд итгэх итгэл алдарч байгаа нэг шалтгаан бол энэ ТӨК-иудын засаглалын тийм үү чадамжгүй байдал, энэ ТӨК дээрээ хэтэрхий үр ашиггүй, үрэлгэн зардал ихтэй дундаас нь хувьдаа завшдаг, тиймэрхүү ийм нөхдүүд шургалж орсон байдал. Тэгээд энэ бүгдийг л энэ хуулиар цэгцэлье гээд үндсэндээ энэ ТӨК-иудын хууль төрийн

өмчийн асуудлаа шийдвэрлэе гээд олон жил ярьсан. Олон жил ярьсан боловч шийдэж чаддаггүй шийдэх гээд Их Хурал руу ороод ирэхээр ямар нэгэн арга саамаар гацаадаг. Тэгээд л нөгөө ард талд нь дахиад л нөгөө завшдаг, шамшигдуулдаг, мэдээлэлд ойр хүмүүс нь илүү хождог байдал нь хэвээр хадгалагдаж олон жил явж ирсэн. Үүнийг л цэгцэлье. Үүнийг ил тод болгоё, нээлттэй болгоё, төрийн өмчийн хөрөнгийг үр өгөөжтэй болгоё, нэгдсэн цогц удирдлагатай, эрх мэдлийн хуваарилалтыг нь оновчтой болгоё гэдэг үүднээс энэ хуулийг оруулж ирж, зайлшгүй хэлэлцэх цаг нь болсон гэж үзэж байгаа.

Улсын Их Хурал дээр хэлэлцэх эсэх нь шийдэгдэх юм бол ажлын хэсэг гараад ажиллах байх. Таны санаа зовж байгаа асуудлууд тэр батлан хамгаалах, хилийн цэрэг, бусад хүчний байгууллагуудад бусад газарт байгаа Соёлын төв, спорт заал, амралт сувиллын газрыг татан буулгана гэдэг чинь санаа зовоож байна гэж. Одоо УБТЗ манай Эрдэнэт үйлдвэр гээд олон томоохон компаниудын дэргэд нийгмийн хариуцлагыг хүлээн чирч явдаг сургууль, цэцэрлэг, соёлын төв, спорт заалууд байдаг. Гэтэл юу гэдэг юм тухайн байгууллага өөртөө давуу байдал, өөртөө юу гэдэг юм илүү тааламжтай байдал үүсгэхийн тулд нэмэлт шаардлагагүй зардал гаргаад байгуулчихсан амралт, сувиллын газрууд байдаг. Энэ бүгдийг үндсэндээ бол тодорхой хэмжээнд цэгцэлье. Хэрхэн яаж цэгцлэх вэ гэдэг дээрээ бас харин Их Хурал дээрээ ярьж байж шийдье гэдэг үүднээс өнөөдөр оруулж ирж байгаа юм. Тэгэхгүй бол тэгээд л ТӨК ашигтай ажилладаг, ашигтай ажиллангуутаа ашгаасаа тодорхой хувиар нь өөрийнхөө дэргэд амралт, сувиллын газар байгуулчихдаг. Үүндээ илүү юу гэдэг юм ажилтан, албан хаагчид амрааж байгаа нэртэй боловч өөрсдөө илүү тийм аятай тухтай байдал бий болгодог иймэрхүү байдлуудыг л цэгцэлье ээ. Хэрхэн яаж цэгцлэх вэ гэдгээ бас бид оруулаад ирье. Их Хурал дээр манай ажлын хэсэг гараад ажиллаад цэгцлэх талд нь анхаарал тавих байх аа гэж бодож байгаа юм аа.

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индрээс хариулт өгье.

Д.Сүнжид: Баасанжаргал гишүүний асуултад нэмэлтээр хариулъя аа.

Банкны тогтвортой байдлын тухай хууль дээр бол энэ хуулийн нэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор орж ирсэн зохицуулалт байгаа. 12.3 дахь хэсгийг бол хүчингүй болгох энэ зохицуулалт байна. Энэ нь болохлоор ерөнхийдөө энэ дахин хөрөнгөжүүлсэн банканд ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага нь бол энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан төрийн төлөөллийг томилох, төрийн төлөөлөлд баримтлах удирдамжийн энэ заалтууд байгаа хамаарч байгаа учраас энэ нь бол нийтийн өмчийн тухай хуулиараа хамаарахгүй хүчингүй болж байгаа. Нөгөөтээгүүр нөгөө төрийн болон орон нутгийн өмчийн компанийн засаглал ил тод байдлын тухай хуулийг хуулийн төсөл явж байгаатай холбоотойгоор энэ заалт шаардлагагүй болсон учраас ингээд хүчингүй болгож байгаа юмаа.

Хуулийн төсөлд бол нийтийн үйлчилгээний байгууллагын ийм эрх зүйн одоо ингээд Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийг үндсэндээ 3 ангилалд хуваагаад, төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага, ТӨК гэсэн ийм 3 үндсэн ийм хэлбэртэй байхаар...

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя 4 дүгээр индэр.

Д.Сүнжид: Нийтийн үйлчилгээний байгууллагын тодорхой зохицуулалтуудыг энэ хуулийн төслийн 16 дугаар зүйлд тусгасан байгаа. Энэ дээр бол ерөнхийдөө хуулийн төрийн байгууллагын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор нийтийн үйлчилгээний байгууллагыг байгуулж болно гэчихсэн дүрэм журмыг нь Засгийн газар батална аа гээд ийм зохицуулалттай юм. Харин бол энэ 16.5 дахь хэсэг дээр бас нэг тусдаа зохицуулалт байгаа. Энэ бол Их Хурлын дэргэд үйл ажиллагаагаа тайлагнадаг, Их Хурлаас байгуулагддаг нийтийн үйлчилгээний байгууллагын асуудал. Нөгөө талаар боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа нийтийн үйлчилгээний байгууллагын асуудлыг тухайлсан хуулиараа энэ дүрэм журмыг нь батлаад явах ийм засаглал буюу удирдлага зохион байгуулалтын асуудлыг нь зохицуулах ийм зохицуулалт байгаа учраас энэ дагаж мөрдөх журмын хуулиараа энэ эмнэлэг, сургуулийн асуудал хуулиараа явчих юмаа. Яг энэ одоо хамрахгүй сургууль, цэцэрлэгт нийтийн үйлчилгээний байгууллага болохгүй гэсэн үг бол биш юмаа. Энийг бол нэг жилийн хугацаанд шийднэ. Гэхдээ өнөөдрийн хугацаанд бол энэ Боловсролын тухай хуулиа эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулиараа энэ байгууллагуудын засаглал нь өөрөө тодорхойлогдоод...

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн тодруулж асууя.

Х.Баасанжаргал: Би яг дотуур байран дээр яг жишээ татаад ярья. Ингээд яг юу гэдэг юм тухайн аймаг орон нутаг сум дээр үйл ажиллагаа явуулж байгаа сургуулийг яг энэ хуулиар зохицуулаад нийтийн үйлчилгээний байгууллага гээд зохицуулчихдаг. Дотуур байрыг нь тусад нь Боловсролын тухай ерөнхий хуулиараа зохицуулна гээд ингээд салгачихдаг. Гэтэл дотуур байрны арчлалт хамгаалалт, тэнд явж байгаа хүүхэд хамгааллын үйлчилгээ, тэнд байгаа боловсролын үйлчилгээ тэнд чинь хүүхэд 24 цаг амьдарч байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ зүйлүүд чинь ерөөсөө эргээд энэ нөгөө тухайн аймаг орон нутгийн удирдлага энэ дээр бас хариуцлага хүлээхгүй болчихоод байдаг. Тэгэхээр энийг нэг та хэд маань нэг жаахан ньуанстай харж өгөөч ээ.

Их, дээд сургууль тэр Боловсролын ерөнхий хуулиараа их, дээд сургуулийн Их, дээд боловсролын тухай хуулиараа зохицуулах юм байна гэж ойлголоо тиймээ. Тэгэхдээ яг энэ дотуур байрны гэх мэт яг нэг ийм нэг үлдээд байдаг энэ нэг байгууллагуудаа та хэд маань харахгүй бол ялангуяа дотуур байр маш хэцүү, маш төвөгтэй хаана ч эзэн нь харьяалагддаггүй ийм байгууллага болчихоод байдаг юм шүү гэдгийг...

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Тийм таны санаа зовж байгаатай яг санал нэг байгаа. Одоо өргөн мэдүүлж байгаа хууль дээр бол цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орон нутгийн өмчид байна гээд ингээд оруулж байгаа. Орон нутгийн өмчид байгаа. Нийтийн үйлчилгээний байгууллагуудыг байгуулах эрх нь бол Улсын Их Хуралд байж байгаа. Нийтийн үйлчилгээний байгууллага зайлшгүй байх ёстой. Тэр нийтийн үйлчилгээний байгууллага болон түүнд өмчлөгдөж байгаа өмч хөрөнгийг хэрхэн яаж тийм үү зөв зарцуулах вэ, зөв зохистой ашиглах вэ, үр өгөөжтэй байлгах вэ гэдэг дээр нэлээн томоохон ТӨК-иуд юу гэдэг юм бүгдийг нь ашигтай ажилла гэхгүй. Бид нийтийн үйлчилгээний байгууллагуудаа илүү нийгмийн хариуцлага хүлээж, төрөөс ард иргэдэд үзүүлэх тийм үү төрийн үйлчилгээг хүргэж байгаа учраас илүү юу гэдэг юм анхаарах ёстой гэдэг агуулгаар бол ингэж салгаж өгч байгаа юмаа. Тэгээд

төрийн болон нөгөө юуг Компанийн тухай хууль, бусад хуулиудад нийцүүлж ингэж уялдуулж өгөхгүй бол өнөөдрийн байж байгаа хуулиудтай нийцэхгүй байгаа учраас ингэж төрийн бус комп...

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Ерөнхий ийм хуультай байх нь зүйтэй. Тэгээд түрүүний гишүүдийн хэлсэнчлэн нэлээн олон асуудлууд орхигдчихсон байна уу даа гэж харж байна. Дээрээс нь нэмээд ерөөсөө хамгийн чухал иргэдийн бухимдаад байгаа асуудлууд нь нэгдүгээрт энэ төрийн өмчийг ер нь их шамшигдуулж байна аа, хөрөнгийн үнэлгээ яг үнэн бодит байж чадахгүй байна аа гэдэг асуудал. Энэ асуудал нэлээн жоохон дутмаг орхигджээ гэж харж байна. Энэ дээр ингэж бичсэн байна л даа 67.3.1 дээр тухайн хөрөнгийн бүртгэлийн үнэ зах зээлийн үнээс материаллаг хэмжээний зөрүүтэй болсон бол гэж. Тэрүүнийг одоо хэн тогтоох вэ? Миний бодлоор одоо бол ихэнхдээ зах зээлийн үнээс асар их ялгаатай. Тэрүүнийг хэн ч тогтоохгүй, хэн ч тэрүүн дээр акт тавихгүй байгаа байх. Ингээд бид нар уг нь бол хувийн хэвшил яадаг вэ гэхээр өөрснөө тэрүүн дээрээ засвар үйлчилгээ хийе гэх юм тэр бараг үнээрээ хөрөнгийн үнийг нь нэмэгдүүлээд явдаг. Сургууль дээр гэж байхад хэрвээ урсгал зардал хийсэн бол их хэмжээний засвар ингээд үйлчилгээ хийсэн бол үнийг нь хөрөнгийн үнэлгээг нь өөрчлөөд бүртгээд явдаг.

Манай дээр бараг тэгнэ гэж бараг байдаггүй. Яг үнэнийг хэлэхэд сүүлийн 40 хэдэн жилийн настай сургууль шүү дээ. Одоо актлахад бэлэн гээд байдаг байхгүй юу. 40 хэдэн жил дотроо бараг жил болгон засвар урсгал засвар хийгээд ахиад 4-5 жил тутамд их засвар хийчихсэн байгаа мөртөө л тэр нь ерөөсөө бүртгэгдэхгүй яваад байдаг. Ингээд явж явж байгаад төрийн өмчийг яадаг вэ гэхээр хөрөнгийнх нь үнэлгээг нь ерөөсөө шинэчлэхгүй эсрэгээрээ элэгдэл хорогдлыг тооцож явсаар байгаад энэ бол ерөөсөө одоо бол энийг ашиглахын аргагүй болсон. Тайлан баланс дээр бараг 0-ээр бүртгэж байгаа шахам юм ярьж байгаад хэн нэгэн хувьчлаад авчихдаг. Тэгэхээр хамгийн иргэдийн бухимдаад байгаа энэ асуудал чинь энэ хууль дээр чинь төдийлөн сайн сууж өгөөгүй юм биш үү? Тэгээд үүнийгээ ажлын хэсэг өөрснөө та бүхэн маань юу гэж харж байгаа юм бэ нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Би бол одоо энэ өмчийн мэдээллийн сантай болох ёстой гэдэг дээр бол маш их санал нийлж байгаа. Одоо Төрийн өмчийн хороон дээр миний бодлоор төрийн өмчит хэдэн компанийн л мэдээлэл байх шиг байгаа юм. Дээрээс нь нэмээд мэдээллийн сангаа бүртгэж байгаа цахим систем нь Бямбацогт сайд аа. Энэ гадаадаас буцалтгүй тусламжаар ч гэнэ үү, үнэгүй шахам авсан нэг системтэй тэгээд үнэгүй юм л үнэгүй л юм байдаг байхгүй юу. Тэрүүний аюулгүй байдал нэгдүгээрт, хоёрдугаарт дээрээс нь нэмээд ахиад дээрээс нь нэмээд уг нь энэ чинь бүх талаараа л Монголын төрийн өмчийг бүртгэж байгаа систем хамгийн аюулгүй хамгийн сайн байх ёстой, энэ бүх зүйл хангагдахгүй байна аа. Тэгээд үүн дээрээ нэг жоохон ач холбогдол өгөөд, мөнгө төгрөгөөр нэг сайн юм нэгдүгээрт худалдаж авч бай. Тэгэхээр энэ төрийн өмчийн систем дээр улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс, дээрээс нь нөгөө буцалтгүй тусламжаар төрөөс өгч байгаа саяхан жишээлбэл Хэнтий аймагт баригдсан нисэх онгоцны буудал гэхээр ийшээгээ би бүртгэгдэнэ л гэж ойлгож байгаа. Энэ зөв үү? Бүх төрөөс улсын төсвөөс баригдаж байгаа бүх өмчүүд энэ дээр бүртгэгдэнэ гэж.

Тэгвэл үүн дээрээ бас засвар үйлчилгээ хийх юм бол улсын төсвөөс ахиад засвар хийдэг. Тэгэх юм бол тэрүүнийгээ яаж бүртгэх юм бэ? Уг нь би бодохдоо юу

гэж бодож байна гэхээр хувийн хэвшлүүд бүүр тийм байдаг. Бүх өмчүүдээ бүртгээд бараг тэрүүн дээр нь ингээд цааш нь дарангуут хэдэн онд, ямар компани, ямар засвар хийсэн, далд ажлынх нь зураг бүх мэдээллүүд нь нэг дор байж байдаг. Тийм байж чадах уу, үгүй юү? Мэдээллийн сангууд нь. За ингэж байж энэ бол аюулгүй ажиллагаа бүх зүйлүүд нь хангагдана аа.

Дараагийн нэг зүйл нь энэ төрийн өмчийнхөө бид нар ингээд ер нь л улсын төсвөөс ийм их юм бариад байх тусам л төрийн өмч улам их нэмэгдээд байна. ДНБ-д. Одоо нийтдээ ер нь төрийн өмчөө та бүхэн маань бүртгэсэн нь ингээд сургууль цэцэрлэг хамаг юмаа ороод ер нь хэдэн их наяд байна гэж үзэж байна вэ? Би санаж байгаагаар нэлээн хэдэн жилийн өмнө шүү дээ. ТӨК-иудынхыг л бид нар яриад байдаг байсан. Орон нутгийн өмчийнхийг оруулаад төрийн өмчийнхийгөө, дээрээс нь улсын төсвөөр орон нутгийн төсвөөр баригдсан бүх энэ өмчүүдийгээ нийлүүлээд ер нь хэд байна гэж үзэж байна вэ? Зохист харьцаа гэж ер нь олон улсад байдаг юм уу? Энүүнтэй харьцуулах юм бол ямархуу...

Д.Амарбаясгалан: Бямбацогт сайд хариулт өгье.

С.Бямбацогт: Маш чухал асуулт асууж байна аа Булгантуяа дарга. Энэ улсын төсвийн хөрөнгөөр, орон нутгийн төсвийн хөрөнгөөр төрийн болон орон нутгийн өмчүүд нэлээн бий болдог. Түүний бүртгэх, хяналт тавих, үр ашигтай ашиглах, зарцуулах тал дээр бол өнөөдөр үнэхээр асуудалтай болчихсон. ТӨБЗГ нэг 60-аад хүнтэй. Орон нутагт нэг төрийн өмчийн төлөөлөгч орон нутгийн өмчийн газар гээд нэг хэдэн хүн байдаг. Тэдгээр нь ерөөсөө юу хийж байгаа, яаж байгаа нь ерөөсөө мэдэгддэггүй. Тийм учраас үндсэндээ өнөөдөр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө бол үр ашиггүй, үр өгөөжгүй тэгээд л бий болж байдаг. Араас нь асуудал бол нэг сагсны талбай байгуулдаг тийм үү. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр тэгээд л нэг мэдэхэд эвдрээд хамхраад алга болчихсон. Тэрнээс нь араас нь бүртгэсэн хүн ч байхгүй, яагаад эвдэрснийг хянадаг ч хүн байхгүй алга болчихдог. Нэг цэцэрлэгт хүрээлэн байгуулдаг, нэг багийн төвд хөгжим аппаратур аваад өгдөг, багийн төвийг засаад өгдөг, тэр нь ерөөсөө ямар ч тийм бүртгэл байдаггүй, хяналт байдаггүй. Орон нутагт үнэхээр өмч маш их цалгардсан, маш үр ашиггүй үр өгөөжгүй болж байгаа. Үүнийг бүртгэдэг, хянадаг, нэгтгэдэг байя аа.

Нөгөө талаас нөгөө ТӨК-иуд одоо Эрдэнэс Монголоос авхуулаад ЭТТ Эрдэнэт гээд л энэ томоохон компаниуд энэ дээр чинь бас л нөгөө төрийн өмчийг үнэ цэнгүй болгох, эсвэл шахаа хийх иймэрхүү асуудал байнга л байж байдаг. Энэ тэгээд л нүдээ харсан ч хараагүй юм шиг ингээд л явж байдаг. Энэ бүх байдлыг л үндсэндээ цэгцэлье гэдэг үүднээс энэ Нийтийн өмчийн тухай хуулийг өргөн барьж байгаа. Энэ дээр ТӨБЗГ тодорхой чиг үүрэгтэй оролцохоор болж байгаа. Энд үндсэндээ төрийн өмчийн бүртгэл, тооллого, мэдээллийн сан, ил тод байдлыг бүхэлд нь ТӨБЗГ, ТӨХ бол Засгийн газрыг тохируулагч агентлаг болж хариуцах юм аа. Энэ тооллогоо бүтэн хийдэг байх, бүртгэлийг нь хийдэг байх. Одоо төрийн нийтийн өмчийгөө тоолдог байх. Урьд нь бол нийтийн өмчөө тоолдоггүй байсан зөвхөн барилга байшингаа тоолдог байсан, нийтийн өмчөө тоолдог болох. За төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн сантай болох.

Мөн өмчийн төлөв байдлын тайланг одоо зөвхөн нөгөө санхүүгийн тайланг нэгтгэж аваад тараадаг тийм үү, одоо өмчийн төлөв байдлын тайлан ашиглалт нь ямархуу байгаа юм таны хэлж байгаа, түүн дээр элэгдэл хорогдол нь ямар байгаа юм. Их засвар хийсэн болоод өртөг нь нэмэгдсэн юм уу, нэмэгдээгүй юм уу энэ

бүгдийг нь нэгтгээд ингээд тайланг олон нийтэд нээлттэй танилцуулдаг болох. Мөн яг үүнийгээ хэрэгжүүлэх зорилгоор цахим системээр цахим мэдээллийн нэгдсэн сантай болох төрийн өмчийн. Тэр нь дуртай хүн нь ороод үзэж байдаг. Аль аль аймагт ямар хөрөнгө, ямар үнээр бий болсон байна түүн дээр ямархуу засвар үйлчилгээ хийгдсэн байна түүнд нэмэлт их засвар, нэмэлт хөрөнгө оруулалт юу хийгдсэн байна бүгдийг нь үзэж байдаг, түүнийг нь буцаагаад эцсийн үлдэгдэл үнэ өртөг нь ямар байгаа юм гэдгийг нь бүгдийг нь ард иргэд нээлттэй хянадаг байх энэ тогтолцоог энэ хуулиар бий болгоё гэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Х.Булгантуяа: Дээрээс нь нэмээд бид нарын бас нэг аягүй их ярих ёстой юм нь ер нь ямар юман дээр төрийн өмч үүсэх ёстой юм бэ гэдгийг та бүхэн маань энүүгээр харилцаагаа зохицуулж чадсан уу? Сая жишээлбэл бид нар гэв гэнэт саяхан мэдлээ шүү дээ. Хөвсгөл аймагт төрийн өмчөөр зах байгуулсан юм байна аа. Уг нь улсын орон нутгийн өмчөөр, тийм орон нутгийн өмчөөр. Уг нь улсын төсвөөр орон нутгийн төсвөөр ч мөн адилхан ашиг олох объект хөрөнгө оруулалтууд хийх ёсгүй. Гэтэл яагаад хэрвээ энийг чинь зах худалдааны төвүүд бараг бүх аймагт хувийн хэвшил байгуулчихсан юм шүү дээ. Энэ хамгийн ашигтай бизнес байдаг бүүр хамгийн хамгийн ашигтай. Зах худалдааны төвийн боссууд бол бараг бүгд аймгийнхаа иргэдийн хурлынхаа төлөөлөгч байдаг. Тэр хүнтэй бараг ярихгүйгээр аймаг орон нутгийн улс төр явдаггүй хэмжээний тийм ашигтай бизнес байдаг юм шиг байгаа юм. Тэгэхэд миний гайхаад байгаа нь яагаад төрийн өмчит тэгвэл ийм зүйлүүдийг үүсгэн байгуулахыг хязгаарласан зүйлүүд байна уу, үгүй юу. Ашиг олох, арилжаа наймаа хийх, хувийн хэвшилтэй өрсөлдөх ийм хөрөнгө оруулалтуудыг хориглосон зүй...

Д.Амарбаясгалан: Бямбацогт сайд нэмж хариулъя.

С.Бямбацогт: Энэ хуулийн бас нэг гол үзэл баримтлал ашиг олж байгаа салбарт төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх энэ зарчмыг барина. Нөгөө талдаа ашиг олдоггүй иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх энэ салбарт зайлшгүй төрийн нийтийн үйлчилгээний байгууллага байх ёстой гэдэг асуудлыг зааглаж ялгаж өгч байгаа. Ингэж ялгаж өгөхгүй болохоор ард иргэдэд цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, ариутгах татуурга, дээрээс нь зам засах, халтиргаа гулгааг цэвэрлэх гээд энэ ажил ашиггүй учраас хүмүүс ордоггүй. Энэ дээр яалт ч үгүй ТӨК байгуулаад энд чиг үүргийг ард иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх Үндсэн хуульд заасан эрхийг нь хангах хүрээндээ бий болгодог. Яг үүнтэй адилхан зарим аймагт тэр зах худалдааны төв бол хөрөнгө хувийн хэвшлийнхэн хийж чадахгүй байсан учраас 2014 онд Хөвсгөл аймаг, Ховд аймаг, Увс аймаг гээд хэд хэдэн аймагт бол төрийн өмчийн хөрөнгөөр зах худалдааны төв байгуулсан...

Д.Амарбаясгалан: Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Х.Булгантуяа: Одоо тэгвэл энэ зах худалдааны төвүүдээ яах вэ. Энэ хууль жишээлбэл хэрэгжиж эхэлбэл ажиллах уу? Үргэлжлүүлээд төрийн өмч, орон нутгийн өмч хэвээрээ байх уу нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын гишүүдээсээ хүсэхэд одоо яг ингээд хууль хэрэгжих гээд тэгэхээр Үндэсний аюулгүй байдал гэдэг нэрийдлээр хэдүүлээ баахан юм аваад үлдчихдэг юм шүү. Би одоо арваад жилийн өмнө Улсын Их Хуралд

жишээлбэл зарим ТӨК-иудыг хувьчлах гээд Валютын сангийн хөтөлбөрийн хүнд үед орж ирэхэд Үндэсний аюулгүй байдал гээд л баахан ТӨК-иудаа энийг чинь төр хийхгүй бол өөр хэн хийх юм, төр хийхгүй бол хэн хийх юм гэсээр байгаад өөр хүнд ч, хүнээр ч хийлгэдэггүй, төр нь ч өөрснөө сайн хийдэггүй. Үүний нэг том жишээ Монгол шуудан. Миний ойлгосноор энэ нэг газартай холбоотой л ингээд байдаг юм шиг байгаа юм. Тэгээд хувийн хэвшил нь ч хөгжүүлсэн юм байхгүй. Нөгөө төр нь ч өөрсдөө нэг их оролцсон юм байхгүй. Тэгээд нэг төрийн төсвийн нэг байгууллагын цалинтай нэг хүн ТУЗ-ийн гишүүн гэдгээр тэндээс нэг цалин аваад машин унадаг ийм л харилцаатай...

Д.Амарбаясгалан: Бямбацогт сайд хариулт өгье.

С.Бямбацогт: Одоо байгуулагдсан зах худалдааны төв болон төр бас өөртөө орон нутаг өөртөө шаардлагагүй гэж үзсэн хөрөнгөө бусдад ашиглуулах, шилжүүлэх, өмчлүүлэх харилцааг энэ хуульд маш нарийвчилж зохицуулсан байгаа. Ерөөсөө нэгдүгээрт нь бол мал ил тод нээлттэй зарлаад, дуудлага худалдаа байж болно тэр шаардлага өгөх юм бол сонгон шалгаруулалт байж болно. Үнэхээр онцгой нөхцөл байдал үүслээ гэх юм бол шууд гэрээ байгуулж болно. Гэхдээ энэ бүгдийг бол шат дараатай, хэрхэн яаж хэрэгжүүлэх нь бол бүгдээрэнд нь иргэд, аж ахуйн нэгж бүгдэд нь тэгш боломж олгосон, нээлттэй ил тод байхыг хуульчлаад өгчихсөн байгаа. Ингэж шийдэхгүй бол нэгэнтээ юу гэдэг юм тухайн үед хувийн хэвшлийнхэн өөрсдөө хөрөнгө оруулж барьж чадахгүй гадаа өвлийн хүйтэнд, зуны халуунд худалдаа наймаа хийж байгаа иргэдийнхээ эрх ашгийг бодож л уул нь тухтай тохитой орчинг бий болгох гэж саяын аймгуудад зах худалдааны төв байгуулагдсан. Үүнийг худалдаад авах боломжтой хүмүүс байвал санал болгохдоо..

Д.Амарбаясгалан: Энэ нөгөө өмнө нь ТӨК-ийн тухай хууль хэлэлцэх эсэх асуудал орж ирж хэлэлцэгдэж байхад яг энэ асуулт, хариултууд өргөн явагдаж байсан. Гишүүд бас энэ дээр анхаарч байгаа байх гэж бодож байна. Тэгээд өнөөдөр ер нь хэлэлцэх эсэхийг нь шийдээд өмнө нь байгуулагдчихсан байгаа тэр ТӨК-ийн тухай хуулийн ажлын хэсгийг хэсгийн үйл ажиллагаан дээр яг энэ хуулийн ажлын хэсгийг шууд нэгтгээд аваад явах нь зүйтэй байх гэсэн ийм байр суурьтай байгаа.

Ер нь тэгээд төр яг ямар бизнест орох юм, ямар төрлийн бизнест огт орохгүй юм. Байгаа бизнесээ ашиг олохын төлөө гэхээс илүүтэй нийгмийн хариуцлагын хүрээнд яаж авч явдаг болох юм гэдэг ийм л зарчмыг маш тодорхой болгох л ийм хуулиуд явж байгаа учраас энэ дээр гишүүд анхаарч үгээ хэлж байх шиг байна аа. За Хассуурийн Ганхуяг гишүүн алга байна. Батбаярын Жаргалан гишүүн алга байна. Цэндийн Баатархүү гишүүн асуулт асууя.

Ц.Баатархүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Маш чухал хуулиудын нэг гэж бодож байна. Хэлэлцэх эсэхийг би дэмжиж байгаа гэдгээ хэлье ээ. Гишүүдийн асуулттай давхцуулахгүйгээр нэг зүйлийг би асууя гэж бодож байна. Энэ сургууль, цэцэрлэг, нийтийн өмч, төрийн өмчийн бүртгэлд байгаа үл хөдлөх хөрөнгө. Ингээд компаниудын үнэлгээ нь нийлээд яг ингээд хөрөнгийн үнэлгээгээр гаргаж үзэх юм бол хэдэн их наяд төгрөг болдог юм бэ. Энэ үнэлгээг ер нь жил болгон гаргадаг юм уу, энэнийхээ өгөөжийг хэмжих юм уу цаашдаа. Хуульд ямар тоон үзүүлэлтээр бид нар одоо ТӨК-ийн ашигт ажиллагаа болгоныг, алдагдал болгоныг бүртгэдэг биш нийт Монгол Улсын нийтийн өмчийн хөрөнгийн үнэлгээ тэд байна. Монгол хүн амд нэг хүнд оногдох хөрөнгийн хэмжээ тэд байна гэдэг ийм тоон үзүүлэлт байдаг юм болов уу гэж асуумаар байна.

Хоёрдугаарт энэ хуулийг баталснаар Монгол Улсын иргэн болгонд оногдох бодит өгөөж ер нь яаж сайжрах юм бэ? Яаж сайжрах юм бэ? Гуравдугаарт нь, цаашдаа бид туйлшрахгүйгээр аль салбартаа төрийн өмчийн менежментээ авч явах юм, аль салбарыг хувьчилж хувийн хэвшил рүү шилжүүлэх юм бэ гэдгээ яг ингээд философийн хувьд ч тэр, эдийн засгийн хувьд ч тэр, улс төрийн хувьд ч тэр, засаглалын хувьд ч тэр ингэж тодорхойлсон юм уу? Нэг ийм ойлголт яриад байна лээ. Ашиггүй ажилласан учраас хувьчилна гээд. Заримдаа ТӨК засаглал муугаасаа болоод зориуд гэмээр алдагдалтай ажиллуулаад ингээд хувьчилж авдаг. Тэгэхээр энэ өмч хувьчлалын менежмент, төрийн өмчийн менежментийг хэрхэн ингэж хослуулах юм бэ гэдэг дээр тодорхой хариултуудыг өгөөсэй гэж бодож байна. Миний тооцож байгаагаар манай энэ ТӨК-иудын нийт үнэлгээ нэг 50 их наяд төгрөг орчим болохоор харагдаад байгаа. Монгол Улсын нэг хүнд оногдох нь нэг 10 орчим сая төгрөгийн нийтийн өмчийн үнэлгээ байна гэж үздэг. Энийг жишээлэх юм Соёлын төв өргөө, Хүүхдийн ордон ч гэх юм уу маш олон энэ ТӨК-ийн барилгууд байдаг энийгээ одоо ингээд эргэлтэд оруулах, менежментийг цаашаа хэн авч явах юм, Засгийн газар авч явах юм уу, ТӨХ авч явах юм уу гэдэг дээр нэг хариултууд өгөөч ээ.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт сайд хариулт өгье.

С.Бямбацогт: Баатархүү гишүүн маш чухал асуудал хөндөж байна. 1996 онд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль батлагдахдаа энэ хуульд бол 4 жилд нэг удаа төрийн өмч төр одоо өмчөө тоолно гэж хуулийн заалт орсон юм байна лээ. Түүний дагуу ингээд тооллогууд нэлээн явагдсан. Яг өнөөдрийн байдлаар төрийн өмчид нийтдээ 111 их наяд төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй хамрагдсан байна. Үүнээс 17 их наяд нь орон нутгийн өмчид, 94 их наяд нь бол төрийн өмчийн хөрөнгө байгаа юм. Төрийн өмчийн. 2015 онд 30 их наяд, 2022 онд 91 их наядын хөрөнгө бүртгэгдэж байсан байна тоологдож байсан. Анх тоологдож байсан дүнтэй 1996 онд бол 1.5 их наяд. Үүнтэй харьцуулах юм бол өнөөдөр ингээд 30 орчим жилийн хугацаанд 61 дахин төрийн өмчийн хөрөнгө нэмэгдсэн байгаа. Энэ дээр бид нар бас нэлээн сайн анализ хийж үзэх ёстой. Үнэхээр одоо юу гэдэг юм. Хөрөнгийн үнэлгээгээрээ үнэ цэнэ нэмэгдээд, төгрөгийн ханш унаад, валютын ханш чангараад ингээд үнэ өсчхөв үү. Төр тийм үү шинээр тийм бүтээн байгуулалт гээд сургууль, цэцэрлэг, эмнэлгүүд барьсаар байгаад энэ хөрөнгө нь нэмэгдчихэв үү, эсвэл ТӨК-иуд нь үр ашигтай ажиллаад тийм үү, үр ашгаас нь, хуримтлагдсан ашгаас нь ингээд хөрөнгө нь нэмэгдчихэв үү гэдэг дээр бид нар цаашдаа нарийвчилсан судалгаа хийж үзнэ ээ. Судалгаа хийж үзнэ.

Ингэж байж бид нар цаашдаа энэ төрийн өмчийн үр өгөөжийг хэрхэн яаж нэмэгдүүлэх вэ. Өнөөдрийн өсөж байгаа хөрөнгө маань үнэхээр бодитой ТӨК-иудын үр өгөөжийн үнэ үр дүнд бий болж уу. Үнэхээр төсвийн хөрөнгө оруулалтаар маш олон сургууль, цэцэрлэг, эмнэлэг нийгмийн үйлчилгээний байгууллагуудыг барьж байгуулснаар бий болчхов уу. Зам, эрчим хүчний шугам гэх мэтчилэн төсвийн хөрөнгөөр барьдаг. Энийг нэг тодорхой болгож цаашдаа нэг үнэлгээ хийж, дүн шинжилгээ хийж үзэж байж цаашдаа бодлогоо зөв тодорхойлох ёстой юм байна лээ. Тэгээд л юу гэдэг юм төрийн өмчийн байгууллага нь хөрөнгө өсөж байгаа шүү дээ гэж яваад байдаг. Ийм байдалтай байж болохгүй байх.

Тийм болохоор өгөөжийг хэрхэн, яаж нэмэгдүүлэх вэ энэ рүү чиглэсэн. Одоо хуулийн нэг үзэл баримтлал бол ТӨК-ийн өгөөжийг хэрхэн нэмэгдүүлэх вэ. Мөн төрийн нийтийн өмч тэр газар, газрын хэвлийн баялаг, ой усны нөөцийг яаж

нэмэгдүүлэх вэ түүний үр өгөөжийг яаж ард иргэддээ тэгш, шударга хүртээдэг болох вэ гэдэг рүү энэ хуулиудын зохицуулалтууд орж байгаа. Төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчим бол таны хэлж байгаатай санал нэг байгаа. Хувийн хэвшлийн хийж чадаж байгаа болгон руу төр орохгүй байх ёстой. Харин хувийн хэвшлийн хийж чадахгүй, ард иргэдийн эрүүл, аюулгүй орчинд Үндсэн хуульд заагдсан эрхийг тийм үү хангах хүрээнд төр өөрийнхөө үүргийг биелүүлэх ёстой иргэдийнхээ төлөө. Ийм л зарчмын үүднээс үндсэндээ тэр төрийн нөгөө нийтийн үйлчилгээний бай...

Д.Амарбаясгалан: Цэндийн Баатархүү гишүүн тодруулж асууя.

Ц.Баатархүү: Тэгээд хууль хэлэлцэх явцад Их Хурлын дарга хэлсэн ажлын хэсэг гаргаад нэлээн олон талаас нь ухаж үзэх хэрэгтэй гэж бодож байна. Жишээ нь төрийн өмчийн оролцоотой компаниуд гээд Монголд байгаад байдаг. Монгол шуудан компани гээд байдаг. Нэг талдаа ингээд тендер сонгон шалгаруулалтад орох гэхээр энэ чинь төрийн өмчтэй компани шүү дээ гээд болдоггүй. Хувийн хэвшлийнхэнтэй өрсөлдөх гэхээр танайх чинь ТӨК шүү дээ гээд янз бүрийн асуудал үүсгээд байдаг. Нэг ийм дунд нь гацчихсан менежмент хийхэд их хүндрэлтэй болчихсон ийм хувьцаатай компаниуд байгаад байгаа юм. Нэг бол хувийн хэвшил нь давамгайл болоод явахгүй бол яг ийм тодорхой хэмжээний бага ингээд хувьцаа өгчихөөр тэр компани ингээд менежментээ хийх гэхээр ингээд асуудал болоод байдаг. Энэ асуудлыг төрийн өмчит оролцоот компанийн хувь хэмжээний асуудал, засаглалын асуудлыг тодорхой болгох хэрэгтэй. Тэгэхээр ТӨК хувийн компани...

Д.Амарбаясгалан: Бямбацогт сайд хариулт өгье.

С.Бямбацогт: Наадах чинь их чухал асуудал байгаад байгаа юм. Одоо яах вэ Та Монгол шуудан компаниас, түүнээс илүү иргэдэд эрсдэлтэй нэг том асуудал бол энэ АЗЗА компани байгаа. АЗЗА компани бол 21 аймагт байдаг. Өвөлд нь зам халтиргаа гулгаагүй иргэдийг аюулгүй зорчуулах үүрэгтэй. Зунд нь цоорхой хагарсан эвдэрсэн замуудыг нөхөж засах ийм үүрэгтэй. Гэтэл ТӨБЗГ ашигтай ажил ТӨК-аас ашигтай ажлыг шахдаг. Зам тээврийн яам бол иргэдийг аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүл гэж шахдаг. Ингээд хоорондоо зөрчилдөх нэг талаасаа ТӨБЗГ-аас төлөвлөгөө батлаад, томилогдоод тайлангаа тавьдаг, нөгөө талаасаа салбарын яамнаасаа хянагддаг. Ингээд 2 талд нь зөрчилддөг.

Мөн нэгтгэл байгуулсан чинь тоогоороо цөөрсөн 21 аймгийг нэг АЗЗА нэгтгэл болгосон боловч өнөөдөр нэгтгэлээсээ болоод 21 аймагт хийгдэхээр зам засвар ашиглалтын ажилд энэ компаниуд оролцож чадахаа больчихсон. Нөгөө АЗЗА-нууд нь өртэй үүнээсээ болоод орон нутагт нөгөө замын засвар үйлчилгээ хийх АЗЗА-ууд нь тендер оролцож чадахаа боль...

Д.Амарбаясгалан: Болдын Цэнгэл дарга 4 дүгээр индрээс нэмж хариулт өгье.

Б.Цэнгэл: Гишүүний асуултад хариулъя.

Бид төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчийн хуулийн этгээдийн хувьцааг 2025-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг бэлтгээд Засгийн газарт танилцуулахаар ингээд ажиллаж байгаа. Энэ дээр тухайлбал бид бол Монгол шуудан компанийн одоо байгаа хувийг 4.9 хүртэл

хувийг олон нийтэд нээлттэй болгох IPO гаргах чиглэлээр саналыг боловсруулж оруулж байгаа. Ер нь бол 4 бүлгээр авч үзэж тухайлбал эрчим хүчний 12, 13 компанийг 4.9 хүртэлх хувийг нь олон нийтэд хөрөнгийн биржийг нээлттэй болгох гэх мэтчилэн тухайлбал дээр нь одоо уул уурхайн компаниудын талаар өмнө нь гарсан Их Хурлын шийдвэрүүдийг хэрэгжүүлье. 10 хүртэлх хувь нь бол IPO гаргая гэдэг ийм Их Хурлын шийдвэртэй энэ агуулгаар нь.

Д.Амарбаясгалан: Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууя.

Энэ хуулийн төслийн хэлэлцэх хэсгийг дэмжиж байгаа. Энэ бол намтар түүх их арвинтай, тулгамдсан асуудал ихтэй, асуудал яривал мянган асуудалтай, зөрчил яривал мянган зөрчил дотор нь байгаа ийм эрх зүйн шинэчлэл 3 үндсэн зүйлийг хэлмээр байгаа юм.

Нэгдүгээрт бид нар 1992 онд Шинэ Үндсэн хуулиа батлаад чөлөөт зах зээлийн эдийн засгийн замыг сонгоод ардчилсан замыг сонгоод 33 жилийг замнасан байгаа юм. Ингэхдээ нэг зүйл дээр 1996 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийг батлаад тухайн үед 100 хувь социалист өмч байсан төрийн өмчүүдийг хувьчлах хуулийг гаргасан юм. Ийм хувьчлах хуулиар бид нар 30 жил явчихсан. Яг нийтийн өмч гэж яриад байгаа энэ асуудал харилцаа маань тэр чөлөөт зах зээлийн эдийн засгийн харилцаанд хувийн эрх зүйн харилцаа гэж яриад байгаа. Энэ бол нэг тэгш эрхийн харилцааны зарчим үйлчилдэг. Ийм зах зээлийн эдийн засаг дээр нөгөө төрийн өмч маань давамгайлаад явсан ийм эрх зүйн орчинтой явчихсан. Эндээс улбаалаад төр ер нь монопол учраас сүүлдээ үйлдвэр аж ахуйн газруудаасаа халиад амралт сувиллын газрууд, спорт заалнууд, эмийн сан 5 эмийн сан хүртэл байгаа. Орон нутгийн өмчид 5 эмийн сан байгаа. Сая манай Булгантуяа гишүүн хэлж байна. Тэр Хөвсгөлд худалдааны зах хүртэл орон нутгийн өмчөөр байгуулчихсан мөн байгалийн баялаг нийт ард түмний мэдэлд байна гэсэн тэр Үндсэн хуулийнхаа өөрчлөлтөөс гажаад байгалийн баялгийг орон нутгийн өмчүүд өмчилдөг болчихсон.

Өөрөөр хэлбэл бид энэ эрх зүйн реформыг Үндсэн хуульдаа нийцүүлэх чиглэлээр боловсруулсан. Энэ эрх зүйн шинэчлэл батлагдах юм бол ер нь мэдэхгүй одоо байгаа энэ төрийн болон орон нутгийн өмчийн гэж байгаа энэ янз бүрийн байгууллагуудын тал нь байхгүй болно. Ер нь голдиролдоо орно. Бид нар чөлөөт зах зээлийн эдийн засаг руугаа орно, төр хийх ёстой тэр чиг үүргээ л хэрэгжүүлнэ. Яагаад гэхээр бид нар 2021 онд Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын хуулийг батлахдаа төв Засгийн газар болон орон нутгийг чиг үүргээр нь ангилчихсан. Одоо энэ нийтийн өмчийн хууль яаж орж ирж байгаа вэ гэхээр тэр өмчийн хэсэг нь зөвхөн тэр хуульд заасан чиг үүргийн хүрээнд л төрийн юм уу, компани юм уу, орон нутгийн өмчийн этгээд юм уу, тэр нь байгуулагдана, тэрэнд нийцэхгүй байгаа бүх хуулийн этгээдүүд татан буугдана.

Тийм учраас бид асуудлыг голдирол руу нь оруулах гэж байгаа юм. Нөгөө талаасаа энэ өнгөрсөн 30 жилийн хугацаанд тухайн үед төрд хэн дарга байна тэр нь төрийн өмчийг хувийн өмч мэт захиран зарцуулдаг байсан. Энэ тоглоомын дүрмийг бид өөрчлөх гэж байгаа. Жишээлбэл манай нийт ард түмний төлөөллийн төв байгууллага Улсын Их Хуралд улсын төсвөөс 3 дахин их төрийн өмчийн компаниудын асуудал ерөөсөө орж ирдэггүй Улсын Их Хурал дээр. Одоо энэ хууль батлагдах юм бол ард түмний төлөөллийн төв байгууллага ард түмний нэрийн өмнөөс ард түмний байгалийн баялгийн менежмент дээр шийдвэр гаргалтууд хийж эхэлнэ. Одоо энийг тэнд нэг компанийн захирал юм уу ТУЗ-ийн хэдэн гишүүн

шийдэж байгаа. Мөн чиг үүргээр нь ангилж заагласны бас нэг чухал үр дүн бол авлига хээл хахууль энэ хулгай цэгцэрнэ.

Д.Амарбаясгалан: Үг хэлчихлээ. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэхээр 2 гишүүн нэр ирүүлсэн байна. Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлье. 2 дугаар индэр.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Нийтийн өмчийн тухай хууль боловсрогдож төсөл нь өргөн баригдаж орж ирж байна. Үзэл баримтлалынх нь хувьд дэмжмээр. Анхны хэлэлцүүлгийн үед нэлээн том ажлын хэсэг гарч нэлээн нухацтай судалж үзмээр ийм зүйл юм байна. Төрийн өмч гэж юу байх вэ гэхээр зэрэг төрийн нийтийн өмч төрийн тусгайлсан өмч 2-оос бүрдэнэ гэж хэлээд төрийн нийтийн өмчтэй нь бид нар энэ газар нутаг, байгалийн баялаг, хэвлий ой, ан, ус гээд энэ бүх зүйлээ оруулсан байгаа юм.

Гэтэл энүүнийхээ харилцааг зохицуулсан зохицуулалт нь энэ хуульдаа байхгүй. Үндсэн хуулийн үзэл санаагаараа Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжид хуваагдана гээд хэлчихсэн юм аа. Тэгвэл одоо энэ аймаг сумдуудад энэ газар нутгийг ямархуу байдлаар ашиглуулах асуудал явагдах юм бэ гэдэг зүйл байгаад байгаа байхгүй юу. Яаж бүртгэлжүүлэх юм бэ энэ асуудлаа? Үнэхээрийн л өмч мөн юм бол энэ чинь үнэ цэнтэй байх тухай ойлголт байх ёстой. Энийгээ юу гэж төсөөлж ойлгоод байна вэ гэдэг зүйл чанар байдлыг дордохгүй байх тухай асуудал яригдах ёстой.

Тийм учраас тухайн орон нутгуудад ашиглагдаж байгаа газар нутгийг анх тогтоож олгохдоо төлөв байдал чанарынх нь үзүүлэлтийг тогтоож өгөөд энэнээс дордохгүйгээр л авч явах ёстой гэдэг энэ үзүүлэлтийг хийгээд эргээд яаж хянаж явах юм энэ тэр гээд олон зүйлүүд энд яригдаж дурдагдах ёстой юм гэж ингэж бодоод байна. Би дараагийн нэг зүйл тэр тусгайлсан өмчийн тухай юм яригдаад байгаа юм.

Тэгэхээр тусгайлсан өмчийн асуудал дээр ер нь энэ өмчийн ашиглалт үр ашиг өгөөжийн тухай асуудал өөрөө суурь ойлголт нь байх гээд байх шиг байна аа.

Тэгэхээр зэрэг энийг тухайн эзэмшигч нарт ямархуу гэрээ хэлцэл нөхцөлтэйгөөр энийг эзэмшүүлэх ёстой юм бэ? Тэгээд тэр юманд нь ямархуу байдлаар хяналт тавьж ажиллах ёстой юм бэ? Төр нь ч бай орон нутаг нь ч бай. Аль нь ч байсан ямархуу байдлаар хянаж ажиллах ёстой юм. Дамаан бизнесийн чиглэлтэй тэр төрийн тусгайлсан өмчийн асуудал байна аа. Энд яах аргагүй үр өгөөжийн асуудал ерөөсөө гэрээ хэлцлээр зохицуулагдахгүй яваад байгаа. Ашигтай ч ажилласан, ашиггүй ч ажилласан. Нэг захирал цалин аваад л явж байдаг тэрнийхээ хариуцлага юмыг үүрдэггүй нэг ийм асуудал үүсчхээд болж өгөхгүй байна. Энийгээ яаж зохицуулах юм гэдэг юм их нарийвчлагдаагүй юм байна гэж.

Дараагийн нэг зүйл ер нь энэ үл хөдлөх хөрөнгийн элэгдэл тооцолт сэргээн босголтыг хэрхэн дахиж одоо энэ хөрөнгийн үнэлгээ юмандаа тооцож авч явах вэ гэдэг асуудал өөрөө байгаа юм. Дам дамаа энэ барилга байгууламж дээр ямар байх юм, машин механизм энэ тоног төхөөрөмжүүд дээр ямар байх ёстой юм, дам дамаа энэ мэдээлэл технологийн энэ тоног төхөөрөмжүүд чинь бол өдрөөс өдөрт бараг хувьсан өөрчлөгдөж байгаа учраас энүүн дээр ямар зохицуулалт тусгайлсан юм

явах юм гээд олон бодмоор санаанууд энийг бүгдийг нь шийдэж чаддаггүй юм гэхэд ямар ч байсан ангилж байгаад энэ дээр ийм бодлого баригдах ёстой гэдэг ерөнхий зарчим юмаа тогтоож өгөх ёстой юу үгүй юу гэдэг нэг ийм зүйл байгаад байна гэж.

Дараагийн нэг зүйл салбарын яам ТӨБЗГ хоёр ер нь ямар харилцаа уялдаатай ажиллах ёстой юм бэ? Салбарын яам нь ямар юман дээр нь оролцох ёстой юм. ТӨБЗГ нь ямар юман дээр нь оролцох ёстой юм дам дамаа бид нарын их тодорхой жишээнүүд байна шүү дээ. Энэ эрчим хүчний салбарт гэхэд.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн үг хэлж дууслаа.

Санал хураалтыг үдээс хойших чуулганы хуралдааны эхэнд буюу 14 цагаас явуулна. Олон санал хураалт байгаа учраас гишүүдэд нэгдсэн зар хүргэж байгаад хангалттай ирц ирцтэйгээр санал хураалт явуулна аа.

16.17 цаг

Дараагийн асуудалд оръё. [ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.](#)

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг танилцуулна аа.

П.Батчимэг: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Сүүлийн жилүүдэд манай улсад иргэд ялангуяа 18 нас хүрээгүй хүүхэд залуучууд шинэ төрлийн бичил, цахилгаан тээврийн хэрэгслүүд түүний дотор сурон загварын цахилгаан, дугуй, цахилгаан скутерээр замын хөдөлгөөнд оролцох явдал эрс нэмэгдсэн. Мөн хүн амын хэт төвлөрөл, хотжилт, авто замын түгжрэлд түгжрэлээс үүдэлтэйгээр нийслэл Улаанбаатар хотод нийтийн хэрэгцээний цахилгаан дугуй, скутер, түрээсийн шинэ төрлийн үйлчилгээ бий болж иргэдийн хэрэглээг өсгөж байна аа. Үүний улмаас иргэд явган зорчигч цахилгаан дугуй, скутертэй холбоотой зам тээврийн осол гэмтэлд өртөх өөрт болон бусдад эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирол учруулах явдал ихэссээр байна аа. Тухайлбал сүүлийн 3 жилийн хугацаанд цахилгаан дугуй, скутер, мопедоос үүдэлтэй нийт 985 шинэ тохиолдол бүртгэгдсэн байна.

Насны бүлгээр авч үзвэл нийт осол гэмтлийн тохиолдлын 3.9 хувийг 10-аас 1.9 насны хүүхэд залуус эзэлж байна. Мөн 2024 оны байдлаар манай улсад нийтэд цахилгаан дугуй, скүүтер, тээврийн хэрэгслийн түрээсийн үйлчилгээ үзүүлэгч Жет, Табо, Эко байк гэсэн 3 ААН үйл ажиллагаа эрхэлж байна.

Эдгээр ААН-үүдийн сүүлийн 3 жилд импортоор оруулж ирсэн цахилгаан дугуй скутерийн тоо 2022 онд 1050, 2023 онд 8157, 2024 онд 16783 болж өссөн байна аа.

Иймд Улсын Их Хурлын даргын 2024 оны .9 дүгээр сарын 5-ны өдрийн 76 тоот захирамжаар төрөөс хүний эрх, эрх чөлөө, хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үндсэн зорилгын хүрээнд цахилгаан дугуй, сурон, скутерийн хэрэглээг зохицуулах талаар хуулийн төсөл боловсруулах

үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, миний бие ахлан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Г.Лувсанжамц, Н.Алтаншагай, Д.Ганбат нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Түүнчлэн НҮБ-ын Ерөнхий ассамблей 2020 онд дэлхий даяар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах асуудлаар тогтоол баталж зам тээврийн ослын улмаас хүний амь нас хохирох гэмтэл бэртлийн тохиолдлыг 2030 он хүртэл 30 он гэхэд 50 хувь бууруулах зорилтыг дэвшүүлсэн. Энэхүү тогтоолоор замын хөдөлгөөний эмзэг оролцогчид болох явган зорчигч унадаг дугуйн жолоочийн аюулгүй байдлыг хангахад онцгойлон анхаарал хандуулах хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого арга хэмжээнүүдийг баталж хэрэгжүүлэхийг гишүүн орнууддаа үүрэг болгосон.

Ажлын хэсэг өнгөрсөн 6 сарын хугацаанд хуулийн төсөл боловсруулах чиглэлээр холбогдох судалгааг гүйцэтгүүлэх, гадаад орны сайн туршлагыг судлах мөн Монгол Улсын Засгийн газар холбогдох төрийн болон ТББ мэргэжлийн экспертүүд, иргэд, олон нийт, цахилгаан дугуй, скүтер нийлүүлэгч, түрээсийн үйлчилгээ үзүүлэгч ААН-үүдийн саналыг авах зэрэг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан үе шаттай цогц ажлуудыг хийсний үндсэн дээр ийнхүү өнөөдөр ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн тус төслийг Улсын Их Хуралд өргөн барьж байна аа.

Энэхүү хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгасан болно.

Нэгдүгээрт цахилгаан, дугуй, цахилгаан, скүтер, хувь хүний бичил, цахилгаан тээврийн хэрэгсэл гэсэн тээврийн хэрэгслийн ангиллыг шинээр тодорхойлж эдгээр тээврийн хэрэгслийг жолоодох насны хязгаар тээврийн хэрэгслийн техникийн дээд хурд тээврийн хэрэгсэлд зорчихыг зөвшөөрсөн замыг хуульчлав.

2.Цахилгаан дугуй, цахилгаан скүтрийг жолоодон замын хөдөлгөөнд оролцогч жолоочийн эрх үүрэг, жолоочид хориглох зүйлсийг тусгасан болно оо.

3.Цахилгаан дугуй скүтерийн хөдөлгүүрийн хүч чадал, техникийн дээд хурд, тээврийн хэрэгслийн тоноглол зэргийг агуулсан цахилгаан дугуй, скүтерийг ашиглах замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндсэн шаардлагуудыг шинээр нэмж тусгуулсан болно оо.

4.Нийтийн хэрэгцээний цахилгаан, дугуй, цахилгаан скүтрийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэх мөн үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлагыг шинээр тодорхойлсон болно.

2025 оны 3 дугаар сарын 23-ны өдөр ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон энэхүү хуулийн төсөлд олон нийтээс санал авахаар Улсын Их Хурлын Тамгын газрын Dparliament.mn цахим хуудсанд хуулийн төсөл, холбогдох судалгааг байршуулсан.

2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хурлын даргын 76 дугаар зар захирамжтай ажлын хэсгийн ээлжит хурлаар ХЗДХЯ, ЗТЯ, ЦЕГ-ын Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөл гэсэн

төрийн эрх бүр эрх бүхий байгууллагуудын төлөөлөлд хуулийн төслийг танилцуулж санал солилцсон.

2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хурлын даргын захирамжтай ажлын хэсгийн ээлжит хурлаар нийтийн хэрэгцээний цахилгаан дугуй скүтрийн үйлчилгээ үзүүлэгч ААН-үүд болох Жет Шэйринг ХХК, ВМС Групп ХХК, Эко технологи ХХК компаниудын төлөөлөлтэй уулзалт хийж хуулийн төсөлд үйлчилгээ эрхлэгчдийн саналыг тусгасан болно.

2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг төрийн бус байгууллагууд болох Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нийгэмлэг төлөөлөлд хуулийн төслийн талаар танилцуулж саналыг авсан. 2025 оны 5 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хурлын даргын захирамжтай ажлын хэсгийн ээлжит хурлаар хуулийн төслийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын гишүүн, 20 минутын хот, Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, НЗД-ын 1 дүгээр орлогч Т.Даваадалай болон бусад албан тушаалтнуудтай санал солилцсон.

2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр. Мөн ажлын хэсгийн зүгээс хуулийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг Төрийн ордонд зохион байгуулсан ба хэлэлцүүлэгт ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Д.Цогтбаатар, Б.Уянга, С.Цэнгүүн, А.Ариунзаяа нарын болон иргэд олон нийт холбогдох төрийн болон ТББ үйлчилгээ эрхлэгч ААН-үүдийн төлөөлөл 100 гаруй иргэд оролцсон.

2025 оны 5 дугаар сарын 14-өөс 16-ны өдрүүдэд БНКАУ-д ЗХАБТХ тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, цахилгаан дугуй, скүтрийн зам, дэд бүтэцтэй газар дээр нь танилцах тус улсын Дотоод хэргийн яам, Астана, Алматы хотын эрх бүхий албан тушаалтнуудтай уулзалт хийх туршлага судлах зорилгоор албан томилолтоор ажилласан. Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль Монгол Улсын нэгдсэн нэгдэн орсон олон улсын гэрээ, Хууль тогтоомжийн тухай хууль, ЗХАБТХ болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай дагалдах хуулийн төслүүдийг боловсруулсан юм аа.

Эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр энэхүү хуулийн төсөлтэй хэлэлцэх асуудлыг та бүхэн хэлэлцэж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Батчимэг гишүүнд баярлалаа.

Төслүүдийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын .9 гишүүнээс 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн

төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч шинэ төрлийн бичил цахилгаан тээврийн хэрэгслүүдийн ангилал, тодорхойлолтыг шинээр хуульчлах, тухайн ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох насны хязгаар, тээврийн хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага, тээврийн хэрэгслийг жолоодож замын хөдөлгөөнд оролцож байгаа этгээдийн эрх, үүрэг, хариуцлага, мөн дээрх тээврийн хэрэгслээр нийтэд төлбөртэй үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг шинээр хуульчлах гэсэн цогц асуудлуудыг зохицуулах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна аа.

Хууль санаачлагч хуулийн төсөл батлагдсанаар иргэнд аливаа зардал үүсэхгүй бөгөөд хуулийн этгээдэд энгийн зөвшөөрөл авахтай холбогдуулан үйл ажиллагааны тодорхой зардал 1000916482 төгрөг 50 мөнгө гарна гэж тооцсон байна. Уг хуулийн төслийг Dparliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг хуулийн төсөлд цахилгаан скүтерээр явган хүний замаар зорчиж болохыг зөвшөөрсөн зохицуулалт байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр цахилгаан скүтер дугуйн түрээсийн үйлчилгээ эрхлэх асуудлыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгаж зөвшөөрлийн тогтолцоонд хамруулах шаардлагатай эсэх, мөн шинээр бий болж байгаа энэхүү зөвшөөрлийн харилцааг зөвшөөрлийн зөвлөлөөр хэлэлцүүлж санал авсан эсэх талаар, цахилгаан скүтертэй холбоотой зөрчилд шийтгэл оногдуулахдаа 16-аас доош насны хүүхдүүдэд хэрхэх талаар, мөн хиймэл оюун ухаан ашигласнаар замын хөдөлгөөний зөрчилд ногдуулж буй шийтгэлийн тоо нэмэгдсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир цахилгаан дугуй скүтер нь тээврийн хэрэгслийн ямар ангилалд хамаарах талаар, тус тээврийн хэрэгслийг урс улсын бүртгэлд хэрхэн бүртгэх талаар, техникийн хяналтын үзлэгт болон жолоочийн хариуцлагын даатгалд хамруулах эсэх талаар, хууль батлагдсанаар энэ төрлийн үйлчилгээ эрхэлж буй компаниудад тавих хяналт, эрх зүйн зохицуулалт хэрхэн сайжрах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар цахилгаан, скүтер, цахилгаан дугуй нь унадаг дугуйн зам байхгүй тохиолдолд аль хэсгээр зорчих талаар, зөвшөөрөөгүй замаар зорчсон тохиолдолд торгууль хариуцлага хүлээлгэх зохицуулалт хуулийн төсөлд тодорхой тусгагдсан эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа цахилгаан скүтер, мопедын хэрэглээ нэмэгдэж буй энэ үед бид хориглох бус аюулгүй зохион байгуулалттай орчныг бүрдүүлэхэд анхаарах талаар, зарим явган хүний замын хэсгийг скүтер дугуйн зам болгон ашиглах, явган хүний замыг давхар түвшинд шийдэх зэрэг хөнгөн зардал багатай хувилбаруудыг судалж зөвхөн хууль тусгаад орхих бус нийслэлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан цогцоор нь шийдэхийг анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хуулийн төслийг дэмжиж буйгаа илэрхийлж хуулийн төслийн гол зорилго нь хориглох хязгаарлах бус зөв зохицуулалт бий болгох талаар, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэд халдахгүйгээр мөн зорчих хөдөлгөөнд саад учруулахгүйгээр хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангах талаар анхаарах ёстой талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг хуулийн төслийг дэмжиж буй талаар тус тус үг хэлж байр сууриа илэрхийллээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт хэсэгт заасны дагуу санал хураалт явуулахад ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Цэвээндоржийн Ням-Очир ЦЕГ-ын Тэргүүн дэд дарга бригадын генерал, Баатарсүрэнгийн Батзориг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга цагдаагийн хурандаа, Батцагааны Очирбат Тээврийн цагдаагийн албаны ЗЦГ-ын Зам, тээврийн хяналт, төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн дарга, Өлзийдэлгэрийн Жамбалсүрэн Улсын Их Хурлын гишүүн Батчимэгийн зөвлөх гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна аа.

Улсын Их Хурлын гишүүд, хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн алга байна. Нанзадын Наранбаатар гишүүн алга байна. Байгаа юм уу? Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Энэ нийгмийнхээ хөгжил, техникийнхээ дэвшлийг дагаад шинэ шинэ зүйлүүд бий болж байна л даа. Тэгээд манайд энэ сурон, дугуй, цахилгаан дугуй гээд ийм юмнууд ороод ирчихсэн. Ер нь олон оронд энэ үйлчилгээ бий болчихсон л доо. Тэгээд хориглох арга байхгүй. Цаашид зохицуулахаас өөр арга байхгүй. Бас нөгөө талаар энэ цахилгаан тамхи, веп гээд ингээд зохицуулалтгүй ийм юмнууд байгаа юм. Тэгээд ямар ч байсан энэ цахилгаан дугуйтай холбоотой асуудлыг нь зохицуулах гээд Батчимэг гишүүнээр ахлуулаад ажлын хэсэг тодорхой үр дүнтэй ажилласанд талархаж байгаа.

Сүүлийн жилүүдэд би энэ танилцуулгаас харж байхад энэ гэмтэл аваар ослын улмаас хүүхэд залуучууд хүмүүс бэртэх ийм асуудлууд хурцаар тавигдаж байгаа. Бүүр жилийн жилээс жилд нэмэгдэж байна. Сүүлийн 3 жил энэ чинь мянга орчим гэх шиг боллоо. Тэгээд нийтдээ манай улсад чинь 16, 17 мянган ийм цахилгаан дугуй, скүтер ороод ирчихсэн. Оруулж ирдэг компаниудын тоо ч нэмэгдэж байна.

Ер нь цаашдаа нэг цэгцлэхгүй бол ингээд яваад байвал ерөөсөө зам тээврийн осол ч замбараагүй. Түүнийгээ дагаад аваар осол, хүмүүсийн эрүүл мэндийн асуудал гээд ийм олон асуудлууд гарч ирэх юм байна. Энэ хуулийн төслийг харж байхад сурон гээд байгаа. Энэ бол маш их хүчирхэг. Одоо энэ мопедоос хэд дахин илүү хүчтэй, хурдтай. Мөн хөдөө унадаг энэ хужаа яамнаас илүү хүчтэй, чадалтай

ийм аюултай тээврийн хэрэгсэл болчхоод байгаа. Хүүхдүүд унаад нэг бол машинд дайруулж үхчих гээд, явган хүний замаар явахаараа нэг бол хүн дайрч алчих гээд л нэг ийм байдалтай.

Тэгээд энэ хуулийн төсөл дээр суроныг чөлөөтэй явахаар оруулчихсан байх юм. Би уг нь энийг л нэг жаахан хязгаарласай гэж хардаг юм. Суроныг бол яах вэ 18 нас хүрсэн хүн унана л гэж хязгаарласан юм байна лээ. Бусдаар бол өнөө замаар машинтай холилдоод давхидаг нь хэвээрээ. Баруун гар талаа бариад л явна гэж байгаа. Яг амьдрал дээр тэр баруун зүүн дундуур нь дураараа л явдаг хэвээрээ байх юм байна лээ. Дахиад явган хүний замаар энэ суроныг явуулна гээд орчихсон байна лээ шүү дээ. Тэгэхээр чинь нөгөө л ялгаа байхгүй нэг бол дайрагдаж мөргүүлж үхчих гээд нэг бол хүн амьтан дайрч гэмтээчих гээд байдаг нь хэвээрээ юм биш үү? Суроныг энэ их хүчтэй техник тээврийн хэрэгслийг яагаад ингээд явган хүний замаар ч, автомашины замаар ч чөлөөтэй явах ийм бололцоо олгож байгаа юм. Хурдыг нь хязгаарлачихсан байна лээ. Тэгэхээр хурдыг нь яаж 10 км-ээс цагаас багаар явна гээд ингээд оруулчихсан байна лээ. Хурдыг нь яаж хэмжих юм? Явган хүний замаар баруун гар талаа бариад 10 км/цагаас дотогш хурдтай явж байна гэдгийг нь яаж тогтоох юм. Хэтрээд хурдтай илүү гараад явчихлаа гэдгийг нь яаж тогт байх юм бэ гэсэн нэг ийм асуулт байна. Энэ дээр л тодруулъя.

Бусдаар тэр скүтер, цахилгаан дугуй энэ тэрийн хувьд бол болох юм байна гэж ойлгож байгаа юм. Тэгээд манай улсад нэг л зовлонтой асуудал манай хотод байна л даа. Зам байхгүй байгаад байгаа байхгүй юу. Дугуйнд зориулсан зам байхгүй болохоор зэрэг л ингээд асуудал үүсээд байгаа юм.

Хоёр дахь асуулт нь тэр хэчнээн компани байгаа юм энэ импортоор оруулж ирээд түрээсэлдэг ААН-үүдэд ямар шаардлага тавьж байгаа юм. Тусгай зөвшөөрлөөр явах юм уу? Яаж явах юм бол? Нөгөө тусгай зөвшөөрлийн чинь тоог нь багасгана. Хүнд суртлын арилгана гээд яриад байдаг. Тэрэнтэйгээ хэр нийцэх юм бол гэсэн ийм 2 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг.

П.Батчимэг: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ цахилгаан дугуй үйлдвэрийнх нь нэршил нь сурон тийм ээ. Үнэхээр сүүлийн үед бол цахилгаан дугуй скүтер энэ суроны эрэлт нийлүүлэлт маш огцом өсөж байгаа. Үүнтэй холбоотойгоор осол гэмтлийн, бэртлийн, эрсдэлийн тоо үнэхээр бүр улам их болж байгаа юм аа. Энд хуульд цахилгаан дугуй, цахилгаан скүтрийн жолооч нь замын хөдөлгөөнд оролцохдоо унадаг дугуйн зам буюу унадаг дугуйн эгнээгээр явна гээд заасан байгаа. Хэрэв унадаг дугуйн зам болон унадаг дугуйн эгнээ байхгүй эсвэл түүгээр явах боломжгүй тохиолдолд явган хүний замаар хурдыг цагт 10 км-ээс хэтрүүлэхгүй явна гээд. Ингээд хурдных нь дээд хязгаарыг заагаад өгчихсөн. Ямар тохиолдолд зорчих вэ гэдэг юуг нь энэ дээр хуулиар заагаад өгчихсөн учраас энд заавал явган хүний замаар зорчино оо гэсэн тийм юу байхгүй байгаа. Өнөөдөр гэхдээ манай нийслэл хотод энэ хот төлөвлөлттэй холбоотой замын асуудал маш хүнд байдаг. Унадаг дугуйн зам хүртэл ховор ийм байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ нөхцөл байдлыг ойлгоод нөхцөл байдалдаа тулгуурлаж цаашид энэ замын асуудал суран скүтрийн тусгайлсан замыг бий болгох энэ асуудал дээр хууль хэрэгжилтийн шатад явах юм аа.

Зөвшөөрлийн тухай асуудал хөндөгдөж байна. Энэ зөвшөөрөл олгосноор энэ бизнес эрхлэгч ААНБ зөвшөөрөл авснаар ер нь энэ скүтер, сурон, цахилгаан дугуй унаж хэрэглэх энэ хэрэглэгчдийн үүрэг хариуцлага нөгөө талаасаа бизнес эрхлэгч ААН-үүдийн үүрэг хариуцлага бүртгэлийн асуудал дагалдаж явах юм. Тэгэхдээ энэ зөвшөөрлийн асуудал дээр энэ хуулийн зүгээр нэг л хэсэг байгаа. Дахиад хуулийн хэлэлцэх шатад бол энэ Зөвшөөрлийн тухай гишүүд ярилцаж энэ асуудал дээр дахин хэлэлцэж болно оо.

Д.Амарбаясгалан: Наранбаатар гишүүн тодруулж асууя.

Н.Наранбаатар: Хуулийн хэлэлцэх эсэхийг бол дэмжиж байна тэгээд ажлын хэсэг байгуулагдаад нэлээн сайн ажиллах ёстой байх. Тэгээд шинэ тутам эхэлж байгаа юм чинь янз бүрийн алдаа оноо байхыг үгүйсгэхгүй ээ. Тийм учраас энийгээ цааш нь сайжруулаад ингээд хуулиа баталж гаргах нь зүйтэй байх гэж бодож байгаа юм аа. Тэгээд энэ хуулиа маш сайн сурталчлах хэрэгтэй. Хүүхэд, залуучууд, иргэддээ энийг оруулж ирэх гэж байгаа ААН-үүд оролцогч талууд бүгдэд нь сурталчилгааг сайн хийх хэрэгтэй. Бидэнд нэг дутагдалтай зүйл байдаг. Хууль хэлэлцэх, хуулиа батлах, хуулиа гаргах энэ процессоо ард иргэддээ сайн нөгөө мэдээлж, сурталчилж чаддаггүй. Гэв гэнэт нэг өдөр хууль гарчихдаг. Тэгээд маргааш нь баахан торгууль, зөрчил энэний чинь араас хариуцлага гараад ирдэг. Ийм юмнууд ороод хүмүүстээ төвөг чирэгдэл болох вий л гэж хэлэх гэсэн юм. Тийм учраас сурталчлах, ажлаа танин мэдүүлэх, соён гэгээрүүлэх ажлаа маш сайн хийгээрэй гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын даргын захирамжаар энэ ажлын хэсэг гаргасан 2 үндсэн шалтгаан үндсэндээ сая Батчимэг гишүүн тайлбарлаж хэлж байна.

Нэгдүгээрт цахилгаан дугуй, скүтер, суран унаад замын хөдөлгөөнд оролцож байгаа нэг хүндрэл үүсэж байгаа нөхцөл, ахиад явган зорчигчийн хөдөлгөөнтэй холилдож байгаа 2 дахь энэ зөрчлүүдийг яаж цэгцлэх юм гээд. Жишээлбэл Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмээр 18 насанд хүрсэн иргэн тусгай жолооны үнэмлэхтэйгээр энэ өндөр хурдтай тээврийн хэрэгслийг жолоодож хөдөлгөөнд оролцох боломжтой мөртөө насанд хүрээгүй хүүхдүүдийн унаад замын хөдөлгөөнд оролцож байгаа асуудал чинь өөрөө энэ 8 нас эрүүл мэндийн хувьд хохирол үүсгэх, бусдын эд хөрөнгө, бусдын эрх чөлөөнд хохирол учруулах нэг ийм хүндрэл үүсжээ гээд ингээд Улсын Их Хурлын өмнөө тавьсан стратеги зорилгын хүрээнд хууль өөрөө цаг үеэсээ хоцрогддоггүй, хүний эрхийн зөрчил үүсгэдэггүй, иж бүрэн зохицуулалтаа хийдэг байх гэдэг энэ 3 зорилтыг хангах шаардлагатайгаар энэ хуулийн төслийг бол өнгөрсөн намар боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Тэгээд Батчимэг гишүүн тэргүүтэй ажлын хэсэг богино хугацаанд төрийн байгууллагатай, цагдаагийн байгууллагатайгаа идэвхтэй хамтарч ажилласны үндсэн дээр энэ хуулийн төсөл хэлэлцүүлэхээр орж ирж байгаа.

Тэгээд хаврын чуулганаар энэ асуудлыг бид хэлэлцэх эсэхийг нь шийдээд намрын чуулганаар эцэслэн батална гэсэн ийм зорилго тавьж ажиллаж байгаа гэдгийг нэмж хэлье. Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг асуулт асууя.

О.Номинчимэг: Баярлалаа. Энэ яах вэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь дэмжээд тэгээд ХЗБХ дээр нэлээн нарийвчилсан ажлын хэсэг гараад нарийн харна гэж бодож

байгаа. Гэхдээ яах вэ зүгээр миний хувьд энэ үзэл баримтлал дээр тусаж байгаа энэ асуудал дээр нэг л байр суурь илэрхийлж байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр бид нар энд алхдаг ийм явган хүнтэй ээлтэй хот бүтээх гээд байна уу, үгүй юу гэдгийн асуудал энэ дээр хөндөгдсөн. Тэгээд суроны хувьд бол яах вэ насны хязгаарыг нь ингээд заагаад аюулгүй байдлаа хангая гэдэг энэ зохицуулалтыг нь дэмжиж байна. Скүтэр дээр болохоор 16 нас гээд яах вэ орж ирж байгаа юм байна. Тэгээд ингээд скүтэр, эко байк энийгээ болохоор явган хүний замаар явах боломжтой байхаар хуульчилж байгаа дээр л би эсрэг байр суурьтай байгаад байгаа юм. Дугуйн замаар явна. Явахгүй бол боломжгүй гэххэж байгаа эсвэл байхгүй боломжгүй гэдэг нь юу гэсэн ч үг юм. Явган хүний замаараа хамтдаа яв. Тэгээд 10 км/ цагаас хэтрүүлэхгүй бай гэдэг зохицуулалт орж ирж байгаа. Энэ миний харж байгаагаар амьдрал дээр хэрэгжих боломжгүй, 1 дүгээрт.

Хоёрдугаарт. Тэгээд бид нар скүтэртэй, эко байктай хүнд давуу эрх олгох уу, явган хүндээ давуу эрх олгох уу гэдэг асуултад энэ хуулиар бол скүтэртэй, эко байктай хүмүүст давуу эрх олгоё гэдэг хариулт өгч байгаа юм шиг санагдаад байгаа. Явган хүний зам бол явган хүний л зам байх ёстой. Тэрүүгээр дунд сургуулийн хүүхдүүд, хүүхдээ тэрсэн ээж нар, ахмадууд алхаад ойр тойронд алхаад явж байдаг. Тэгээд энэ замыг нь скүтэртэй, эко байктай хүмүүст хэрэглэх ашиглах боломжийг нь ингээд хуульчлаад оруулаад өгчихөөр ер нь цаашдаа Монгол Улсад Улаанбаатар хотод ч байдаг юм уу явган хүн алхах ер нь боломжгүй. 16-аас дээш насныхан тэр эко байк эд нар унаад хүүхдүүд яах юм мэдэхгүй. Аюултай учраас яршиг машинаа уна гэж байгаа юм шиг л бодлого руу орчих вий дээ гэж би санаа зовниж байгаа.

Тэгэхээр энийг бол ажлын хэсэг гараад ажиллаж байхдаа энэ бодлогын асуудал дээр бол шийдэл гаргаад явах байх гэж харж байгаа. Зүгээр энэ мэдээж яах вэ ингээд аль хэдийн ороод ирчихсэн бүтээгдэхүүн байгаа учраас гэж харж байгаа байх. Гэхдээ бид нар Монгол Улс ингээд харахаар нэг ийм анархи байдал руу аягүй олон юман дээр гарч байгаа. Цахим мөрийтэй тоглоомын асуудал ч байна тамхи, вепний асуудал ч байна. Яг энэнтэй адилхан скүүтэр, мото байк, суроны асуудал ямар ч зохицуулалтгүй явсаар байгаад ингээд нийгэмд энэ нь асуудал болчихсон. Араас нь дандаа хөөж бид нар зохицуулах гэж оролддог. Тэгээд яах вэ Батчимэг гишүүнийг энийг ингээд зохицуулах гээд чамбай хууль боловсруулаад орж ирж байгаад талархаж байгаа. Гэхдээ энэ маань ямар үр нөлөө өгч байгаа юм бэ гэдгээ бид нар хаа хаанаа бодлого ёстой байгаа юм. Тэгээд нэгэнт л бид нар явган эрүүл явган хүнийхээ замыг явган хүндээ л зориулъя. Эрүүл явган алхдаг, ийм хоттой, больё, хүндээ ээлтэй хоттой больё гэж ингэж байгаа бол явган хүний замаа явган хүндээ л зарцуулчихмаар байгаа юм.

Нөгөө талаар явган хүний замаар явуулахгүй ээ, скүтэр, эко байк чинь зориулалтын замтай дугуйны замтай юу гэдэг юм ийм замтай байна гээд хуулийн зохицуулалт ороод ирчих юм харин ч нөгөө бизнесүүд маань ч гэсэн өө энэ чинь явган хүний зам биш ийм замаар явах юм байна гээд тэр тийм зориулалтын зам байгуулах ажил дээр илүү оролцоотой илүү хөшүүрэг болох болов уу гэж бодож байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бас манай ажлын хэсгийнхэн нарийвчилсан явган хүний замын зорчигчийн судалгаа эд нар хийсэн юм уу? Яагаад энэ явган хүний замаар ийм юм оруулж явуулна гэдэг дээр ийм шийдэл болчхов гэдгийг нэг бас тайлбарлаад өгчихмөөр байна. Тэгээд яах вэ ингээд нөгөө агаар орчны бохирдол, ногоон зээл гээд л бид нар баахан ярьдаг. Ер нь сүүлд харахад банкнуудын ногоон зээл ихэнхийг нь энэ скүтер худалдаж авахад зарцуулчихдаг юм байна лээ шүү дээ эко бай гээд. Тэгээд ингээд энэ баахан хувийн ч бай хувьсгалын

ч бай скүтерүүд ороод ирчихсэн. Аюулгүй байдлын үнэхээр зохицуулалт нь юу юм гэрлэн дохиотой юм уу, үгүй юм уу гээд олон асуудал байгаа юм.

Дээр нь энэ 10 км/цаг гэдэг бол хэрэгжихгүй ээ. Явган хүний замаар явахдаа хэн энийг барометр, спидометр бариад явган хүний зам дээр энийг хэмжээд зогсож байх юм? Ер нь боломжгүй шүү дээ. Бүх хүн явган хүн явж байгаа хүмүүс эсвэл ийм спидометртэй хажуугаар өнгөрч байгаа юмаа хэмжээд чи 11 болчихлоо торгуулъя гээд ингээд байж байх юм уу? Тэгэхээр хэрэгжих боломжгүй байгаа учраас энийг нэг эргэж.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. 4 дүгээр индэр. Баярлалаа.

Ө.Жамбалсүрэн: Номинчимэг гишүүний асуултад товч хариулт өгье. Улсын Их Хурлын гишүүн Батчимэгийн зөвлөх Жамбалсүрэн гэж хүн байна. Тэгэхээр хуулийн төсөлд, хуулийн төслийг нэлээн өргөн хүрээтэй хэлэлцүүлж явсан. Мэдээж үйлчилгээ эрхлэгчдийн саналууд ч тодорхой байр суурь илэрхийлж байсан.

Нэгдүгээрт бол явган хүний зам дээр зөвшөөрч байгаа нэг нөхцөл нь болохоороо одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа манай 2018 онд батлагдсан Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэмдийн 25.5 дээр унадаг дугуйгаар явган хүний замаар 10 км-ээс хэтрүүлэхгүй явган зорчигчдод саад учруулахгүй байвал зохино гэсэн энэ заалтыг харгалзаж үзсэн.

Хоёрдугаарт энэ Гэмтэл согог үндэсний төвөөс ирүүлээд байгаа энэ гэмтэл статистикийн тоон мэдээлэл дээр ер нь цахилгаан дугуй скүтертэй холбоотой статистик тоон мэдээллийнх шалтгааны эхний 2-т бол 17 орчим хувь нь мопед, цахилгаан дугуй, скүтерийн жолооч автомашинд мөргүүлэх тохиолдол ихсээд байгаа юм. Харин явган зорчигчтой мөргөлдөх тохиолдол нь 6.6 буюу 64 гэсэн ийм тоо үзүүлэлтүүд статистик үзүүлэлтүүд байсан. Мөн дэлхийн улс орнуудын хувьд нийтдээ нэг. Европын орнуудаас 10 орчим улс орон байна. Казакстан, Эстони, Словак, Хорват, Латви, Норвег, Польш, Португал, Грек гэсэн ийм 10 улс орнуудад бол явган хүний зам дээр 6-аас 10 км/цагийн хурдтай байхыг зөвшөөрсөн ийм хууль эрх зүйн орчинтой байна. Казахстан улс бол хэдийгээр 6 км/цагийн хурдтай явахыг зөвшөөрсөн боловч тус улсын Алмата хотод жишээ нь авто замын зорчих хэсгийн 1 дүгээр эгнээн дээр цахилгаан дугуй скүтерээр явахыг зөвшөөрсөн гэсэн ийм сайн туршлагууд байна.

Тэгэхээр ер нь бол үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлж байгаа санал нь юу вэ гэхээр бид нар энэ 5 км цаг ч юм уу 10 км/цаг гээд бүрэн хориглох юм бол эргээд өнөөгийн манай авто замын сүлжээний нөхцөл байдал авто авч автомашины нөхцөл байдалтай холбоотойгоор автомашины зам дээр гарах осол аваар нэмэгдэнэ шүү л гэдэг ийм болгоомжлолыг л хэлээд байгаа юм аа.

Тийм учраас энэ нөхцөл байдлуудыг харгалзаж үзэж мэдээж явган зорчигчийнхоо эрх ашиг мөн дугуйгаар зорчигч хэрэглэгчийнхээ эрх ашиг гэдэг 2-ыг аль болох тэнцүүлэх зорилгоор л 10км цагийн хурдтай хэтрүүлэхгүй явна. Явган зам дээр явган зорчигчийн давуу талтай байна л гэсэн зохицуулалтыг оруулж ирсэн байгаа.

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн тодруулж асууя.

О.Номинчимэг: Яах вэ тэгээд бодит байдал дээр ингэдэг шүү дээ. Хүүхдээ дагуулаад явж байгаа ч гэдэг юм уу, юм түрээд явж байгаа хүн ёстой урдаас нь хойноос нь нэг эко байк гарч ирнэ. Ардаас нь хөөе би хөөе холдоорой гээд л нэг скүтер явна. Тэгээд та нар үйлчилгээ эрхлэгчдийн саналаар бол явган хүнээрээ явган хүний замаараа явуулахгүй бол харин автомашины замаар яваад улам осол гарна шүү гэдэг саналыг үндэслэсэн гээд байх юм. Та хэд яг иргэдээсээ санал авсан юм уу? Иргэд чинь явган хүний замаараа явган хүмүүс л явмаар байна янз бүрийн цахилгаан хэрэгсэл явуулмааргүй байна гэдэг санал өгч байгаа шүү дээ.

Тэгээд яг энэ хэний саналыг нь аваад хэний саналыг нь авдаггүй юм? Тэрийг бодолцож үзмээр байна.

Хоёрдугаарт 10 км цагийг чинь хэн ч хэмжээд зогсож байхгүй спидометр. Худлаа наадах чинь. Тэгээд 10 км цагаар явж байгаа ийм цахилгаан скүтер эко байк чинь 50 кг-ын жинтэй хүнтэй очиж мөргөх юм бол 6-аас 10 килограмм юм ачаад дээр нь ингээд шууд шидэж байгаа юм шиг ийм цохилт өгдөг гээд.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя. 4 дүгээр индэр.

Ө.Жамбалсүрэн: Хуулийн төслийн талаар 5 сарын 27-нд олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Эндээс иргэдийн зүгээс бол явган зам дээр одоо мэдээж энэ саналыг мэдээж ирүүлсэн. Гэхдээ бид өнөөгийн авто замын нөхцөл байдалтай холбоотойгоор мөн саяын дурдсан Гэмтэл согог үндэсний төвөөс ирүүлж байгаа, ЭМЯ-наас ирүүлж байгаа гэмтэл статистикийн тоон мэдээллээс харахад бол энэ цахилгаан дугуй скүтертэй холбоотой гэмтлийн 2 дахь том шалтгаан бол энэ авто зам дээр зорчиж байгаатай холбоотой байна гэдэг ийм тооцоо өгч байгаа.

Өнөөдөр ч гэсэн авто зам дээр мотоцикл мопедын осол аваар хүртэл бараг өдөр тутам ийм гарч байгаа нөхцөл байдлууд анзаарагдаж байгаа юм аа. Тийм учраас энэ өөрөө эрсдэл бий болгох магадлалтай байна л гэдэг зүйлийг энэ тоон үзүүлэлт дээр суурилж өгсөн байгаа.

Хоёрдугаарт энэ хэрэглээг дэмжих гээд байгаа нэг том шалтгаан бол НҮБ-ын тэр 2020 оны тогтоол дээр 2021-ээс 2030 он хүртэл зам тээврийн осол аваарыг бууруулахтай холбоотой тогтоол дээр. Ер нь бол 2030 он гэхэд гишүүн улс орнууд бол энэ хувийн авто тээврийн хэрэгслийг.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Энэ 2021-ээс 2030 он хүртэлх энэ үйл ажиллагааны төлөвлөгөө гэж гарсан. Энэ тогтоол дээр гишүүн улс орнуудаа юу гэж уриалаад байгаа вэ гэхээр ерөөсөө энэ хотожсон суурин, хот төвлөрөл ихэссэн энэ улс орнуудад аль болох энэ хувийн авто тээврийн эрсдэлийг хязгаарлах замаар олон төрөлт тээвэр буюу унадаг дугуй, цахилгаан дугуй мөн явган алхах ийм орчныг бүрдүүлээч л гэдэг ийм зүйл хэлээд байгаа юм.

Тэгэхээр өнөөгийн манай энэ нөхцөл дээр бид бол яг энэ нөхцөл байдалдаа, энэ гэмтэл согог, тэр ирүүлсэн мэдээлэл дээр суурилж л ийм арга хэмжээ зөвшөөрөхөөс аргагүй л ийм нөхцөл байдалтай л энэ хуулийн төсөлд оруулж ирсэн.

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн дахин тодруулж асууя.

О.Номинчимэг: Яах вэ зарим шийдлүүдийг чинь бол би дэмжиж байгаа. Гэхдээ яг энэ явган хүний замаар явуулах гэж байгаад энэ шийдэл чинь бол шийдэл биш ерөөсөө одоогийн нөхцөл байдлыг ерөөсөө өөрчилж чадахгүй. Тэгээд тэр нэг НҮБ-ын юу хэлж байна л даа тэр чинь ер нь бол дугуй, явган хүнийг л дэмжье гэж байгаа шүү дээ. Тэгээд бид нар явган хүнээ ч бүүр явуулахаа больё эко байк, скүтер нь байдаг байя л гэдэг бодлого гаргаад байна.

Тэгэхээр энэ энийгээ дахиж нэг хараад ажлын хэсэг байгуулагдаад явах дээр Улсын Их Хурал дээр энэ бодлогыг бол нэлээн нухацтай авч хэлэлцэх ёстой. Тэгээд дээр нь тусгай замаараа явна гээд заагаад өгчих юм бол өөрөө энэ үйлчилгээ эрхлэгч байгууллагууд чинь үнэхээр ашиг олдог л юм бол тэр зам харгуйгаа засах, нэмэлт зам тавих дээр ч гэсэн өөрсдөө оролцоотой орчих байхгүй юу. Тийм хөшүүрэг хийж өгөхгүй бол энэ хүмүүс бол хэзээ ч дугуй скүтерийн янз бүрийн зам тавья гэдэгт оролцохгүй. Явган хүнийхээ замаараа л явуулчихъя. Өөрсдөд нь бол ямар ч ашгийн юугүй болчихлоо шүү дээ тэ. Шаардлагагүй болчихлоо шүү дээ явах юунд нь тэгээд. Ийм юмыг бодолцож үзчихээд дахиад өөрчлөх.

Номинчимэг гишүүнтэй ер нь санал нэг байна. Ерөнхийдөө бид байгаа нөхцөлдөө тааруулах биш олон улсынхаа жишгийг дагаж хүнийхээ эрхийг хангах хамгаалах чиглэл дээрээ төвлөрч ажиллах нь зүйтэй гэж бодож байна. Тэгээд хэлэлцэх эсэхээ дэмжихвэл Номинчимэг гишүүн боломжтой гэж үзвэл энэ ажлын хэсгээ ахлаад байгуулаад, ажиллаад явах нөхцөлөөр хангая. Олон талаас нь харах зайлшгүй шаардлага байгаатай санал нэг байна. Бид нэг удаагийн шийдлээр өнөөдрийн байгаа нөхцөлдөө тааруулсан гал унтраах ажлыг хийж болохгүй гэдэгтэй бол санал нэг байгаа учраас тийм зүйлтэй байна.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Сая хэлсэн Номинчимэг гишүүний байр суурьтай бас яг адилхан байр суурь илэрхийлж байгаа, дэмжиж байгаа. Тэгээд бид нар яг энэ нөгөө явган хүний зам өөрөө явган хүний л зам байх ёстой. Өөрөөр хэлбэл унадаг дугуйн зам байхгүй гэдэг эрсдэлийг явган хүн үүрмээргүй байгаа. Техник хэрэгсэлтэй хүмүүс нь илүү энэ эрсдэл дээрээ байрших ёстой болов уу гэж харж байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, бас нэг ийм зүйлийг бид нар нэг харъя. Энэ хуулийн төслийн 12¹ дээр 16-аас дээш насныхан оролцох замын хөдөлгөөнд оролцох эрхийг хэдүүлээ нээгээд өгчихлөө. Тэгэхээр 16-аас 18 насны өөрөөр хэлбэл насанд хүрээгүй хүүхдүүд одоо яг л нөгөө авто замаар энэ скүтер цахилгаан дугуй, сурон унаад авто замын хөдөлгөөнд оролцох болох гээд байна л даа. Тэгээд хойшоогоо ингээд харахаар цахилгаан дугуй, цахилгаан скүтерийн жолоочид дараах зүйлийг хориглоно гээд.

Тэгэхээр эсвэл 16-аас 18 насныханд тийм тусдаа эрх сургалтын тийм систем үүсээд эрх өгөх гээд байна уу эсвэл яг одоогийн байгаа системээрээ 16-аас 18 насныхныг яг энэ том энэ замын хөдөлгөөнд оролцуулах ийм эрхийг нээх гээд байна уу гэдэг дээрээ нэг хариулт өгөөч? Энэ жаахан эрсдэлтэй харагдаад байна.

Хоёрдугаарт тэр явган хүний зам дээр энэ скүтерүүдийг байрлуулж байгаа тэгээд энэ яг 12.6 дээр бас энэ скүтерүүдийг байршуулах байр талбай дээр ерөөсөө зохицуулалт ороогүй байна. Гэхдээ энэ хэм хэмжээний актыг нь тухайн орон нутаг

өөрөө гаргана гээд ингээд зохицуулалтад тавьчихсан байна. Тэгэхээр зарчмын хувьд бол ерөөсөө явган хүний зорчих хэсэг явган хүний зам талбайд энэ сурон, скүтер ямар нэгэн байдлаар саад болохгүй байх буюу хамгийн түрүүнд явганаар зорчиж байгаа иргэдийн эрхийн асуудлаа нэгдүгээрт эрэмбэлээд ингэж ийм байдлаар хармаар байна гэсэн үг.

Хоёрдугаарт хэдүүлээ нэг ийм зүйлийг нэг бодож үзвэл яадаг юм бол? Нөгөө шилжилтийн үеийн зохицуулалтууд гэж байж болно шүү дээ. Энэ тохиолдолд. Одоогийн байдлаар нийслэл хотын хэмжээнд тэчнээн километр дугуйн авто зам байлаа гэж бодоход тухайн авто зам 2 жил, 3 жилийн дараа тэчнээн километр болно тэр үед нь 18 нас хүрсэн хойно нь авто замын хөдөлгөөнд оролцуулна ч гэдэг юм уу ийм нэг ийм уян хатан байх талаас нь судалгаа зохицуулалтын тал дээр судалгаа хийсэн зүйл байдаг юм болов уу гэдэг ийм асуулт байна. Тэгээд хамгийн гол зүйл нь түрүүн хэлсэн явган хүний эрхийн асуудал дээр бид нар хэдүүлээ 1 дүгээрт гэдэг эрэмбээрээ байх нь бол илүү зөв байх болов уу гэж бодож байна.

Тэгээд тэнд чинь гал ганцхан нөгөө хүүхэд, настай хүн, дээрээс нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гээд маш олон ийм олон төрлийн зорчигч явган хүний зам дээр явж байгаа. Авто зам дээр зөвхөн автомашин унаж байгаа хүмүүс зорчиж байгаа тэ? Тэгэхээр ийм зүйлүүд дээр ялгааг нь харах ёстой байх аа. Түрүүн зөвлөх хэн Жамбаа зөвлөхийн хэлсэн дээр яах вэ нэг зүйлийг бид нар нэг харъя. Тэртээ тэргүй ингээд нөгөө насыг нь заагаад өгчихөөр авто зам дээр оролцож байгаа тоо цөөрөх болов уу гэж харж байна. Тэр чинээгээрээ эрсдэл буурах болов уу гэж харж байна.

Тийм учраас насны хязгаартайгаар энэ авто замын хөдөлгөөнд скүтер дугуйгаа оруулж байгаа учраас явган хүний зам дээр байх нь илүү аюулгүй гэдэг нөхцөл маань өөрөө үгүйсгэгдэх байх гэж харж байгаа шүү гээд. Тэгэхээр энэ 2 асуудал дээр шилжилтийн үеийн ямар зохицуулалт байж болох вэ гээд.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Хэн хариулах вэ? 4 дүгээр индэр.

Ө.Жамбалсүрэн: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр 16-аас 18 насны иргэдийн хувьд хэрхэн зохицуулж байгаа вэ гээд. Тэгэхээр ер нь бол дэлхийн ихэнх улс орнуудад 14-өөс 16 насны иргэдэд цахилгаан скүтер яг нийтийн хэрэгцээний цахилгаан скүтерийг нийтийн эзэмшлийн зам дээр зорчих насыг тэгж хязгаарлаж 14-өөс 16 насны хооронд тогтоож байна. Манай өнөөдрийн мөн замын хөдөлгөөний дүрэм дээр мопед 16 настай иргэн унах эрхтэй байгаа. Иргэний хуулиар 16 настай иргэн насанд хүрээгүй иргэн зарим чадамж хүлээсэн ийм иргэн байдаг. Энэ утгаараа бол эдгээрийг харгалзаж үзэж байгаад 16 насны хүн замын хөдөлгөөнд оролцох ийм оролцоотойгоор ингэж журамлаж өгсөн. Жолоочийн үүрэг хариуцлагыг бол энэ удаагийн хуулийн төсөл дээр илүү замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага талаасаа илүү түлхүү нэн түрүүнд зохицуулж ирсэн тэр сургалтын энэ асуудлуудыг бол хууль хэрэгжүүлэх шатад хийх бололцоотой болов уу гэсэн ийм хариулт өгье өө.

Асуулт нь юу гэсэн бэ асуултыг нь дахиад нэг тодруулаад өгчих үү? ЗХАБТХ-ийн төсөл одоогоор шилжилтийн үетэй холбоотой ямар нэгэн зохицуулалт тусгаагүй байгаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай, намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаггүй, гишүүдээс дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ.

Хоёр гишүүний нэр ирсэн байна. Ганзоригийн Лувсанжамц гишүүн индэр дээрээс. 1 дүгээр индэр.

Г.Лувсанжамц: Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе ээ.

Батчимэг гишүүнээр ахлуулсан энэ ЗХАБТХ-ийг шинэчлэх өөрчлөх энэ ажлын хэсэгт нь орж ажилласан. Ажлын хэсэг маш идэвхтэй ажилласан. Олон нийтийн оролцоог хангасан. Ялангуяа хэрэглэгч нар болон явган зорчигч нар дээрээс нь нэмээд үйл ажиллагаа явуулж байгаа Тапа, Жет, Эко байк гэсэн энэ ААН-үүдийн оролцоог хангаж хуулийн төслийг боловсруулсан. 20 гаруй улс хотуудын зохицуулалтын арга барилыг нь судлаад Монгол Улсын нөхцөл байдал ялангуяа Улаанбаатар хотын зам тээврийн аюулгүй байдлын нөхцөл байдал дээр үндэслээд мөн бусад хууль эрх зүйн орчин ямар байгаа вэ гэдгийг нь харгалзаж үзсэний үндсэн дээр энэ хуулийн төслийг боловсруулсан.

Энэ хуулиа дэмжиж үг хэлэх гэж байна. Үг хэлэхээсээ илүүтэйгээр шийдэл ярих гэсэн юм. Ажлын хэсгийн хурлууд дээр маш их олон удаа хэлсэн. Тэгэхээр энийг цаашдаа энэ хууль маань намрын чуулган болгоод ажлын хэсэг байгуулагдаад засах зүйл байгаа. Засаад тэгээд батлагдаад ирэх жилээс бодитоор хэрэгжээд эхэлнэ гэсэн. Ийм төлөвлөгөөтэй байгааг нийт хэрэглэгч нар болон ААН-үүд мөн дээрээс нь нэмээд нийслэл дүүргийн албан хаагч нартаа зам тээврийн цагдаагийн албаныхандаа хэлмээр байна. Нэгдүгээр шийдэл их тойруу дотор явган дугуйн замыг бүрэн болгох хэрэгтэй. Өнөөдөр явган дугуйн замын засвар, арчилгаа тохижилтын ажлыг дүүргийн Засаг дарга нар хариуцаж байгаа. Дугуйн зам байхгүй байх юм бол дугуйн замтай болгох хүсэлтийг түүнийг хэрэгжүүлэх ажлыг дүүргийн Засаг дарга хариуцаж байгааг хэрэглэгч болон явган зорчигч мөн хувийн хэвшлийнхэн маань сайн бодоорой.

Өнгөрсөн намрын чуулганаар бид нар ААНОАТ-ын нэг хувиар нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулах эрхийг нь нээж өгсөн. Энэ дээрээ энэ нэг хувийн үйл ажиллагаа нь борлуулалтынхаа орлогыг ашиглаад дугуйн замыг их тойруу дотор зөв болгож өгөх ёстой бүрэн болгож өгөх ёстой. Энэ дээр дүүргийн Засаг дарга нар хувийн хэвшилтэйгээ хамтраад манлайлаад явах ёстой тийм ажил зөвхөн Улсын Их Хурал гүйцэтгэх юмыг яриад дотор нь ороод байх ямар ч боломжгүй. Хууль эрх зүйн үндсийг нь тавьж өгсөн. Цаашаа манлайлаад явахыг нь бол хувийн хэвшил ялангуяа дүүргийн Засаг дарга нар манлайлж явах ёстой гэсэн тийм байр суурьтай байна.

Хоёрдугаарт нь Зам тээврийн цагдаагийн алба болон Замын хөдөлгөөн удирдлагын төвд нэг шийдэл хэлсэн. Үүнийг заавал хэрэгжүүлэх ёстой. Урин дулаан цагаар авто замын 1 дүгээр эгнээг зөвхөн автобус бус дугуй болон скүтрээр зориулалттай зорчих боломжийг нь нээж өгөх ёстой. Тэгж байж бид нар явган зорчигчдынхоо эрх ашгийг аюулгүй байдлыг хамгаална.

Тэгэхээр 5 сарын 1-нээс 10 сарын 1-ний хугацаанд жишээлбэл 3 эгнээ замтай төв замуудын 1 дүгээр эгнээг нь энэ зорчигчдоо зориулж нээж өгөх ёстой. Энэ бэлтгэл ажлыг гүйцэтгэх түвшиндээ, гүйцэтгэх засаглалын түвшиндээ хийгээд явах ёстой байна аа. Ийм ажил байна.

Гуравдугаарт нь хувийн хэвшлийн 3 байгууллагадаа хандаж өмнө нь 2 ч удаа хэлсэн зүйлээ 3 дахь удаагаа хэлэх гэж байна. Та бүхэн маань их өгөгдөлд суурилсан шинжилгээг хийгээд иргэд хэрэглэгч нар хаагуур зорчиж байгаа тэр замуудыг гаргаж өгөх ёстой. Үүнийгээ Хот байгуулалтын газартай хамтраад зогсоол болон зориулагдсан эгнээг хаана гаргаж өгөх вэ гэдэг төлөвлөгөөгөө хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж өгөх ёстой. Тэгэхлээр хувийн хэвшлийн оролцоо маань энэ дээр маш их чухал байгаа шүү. Та хэд маань энийгээ манлайлаад ажиллах ёстой. Сая Баасанжаргал гишүүн асууж байсан. Шилжилтийн үеийн зохицуулалтыг яах вэ гээд. Аппликэйшнийг нээгдэхэд нь хагас жилд нэг удаа замын хөдөлгөөний дүрмийн тестийг авах ёстой. Тэгж байж энэ скүтэр болон мопедийг ашиглах эрх нь нээгддэг тийм журмыг энэ 3 хувийн Жет, Эко байк 3 маань аппликэйшн дээрээ шинэчилж хийж өгөөд түүгээр зорчих хүнд нь замын хөдөлгөөний дүрмийг барих ёстой гэсэн тэрийг шалгалтдаа тэнцэж чадахгүй байх юм бол унах эрх нь нээгдэхгүй байдаг ийм зохицуулалтыг нь хийж өгөх ёстой ийм асуудлууд байгаа.

Тэгэхээр сая хэлсэн энэ 3 шийдлийг холбогдох байгууллагууд нь анхаарч ажиллаад иргэд маань энэ дээр оролцоод.

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандхай гишүүн үг хэлнэ.

Нэгдүгээр индэрт урьж байна.

М.Мандхай: Би гол нь асуулт асуух байсан боловч асуулт асуучхаад амжсангүй. Тэгээд үг хэлье гэж бодлоо. Манай энэ ажлын хэсгийнхэн анхааруулж нэг зүйл хэлмээр байна. 2022-оос 2023 онд нийт Скүтэр болон энэ цахилгаан дугуй, сурон нийлүүлсэн тоо хэмжээ 8 дахин нэмэгдсэн байна. Зөвхөн нэг жилийн дотор. 2023-аас 2024 онд 50 хувь нэмэгдсэн байна. Ингээд 2024 оны байдлаар 16783 цахилгаан дугуй скүтэрийн тоо өдөрт хүрсэн юм байна аа. Одоогийн байдлаар яг энийг ашиглаж байгаа аппликэйшн ашиглаж байгаа иргэдийн тоо 1.1 сая.

Тэгэхээр энэ нийлүүлэлтийн энэ эрчтэй явж байгаа нийлүүлэлтийг манай яг одоо энэ замын хөдөлгөөнийг зохицуулж байгаа байгууллагууд болон хот төлөвлөлт өөрөө яг амжиж энэтэй хөл залгуулж зохицуулалт нь ингээд аюулгүй байдлыг хангаж ажиллаж чадах уу гэдэг дээр бас анхааруулж хэлмээр байна. Одоо жишээлбэл энэ хууль дээр хэрэгжих орчны нөхцөл байдал хангалтгүй байгаад байгаа юм. Жишээлбэл бид нар нэгэнт ингээд насны хязгаар тавиад хурдны хязгаар тавиад явж байгаа ч гэсэн бид нар энэ чинь өөрөө хот төлөвлөлттэйгөө уялдаж явах ёстой. Бид нар хуулиа түрүүлээд баталчихдаг. Гэтэл дэд бүтэц болон хот төлөвлөлтийн орчин чинь өөрөө бүрдээгүй байхад одоо бид нар энэ хурдтай явж байгаа нийлүүлэлтийг яаж зохицуулах юм бэ гэдэг дээр бас учир дутагдалтай харагдаад байна.

Тэгэхээр энэ хэрэгжих орчны нөхцөл хангалтгүй байгаа дээр анхаарах хэрэгтэй байна аа. Жижиг оператор илүү дарамттай байх юм биш үү. Техникийн үзлэг оношилгоо жишээлбэл хадгалах байрууд зэрэг шаардлагуудыг энэ старт ап

үйлчилгээ үзүүлж байгаа компаниуд өндөр босго болох вий гэдэг асуудал байна. Мөн түрүүн хэлсэн Номинчимэг гишүүн технологийн арга энэ GPS, спидометр гээд энэ хурдны хязгаарлалт автоматаар унтраах гэх мэт технологийн шийдлүүдийн энэ нэр томьёо уялдаа бас л хуулиар хангалтгүй харагдаж байна. Мөн хэрэгжилтэд хяналт тавих дэд бүтэц бүрэн тодорхой бус байна аа. Ялангуяа тэр нутгийн захиргаа энэ нийслэлийн хяналт хариуцуулсан ч гэсэн хэрэгжилт нь хангах шалгуур үнэлгээний аргачлал санхүүгийн механизмууд нь л дутуу харагдаж байна.

Жишээлбэл одоо Герман улс илүү энэ хэрэв хурд эхлэхэд спидометр гэхээсээ илүүтэй хүчээр энэ зогсоодог цаанаас нь автоматаар ашиглаж чадахгүй болоод зогсоодог зохицуулалтыг нь хийж өгдөг байгаа. Цагдаа шууд хураах эрх эрхийн тогтолцоог нь хүртэл бүрдүүлээд өгчихсөн байдаг тийм ээ. Эсвэл энэ скүүтер дээр даатгалыг хамруулж байгаа, хууль дээр даатгалыг оруулсан боловч яг даатгалыг яг яаж энэ хариуцлагын тогтолцоог бий болгох вэ гэдэг нь дахиад өшөө нарийвчилж судлахгүй бол бас л их ерөнхий заалтуудтай байна. Тэгэхээр би хэлэх үгэндээ ер нь 1 дүгээрт энэ бид нар ганцхан Зам тээврийн газар биш энэ ЦЕГ энэ нийслэл хот байгуулалтыг яаж энд татаж оруулах юм бэ? Өнөөдөр ажлын хэсэгт бол нийслэлээс энэ яг энэ хот төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжлийн хүмүүс нь ирж суух ёстой байсан байхгүй байна.

Тэгэхээр энэ хот төлөвлөлттэйгөө энийг яаж уялдуулах юм бэ? Технологийн шаардлагыг нарийвчилмаар байна. Сургалт соён гэгээрүүлэх хэрэгтэй байна? Ялангуяа энэ 16-аас 18 нас гээд бид нар насны хязгаарлалт тавьсан байгаа учраас жолоочид зориулсан богино цахим сургалтуудыг илүү тесттэй ч гэдэг юм уу оруулж ирэх хэрэгтэй байна. Яг олон улсын туршлага жишигтэй уялдуулаад. Мөн даатгалд хохирол нөхөн төлбөр төлөх тогтолцоог нарийвчилж хуульдаа оруулмаар байна аа. Энэ эрсдэлийн сангийн зориулалт ямар байх юм? Тооцоолол нөхөн төлбөрийн тэр доод хэмжээг зааж өгөх ч гэдэг юм уу?

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан дээр явагдана. Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул завсарлуулъя. 14 цаг 30 минутаас үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан шууд санал хураалтаар эхэлнэ.

ЗАВСАРЛАГА

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийг орж ирэхийг урья. Үдээс хойших чуулганы хуралдаанаа эхлүүлье. Улсын Их Хурлын гишүүдэд зар хүргэе

Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудлын дарааллаар 7 дахь асуудал руугаа орж байя.

Гишүүд чуулганы танхимд санал хураалттай учраас танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ТББХ-ны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэлд танилцуулна аа. Индэрт урьж байна.

О.Алтангэрэл: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн билээ. ТББХ 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан 40.2 дугаар зүйлд заасан журмын дагуу Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан нэг санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд тусгасан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөн, аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ТББХ-ны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Энхтайваны Бат-Амгалан Хот байгуулалт, барилга хот орон сууцжуулалтын сайд, Хишгээгийн Нямбаатар НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Маамын Үнэнбат НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга.

Энэ ажлын хэсгийн хүмүүсээ оруулаарай Ичинноровын Баттөгс Хот байгуулалт барилга орон сууцжуулалтын сайд.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Улаанбаатар хотын дарга Нямбаатар эдийн засгийн форум дээр оролцож байгаа учраас жоохон хоцорч орж ирэх юм байна. Тэгээд ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгаа учраас ажлын хэсгээс асуултаа асуугаад явж байя аа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн алга байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн алга байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн алга байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Өмнөх 2 дугаар хэлэлцүүлэг дээр саналаа хэлчихсэн. Нэг зүйлийг тодруулж асууя. Тэр таксинд татаас өгнө гэх асуудал энэний өмнө нэлээн яригдсан. Энийг яг эцсийн байдлаар нь яаж зохицуулъя гэж бодож байгаа вэ? Ер нь бол Улаанбаатар хотод ид түгжрэлийн үеэр ер нь такси явахаа больсон. Өвөл болон ялангуяа өглөөгүүр эд ачааллын үеэр хүмүүс хүүхдээ хүргэж өгөх, ажил гэр лүүгээ явах энэ үеэрээ такси олдохгүй болохоор нөгөө машин руугаа л тэмүүлэх ийм юмыг нэг хугарлын цэгийг нь зөв олж хүмүүсийг аль болохоор нийтийн тээвэр болон таксины үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ авах энэ сонирхол руу нь татахад би чиглэсэн арга хэмжээ гэж би уг нь ойлгосон.

Тэгэхээр тэрийг татаас гэдэг нь ямар хугацаанд ер нь яаж өгье гэдэг байдлаар оруулж ирсэн бэ?

Хоёрдугаарт энэний өмнө нэг би санал хэлсэн байж байгаа. Автомашины зогсоолуудыг томоохон оффисууд худалдааны төвүүд, орой болонгуут ерөнхийдөө ингээд цоожлоод явчихдаг. Гэтэл тэрний хавь ойрд байгаа болон орон сууцын буюу орой очоод машинаа тавих гэж байгаа маш олон айл өрхүүд зогсоол байхгүйн улмаас тэнд замын хажуугаар тавьдаг гарц орцыг хааж тавьдаг, магадгүй шөнө орой, өдөр орой, гал түймэр, гэнэтийн осол аваар, түргэн гал команд гээд асуудал гарахад битүү ингээд хаагаад тавьчихдаг. Энэ өөрөө эргээд Улаанбаатар хотын хувьд бол эрсдэлийн түгжрэл гэдэг энэ зүйлийг нэлээн их бий болгоод байгаа.

Тийм учраас энэ зогсоолыг шэйрлэх гэдэг ийм юмыг энэ хуульдаа давхар оруулж ирээд шийдчих ийм боломж бололцоо байгаа юу гэдэг саналыг би энэний өмнөх хэлэлцүүлгээр тавьсан. Тэгэхээр энэ тал дээр та бүгд судалсан юм байна уу? Тухайлбал одоо талбай тойрсон оффисууд, мөн зах худалдааны төвүүд дээр оройдоо 7, 8 гэхэд машинууд хоосроод хаагаад явчхаж байгаа шүү дээ. Зөрөөд хүмүүс гэртээ очих хавь ойрынхоо зогсоолуудыг ашиглуулах гэхээр маш өндөр төлбөр нэхээд тэр нь хоосон буюу манай Улаанбаатар хотын зогсоол ашиглагдах байдал шөнийн оройны 8-аас өглөөний 7 хүртэл ашиглагдаж байгаа энэ хувин дээр энэ тооцоо хийж үзсэн үү? Ингэх юм бол магадгүй хүмүүс аль аль талдаа маш их

зөв зохицуулалт болох боломжтой юм биш үү? Энэ өөрөө нэг талаар тэр замын түгжрэл буюу энэ зүйл дээр зохих хувь нэмрээ оруулах ийм боломж гарах юм биш үү гэдэг зүйлийг тодруулж асуумаар байна аа.

Дээрээс нь орон сууцжуулахад бас давхар хувийн хэвшлийг оролцуулах ийм асуудлууд нэлээн тавигдсан. Тэгээд би 20 хувьд нь ерөнхийдөө манай хувийн ААН байгууллагууд оролцож болно гэдэг ийм асуудал яригдсан. Тэгээд энэ тал дээр ямар тооцоо судалгаа шийдэгдэхээр болсон бэ гэдгийг асуумаар байна. Тэгээд ер нь гэр хорооллыг орон сууцжуулахад дэд бүтцээ дагаад л метр квадратын үнэ 7, 8 сая бараг зарим нь 10 сая ч хүрчихсэн байж байгаа байх. Тэгэхээр энэ Сэлбэ дэд төв байна, Баянхошуу дэд төв гээд дараа дараагийн юмнууд маань энэ метр квадратыг ойролцоогоор хэд хавьцаанд нь барья гэдэг тийм тооцоо судалгаа байгаа юм бэ? Яг үнэнийг хэлэхэд жирийн нэг төрийн албан хаагч нар бага дунд орлоготой иргэд бол орон сууцад ороход 1 дүгээрт метр квадратын үнэ өндөр байна.

Хоёрдугаарт банкны зээлийн хүү өндөр байна. Моргейжийн зээл үндсэндээ бараг маш хязгаарлагдмал байгаа учраас энэ төслүүдийг дэмжихэд санхүүгийн ямар эх үүсвэрүүдийг цаашид ашиглавал тооцоолж байгаа вэ гэдэг ийм асуултуудыг асуумаар байна.

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индэр. Үнэнбат дарга хариулъя.

М.Үнэнбат: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. НЗДТГ Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газар Үнэнбат.

Нэгдүгээр асуултын хүрээнд такситай холбоотой асуулт асуулаа. Монгол Улсын Их Хурлаас нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллын орон сууц учруулах тухай хуульд баталсан энэ хуулийн гол 3 зорилтын нэг нь бол энэ нийтийн тээврийг хөгжүүлэх асуудал байгаа. Нийтийн тээврийг хөгжүүлэх асуудал дээр бол энэ удаагийн өөрчлөлтөөр бол нийтийн тээвэр зөвхөн автобус гэхгүй таксид дэмжлэг үзүүлнэ гэсэн ийм ойлголт асуудал орж ирсэн. Юу байна вэ гэхээр Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн сан гэж анх энэ хуульд баталсан. Энэ сангийн хөрөнгийг зарцуулах, бүрдүүлэх, тайлагнах журмыг НИТХ баталдаг. Өнгөрсөн хугацаанд энэ журмыг 2024 оны 2 сарын 8-ны өдөр ИТХ-аас батлаад улсын захиргааны хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлчихсэн байж байгаа. Энэ хүрээндээ таксины тэр мөнгө төгрөг өгнө гэдэг юм уу ийм зүйл яриад байх шиг байна. Энэ бол тухайн сангийн хөрөнгийг зарцуулах журам дээр нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл гэж ингэж байж байгаа. Энэ төслөөр юу байх вэ гэхээр жишээлбэл ногоон үйл ажиллагааг дэмжсэн ийм төсөл хөтөлбөр байж болно. Шинэ инновац, шинэ технологи нэвтрүүлэх боломжтой байж болно гэх мэтээр такси компаниуд өөрсдөө төслөө санал болгоод энэ төслийг нь тухайн захиран зарцуулах журамд заасны дагуу шалгаж үзээд боломжтой гэвэл ямар хувилбараар дэмжлэг үзүүлэх үү гэдэг рүү явна.

Өнөөдрийн байдлаар нийслэл Улаанбаатар хотод 5 такси компани яг үндсэн тусгай зөвшөөрөлтэй байгаа. Энэ хүрээндээ 240 такси байгаа. 240 таксины насжилт гэж үзэх юм бол бараг бүгд 10 гаран жилийн насжилттай ийм таксинууд байгаа. Ер нь бол Улаанбаатар хотын бид бүх нийтийн тээврийг хөгжүүлэх чиглэлээр хийсэн судалгаанаас авч үзэх юм бол Улаанбаатар хотод.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

М.Үнэнбат: Хамгийн багадаа бол 5 орчим мянган такси байж байж нийслэлийн энэ иргэдийн хэрэгцээг хангах бололцоотой гэсэн судалгаа гарсан байгаа. Тийм учраас энэ таксины автобуснаас гадна энэ нийтийн тээвэр такси гэдэг энэ асуудлыг оруулж ирж байгаа. Мөн хуульд бол нийтийн тээвэр гэдэгт автобуснаас гадна таксиг ойлгоно гэсэн яг бүрэн тодорхой зохицуулалт байж байгаа.

Хоёрдугаарт нь зогсоолын асуудал мөн энэ түгжрэлийг бууруулах нэг гол үндсэн зохицуулалтуудын нэг.

Өнөөдрийн байдлаар НЗДТГ болон Нийслэлийн захирагчийн ажлын албан дээр Улаанбаатар хотын ерөнхий менежерээр ахлуулсан энэ зогсоолтой холбоотой цогц судалгаа хийж танилцуулах ажлын хэсэг гарсан. Ажлын хэсгийн судалгаа дүгнэлт бэлэн болсон. Үүнтэй холбоотойгоор авах арга хэмжээнийхээ төсөл хөтөлбөрүүдийг бэлдчихсэн байж байгаа. Энэ хүрээндээ энэ зогсоолтой холбоотой асуудлыг бол шийдвэрлээд явах боломжтой. Хотын төвд бол зогсоол 1 дүгээрт хүрэлцээ муутай байгаа.

Хоёрдугаарт өглөө ирээд автомашинаа тавиад орой авч явдаг ийм асуудлууд үүсдэг. Үүнээс ерөөсөө зогсоолын төлбөр өдөрт тодорхой хэмжээний төлбөрийн асуудал байна уу гэсэн судалгаан дээр энд дурдагдсан байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ бол шийдэгдээд явах явна аа.

Орон сууцжуулалтын асуудлыг та мөн асуулаа. Орон сууцжуулалт бол энэ гэр хорооллын агаар орчны бохирдлыг бууруулахад нэг том алхам гэж ингэж үзэж байгаа. Тэгэхдээ сүүлийн үед.

Д.Амарбаясгалан: Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн асуулт асууя.

П.Мөнхтулга: Өнөөдрөөс яг 3 сар 3 хоногийн өмнө буюу 4 сарын 3-ны өдөр хэвлэлийн мэдэгдэл хийж байсан. Тэр нь энэ Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай. Монгол Улсад нийт сая 100 мянган жолооч байдаг. Энэ жолооч нар бүгдээрээ албан журмаар даатгуулдаг. Даатгалынхаа нөхөн төлбөрийг авахын тулд маш олон шат дамжлагуудаар явдаг. Цагдаагийн тодорхойлолт, нөгөө үнэлүүлэх гээд. Энэнийхээ хойноос хөөцөлдөж явсаар байж байгаад 7 хоногийн ажлаа алдаад тэгээд 14 хоногоос сарын дотор нөхөн төлбөрөө авдаг ийм чирэгдэл үүсчихсэн яваад байдаг юм. Тэгээд энэ хуулийн хуулийн 16.6 дээр ингээд замын хөдөлгөөний дүрэмд заасан хоорондоо тохиролцож болдог энэ заалтыг хуулийн хийдлээр байхгүй болгочихсон байсан.

Тэгээд зарим нэг даатгалын компаниуд үүнийг ашиглаад цагдаагийн тодорхойлолтгүй бол даатгалын чинь нөхөн төлбөрийг өгөхгүй гээд ингээд дунд нь хийдэл үүсээд байдаг байсан юм аа. Энийг бол одоо энэ хуулиар дагаж орж ирж байгаа хууль дээр нэмэлт, өөрчлөлтөөр оруулж ирсэн байна. Энэ бол дэмжих ёстой зүйтэй заалт. Энэ нэг хэдэн статистик дурдахад ийм байдаг юм. Улаанбаатар хотод мөн хөдөө орон нутагт нийт гарч байгаа зам тээврийн ослын 40 хувь нь буюу нийт 28 мянган даатгалын тохиолдлууд жилдээ гардаг юм байна лээ. Тэрний 40 хувь нь араас мөргөх, эгнээ байр буруу эзэлсэн, маргах шаардлагагүй ийм тохиолдлууд байдаг. Энийг заавал цагдаагийн тодорхойлолт цагдаа ирнэ, нөгөө даатгалын шуурхай алба ирж баталгаажуулна гээд ингээд ерөөсөө.

Д.Амарбаясгалан: Нэг минут нэмж өгье. Мөнхтулга гишүүнд.

П.Мөнхтулга: Ингээд 38 минут цагдаа ирэхийг хүлээдэг, даатгалын шуурхай алба ирж баталгаажуулахыг хүлээдэг. Энэний ард гудамжаараа түгжирч 300, 400 машинууд ажлаа алдаж байдаг. Машин дотор яваа хүмүүс тэгэхээр энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулах нь зүйтэй. Тэгээд та бүхнээс асуухад энэ цахим аргаар шийднэ гэсэн ийм байдлаар оруулж ирж байгаа юм байна лээ. Энэ цахим аргаар шийдэх одоо энэ дэд бүтэц нь бий болсон уу? Энийг төр хийх юм уу, хувийн хэвшил л хийх юм уу гэсэн ийм асуулт байгаа.

Д.Амарбаясгалан: Үнэнбат хариулт өгье. 4 дүгээр индэр.

М.Үнэнбат: Мөнхтулга гишүүний асуултад хариулъя.

Жолоочийн даатгалын тухай хуульд орж байгаа өөрчлөлтийн гол зорилго бол тухайн осол гарсан тохиолдолд ямар нэгэн эрүүл мэнд, амь нас хохирсон гэдэг юм уу ийм асуудал байхгүй байх ёстой 2 дугаарт нь 2 жолооч бол хоорондоо ямар нэгэн маргаангүй байх ёстой. Энэ хүрээндээ хэрвээ аль нэг нь буруугаа хүлээгээд аль нэг нь буруугаа хүлээх ёстой. Тэгээд энэ тохиолдолд даатгалын маягт гэж гарч байгаа. Тэр маягтыг бөглөөд л тухайн даатгалынхаа компани руу илгээх ёстой. Тэр нь бол бүх даатгалын компанид өөрийн гэсэн цахим хуудастай байгаа. Тэр цахим хуудас руу илгээх тэр бааз руу бол шийдвэрлэнэ. СЗХ болон энэ хяналт тавих байгууллагууд яг тэрэн дээрээ даатгалын тэр тохиолдол гарсан асуудлыг тэр маягтыг хэрхэн шийдвэрлэх талаар бол шийдэх ёстой. Энэ бол төрийн байгууллагын хийх ажил байгаа.

Хоёрт нь жолооч маань хэрвээ маргаан гарсан тохиолдолд мэдээж даатгалын, цагдаа дуудах тэр зохицуулалт нь хэвээр байж байгаа. Таны өмнө хэвлэлийн хурал хийгээд энэ асуудлыг гаргаж тавьж байсантай бол яг л зарчмын хувьд яг адилхан тийм зохицуулалт орж ирж байгаа.

Д.Амарбаясгалан: Мөнхтулга гишүүн тодруулж асууя.

П.Мөнхтулга: Гол нь нөгөө энийг цахимжуулна гэдгээр ороод ирчихсэн байна лээ. Цахимжуулах нь зөв. Яг тухайн газар дээрээ 2 даатгалын нөхөн төлбөр авах гэж байгаа 2 этгээд бусдад хохирол учруулаагүй бол хоорондоо тэр үнэлгээгээ газар доор нь хийлгэх, тэр даатгалынхаа нөхөн төлбөрийг газар доор нь шийдүүлэх энэ цахим шийдлээ та нар боловсруулсан юм уу? Энэ цахим шийдлийг цааш нь төр ингээд нэг компани байгуулах ч гэдэг юм уу ямар нэгэн яаман дээрээ эсвэл агентлаг дээр авч явах юм уу. Энэ маш олон колл центр ажиллах сая 100 мянган жолооч нарын асуултад хариулах ийм том бүтэц явна. Энийг хувийн хэвшил хийх юм уу? Ямар зохион байгуулалт дэд бүтэц байгаа юм бэ гэсэн энэ асуултад хариулж байна.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгье.

М.Үнэнбат: Даатгалын тохиолдол илэрсэн тохиолдолд бол тухайн даатгалыг осол гаргасан 2 тээврийн хэрэгслийн жолооч нь баримтжуулаад тэрийгээ даатгал нь өөрсдийнхөө гэрээ хийсэн даатгалын компани руу илгээх л ёстой, мэйлээр нь байдаг юм уу эсвэл фэйс, цахим хаягаар нь байдаг юм уу тэгээд тэрнийг нь ирүүлсэн тохиолдолд тухайн даатгалын компани шалгаж үзнэ. Үнэхээрийн одоо тухайн гаргасан зөрчил нь ямар нэгэн эргэлзээ төрүүлсэн тохиолдолд тухайн тухайн ойр

орчмынх нь хяналтын камераар баталгаажуулах эрхийг мөн нээчихсэн байж байгаа. Тэгэхээр ингэж л явна гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Бадарчийн Хэрлэн гишүүн асуулт асууя.

Б.Хэрлэн: Тэгэхээр Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай энэ хуульд оруулж ирж байгаа нэмэлт, өөрчлөлт болон дагаж орж ирж байгаа 10 хуулийн хүрээнд асуух хэдэн зүйл байна аа.

Нэгдүгээрт нь одоо энэ газрыг дахин төлөвлөх Гэр хорооллын хөгжлийн сан гэдэг маань ямар статустгүйгээр үйл ажиллагаагаа явуулах юм бэ гэж асууя. Энэ Нийслэлийн орон сууцын корпорацын дэргэд үйл ажиллагаа явуулах юм уу эсвэл Засаг даргын шууд удирдлага доор үйл ажиллагаагаа явуулах юм уу эсвэл бие дааж үйл ажиллагаагаа явуулах юм уу гэдгийг тодруулж асууя.

Хоёрдугаарт нь энэ хуулийн төслийн 7^б дээр бичсэн байна л даа. Газрыг дахин төлөвлөх гэр хорооллын хөгжлийн сангийн тайлан зарцуулалт ил тод нээлттэй байх гэсэн ингэж томьёолж орж ирсэн байгаа юм. Тэгэхээр энийг энэ сангийн хөрөнгө бүрдүүлэлт зарцуулалтын талаарх энэ тайланг ямар хугацаанд жилдээ нэг удаа юу, 2 удаа гаргаж байх юм. Дээр нь энэ төрийн аудитад энэ аудит энд хийх үү, тэр тайлан дүгнэлтийг нь цахим хуудас шилэн дансанд байрлуулах уу гэх жишээтэйгээр нөгөө ил тод нээлттэй байдлыг хангах ямар ямар арга механизмуудыг энд хэрэглэх гэж байгаа вэ? Энэ дээр нөгөө Төрийн тусгай сангийн тухай хуульд заагдсан удирдлага санхүүжилтийн тухай зарчмууд яг энэ гэр хорооллын хөгжлийг дэмжих сан дээр үйлчлэх үү үгүй юу гэдгийг 2 дугаарт асуумаар байна.

Гуравдугаарт нь энэ дагаж орж ирсэн 10 хуулийн хүрээнд Улаанбаатар хотын захирагч буюу НЗД-ын эрх үүрэг нэлээн нэмэгдэж байгаа чиг үүргүүд хэд хэдэн чиг үүргээр нэмэгдэж байгаа. Ийм юм байгаад байна. Тухайлах юм бол одоо нөгөө авто тээврийн тухай хуульд болоод ирэхээр чинь нийслэлийн нутаг дэвсгэрт авто тээврийн хэрэгсэлд техникийн хяналт үзлэг хийх тухай ажлыг зохион байгуулах тэгээд авто тээврийн улсын бүртгэлийг хөтлөх тэгээд дээр нь цаашлах юм бол нөгөө авто тээврийн хяналт хийх, зөвшөөрөл олгох гээд энэ ажлууд бол хотын захирагчийн эрх мэдэлд орж ирж байгаа юм байна.

Түүнчлэн одоо тэр нийслэлийн Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиараа хууль тогтоомжийн хэрэгжилт стандартыг мөрдүүлэх тухай асуудлууд гэж орж ирж байна. Тэгэхээр энэ бүхэн бол нөгөө нэг танай хотын чинь нэг бүтэц зохион байгуулалтыг удирдлагыг нэмэгдүүлэх улмаар нөгөө төрийн албан хаагчийн чинь тоог нэмэгдүүлэх ийм үр нөлөө авчрах уу үгүй юу? Энэ дээр ер нь оролцоог хангаж энэ засаглалыг хэрэгжүүлэх тухай дээр та бодсон уу гэж би тодруулж асуумаар байна аа. Ялангуяа тухайлах юм бол тэр нөгөө авто тээврийн хяналтын тухай асуудал дээр чинь мэргэжлийн холбоодын байгууллага тиймээ хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог хангаж энэ үйл ажиллагааг явуулах ийм боломж бүрдэх үү үгүй юу? Энэ тал дээр та ямар бодолтой байна гэж асууя.

Нямбаатар дарга хариулт өгье.

Д.Амарбаясгалан: Нямбаатар дага хариулт өгье. 4 дүгээр индэр.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт энэ сан өөрөө бие даасан хэлбэрээр үйл ажиллагаа явуулна.

Хоёрдугаарт энэ төсвийн бүрдэл хэсэг учраас шилэн данс хөтлөгдөнө. Жил болгон тайлангаа ИТХ-даа тавина. Энэ санг яагаад яаран байгуулах гээд бид байгаа вэ гэхээр өнгөрсөн он жилүүдэд олон улсын хөгжлийн сангуудаас болон гаднын хөнгөлөлттэй зээл тусламжуудаар нэлээн олон орон сууцын хороолол барилгууд Улаанбаатар хотод баригдаад түрүүчээсээ дуусаж эхэлж байгаа. Тухайлах юм бол Баянхошуу, Шар хаданд 800 гаруй айлын орон сууц 97, 98 хувьтай явж байна. Солонго нэг хороолол баригдаж байна. Баянголын аманд мөн БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр 2008 айлын орон сууц баригдаж байна.

Энэ Баянбүрдийн орчим 1008 айлын орон сууцууд баригдаж байна. Эдгээр хөрөнгүүд ихэнх нь урт хугацаатай хөгжлийн зээл учраас эргэн төлөгдөх шаардлагатай. Тийм учраас эдгээрийг хэн нэг Засаг даргын захирамжаар иргэн, ТББ, ААН-үүдэд үнэ төлбөргүй өгөхөөсөө илүүтэй бид нар худалдан борлуулж нийслэлийн орон сууцын корпорац МИК-тэй хамтарч худалдан борлуулж борлуулсан орлогоор нь дэд бүтэц татсан гэр хорооллын газруудыг дахин чөлөөлөхөд зориулъя аа. Чөлөөлөгдсөн газруудаа эргээд барилгын компаниудад шилжүүлж өгье. Барилгын компаниуд нөгөө манайхаас авсан газар дээрээ барилга бариад эргээд барилгынхаа тодорхой хэсгийг газар чөлөөлөлтийн санд эргэж бүрдүүлдэг байдлаар ингэж эргэж нөхөгддөг байдлаар явуулъя гэж үзэж байгаа юм.

Нийслэл Улаанбаатар хот өнгөрсөн жил гарны хугацаанд 2 сан амжилттай ажиллуулж байгаа. Нэг нь нийтийн тээврийг хөгжүүлэх сан, огт ажилладаггүй байсан сан одоогийн байдлаар 40 гаран тэрбум төгрөгийн эргэлт хийчихсэн явж байгаа юм. Нөгөөх нь хот тохижилтын тоног төхөөрөмжийн сан байгуулсан. Өөрөөр хэлбэл нэг портерын ард хүрз давсаар цацдаг эрин үеийг бид нар халж энэ тоног төхөөрөмжүүдийг хувийн сектор орон нутгийн өмчит байгууллагуудад авч өгсөн. Эргэн төлөлтийг нь тухайн сан ингээд ашигтай ажиллаж байгаа гэдгийг хэлье. Таны дараагийн асуусан асуулт бол үзлэг оношилгоо улсын бүртгэл ингээд хотод ирчихсэн гээд. Энэ бүртгэл аль хэдийн ирчихсэн. Оношилгооны асуудлыг Зам тээврийн сайд хүсвэл оношилгооны тэр зөвшөөрөл олгох асуудлыг хотод шилжүүлж болно. Хүсэхгүй бол Зам тээврийн сайд дээрээ хэвээрээ үлдэнэ гэж байгаа. Хотын стандартын энэ чиг үүрэг хотод ирчихсэн. Ямар нэгэн орон тоо нэмэгдээгүй бид нар байсан хотын стандартын газрыг Хот байгуулалт, стандартын газар болгож, өөрчилж, хотын стандартыг мөрдүүлэх, хотын стандарт зөрчигдсөн тохиолдолд түүнийг таслан зогсоож мөрдүүлэх ийм чиг үүрэгтэй явж байгаа. Эдгээр хуулиуд батлагдсанаар Улаанбаатар хотод ямар нэгэн шинэ орон тоо нэмэгдэхгүй ээ.

Д.Амарбаясгалан: Хэрлэн гишүүн тодруулж асууя.

Б.Хэрлэн: Тэгэхээр ер нь бол яг энэ дагалдаж орж ирсэн 10 хуультай холбогдуулаад ингээд харахад бол таны чиг үүрэгт бол 4 зүйл, 4 шинэ чиг үүрэг орж ирэхээр байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол өөрөөр хэлэх юм бол эрх мэдлийн төвлөрөл бас нэлээн жаахан нэмэгдэх тал руугаа явах гээд байна уу гэж би хараад байгаа юм. Ер нь засаглалын үр өгөөж үр дүнг сайжруулъя гэх юм бол аль болохоор оролцогч талуудыг оролцуулах, идэвхтэй оролцоог бий болгох хэрэгтэй гэж үзээд байгаа. Тэгэхээр энэ мэргэжлийн холбоод, иргэд, хувийн хэвшлийнхний оролцоог ерөнхийдөө та яаж хангаж ажиллая гэж бодож байгаа юм бэ гэдгийг 1 дүгээрт бүүр сайн тодруулж хэлж өгөөч гэж.

Хоёрдугаарт нь би энэ дээрээ юу хэлэх гээд байна вэ гэхээр энэ нөгөө гэр хорооллын хөгжлийн сан гэдгийг нь нөгөө хуулийн 2 дугаар бүлэгт оруулчихсан байгаад байна л даа. Энийг 3 дугаар бүлэгт яг гэр хорооллыг дэмжих тухай өгүүлж байгаа тэр 3 дугаар бүлэгт нь оруулбал ер нь хэр зохистой вэ гэж би энэ дээр нэг хэлмээр байгаад байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол энэ авто зогсоолын тухай хэсэг дээр энэ гэр хорооллыг санал хэллээ.

Д.Амарбаясгалан: Ренчиндоржийн Батболд гишүүн асуулт асууя.

Р.Батболд: Гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Энэ хуулийн шинэчилсэн шинэчлэлээр бол ер нь нийслэл маань энэ хувийн хэвшилтэйгээ л өрсөлдөх юмыг нэг хуульд оруулаад явчхаад байна л гэж би хараад түрүүчийн хуралд хэлэлцүүлэг дээр асуугаад байсан юм. Энэ яагаад тэгж бодоод байна гэхээр энэ сангийн эх үүсвэр нь өөрөө чөлөөлсөн газар дээрээ орон сууц бариад тэрнийхээ худалдан борлуулсан орлогоос бүрдэнэ гэхээд байгаа юм.

Тэгэхээр ер нь бол хувийн хэвшилтэйгээ л өрсөлдөөд явна бид нар байшин бариад зарна л гэдгээ нэг хуульчлаад бүр ингээд баталгаажуулаад авчихлаа гэж бодоод байгаа юм аа. Энэ такси үйлчилгээн дээр ч гэсэн иймэрхүү юм гараад ирэх юм шиг байна аа. Тэгээд энэ удаа зүгээр асуух гээд байгаа юм нь би энэ цахимаар энэ автомашины хяналттай холбоотой зүйлийг нэг асуугаадахъя.

Энэ нэг хувь хүний өгөгдөл хамгаалах хууль ч билүү байдаг байх гэж бодоод байна. Тэгэхээр энэ цахим хяналтад орохоор энэ хувь хүний чинь энэ маршрут өглөө хэдэн цагт гардаг яадаг ийдэг, ийм юман дээр нэг асуудал үүсэх үү? Энэ дээр хувь хүнийг ер нь яаж хамгаалах юм. Тэгээд яг энэ тэр камерын бичлэг хийгээд байгаа газар маань өөрөө яг баталгаажсан тэр бичлэг энэ тэрээ ер нь яаж баталгаажуулах юм. Хэн нэг нь AI-аар ч юм уу ингээд дүрс бичлэг хийгээд хувь хүний нэр хүндэд халдаад тэнд явж байсан шүү дээ гээд ингээд гаргаад ирвэл тэрийгээ ер нь яаж хамгаалах юм бэ гэдэг талаар асууя. Энэ дээр ер нь бодсон юм байгаа юу? хариулт өгье 4 дүгээр индэр.

Х.Нямбаатар: 1 дүгээр асуултад хариулъя. Би яг таны бодож байгаагаас яг эсрэгээр бид нар бодлого хэрэгжүүлж байгаа гэдгийг л хэлэх гэсэн юм Батболд гишүүн ээ. Өөрөөр хэлбэл бид нар газар чөлөөлөлтийг нь төр хийж өгөөд хувийн секторын барилгын компаниуд тухайн барилгад газар дээрээ барилгаа бариарай. Бид нар энэ сангаараа газрыг чинь чөлөөлж өгье. Дэд бүтцийг чинь татаж өгье өө. Бид нар газар чөлөөлснийхөө төлбөрт таны барьсан барилгаас тодорхой хувийг одоо Нийслэлийн орон сууцын корпорацаар дамжуулан худалдан борлуулах замаар сангаа үргэлжлүүлж арвижуулж явъя л гэдэг л ийм зарчим барьж байгаа.

2 дахь асуултад хариулъя 2022 онд би тухайн үед ХЗДХ-ийн сайдаар ажиллаж байхад манай яамнаас Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль Нийтийн мэдээллийн тухай хууль гэдэг ийм багц хуулиудыг баталсан. Энэ багц хуулиар хувь хүний мэдээллийг хэрхэн хамгаалах вэ түүнийг хамгаалахтай холбоотой журмыг хэн батлах вэ гэдэг журмууд батлагдсан. Энэ хууль хяналтын байгууллага гагцхүү хэрэг хянан шийдвэрлэх зорилгоор уг камерын нэгдсэн системд нэвтэрч орно. Зөрчлийг баталгаажуулах эрх бүхий ажилтныг одоо бидний энэ өргөн бариад байгаа хуулийн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд ЭБАТ буюу эрх бүхий албан тушаалтан зөрчлийг тэр өдөрт гарсан зөрчлийг баталгаажуулж байгаагаар хуульчилсан. Хувийн зорилгоор

орсон тохиолдолд лог үүснэ. Үүссэн логийн дагуу хувь хүний мэдээлэлд халдсан гэдгээр нь Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Эрүүгийн хуульд заасны дагуу тухайн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэг тогтолцоог бид нар 2022 онд бүрдүүлсэн.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Дараачийн асуудал дээр 3 гишүүн асуулт асуугаад санал хураалт явагдахаар байгаа. Энэ хооронд түр 5 минут завсарлая.

15.28 цаг

Энэ хооронд гишүүдийг санал хураалтад бэлдье. Түр 5 минут завсарлаадахъя.

Дараачийн асуудал руу оръё. **Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд орох нэмэлт өөрчлөлтийн талаар 3 дугаар асуудал байгаа.**

Өглөө хэлэлцэж байгаа Даргын дэргэдэх зөвлөлийн хурлын дараа үргэлжлүүлэн хуралдъя гэж ингэж шийдсэн 3 хүн асуулт асууж дуусахаар асуухаар байгаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулахаар байгаа.

Тэгээд энэ дээр Дэгийн тухай хууль, Тогтвортой төсвийн тогтвортой байдлын тухай хууль зэрэг хуулиуд дээр зарим зүйл заалтууд нь тодорхой зөрчилтэй байж болзошгүй гээд Даргын дэргэдэх зөвлөл дээр энэ асуудлаар ярьсан.

Тэгээд Улсын Их Хурлын гишүүдийн ирц бүрдэж байж хурал явагдах ёстой гэсэн энэ асуудал нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиараа тодорхой шаардлага тавигдсан байсан. Тэгэхээр Тамгын газраас ирц бүрдсэн эсэх талаар мэдээлэл өгөх үү?

Ариунхур дарга 1 дүгээр микрофон.

Гишүүд ирцдээ дахиж бүртгүүлье. Энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль бүртгэлтэй биш шалтгаангүйгээр чөлөө болон эмнэлгийн чөлөө гадаад болон дотоод томилолт аваагүй гишүүд ирц нь заавал бүртгэлтэй байж байж энэ хуулийн төслийг хэлэлцэх шаардлагатай гэдэг хуулийн заалт байгаа учраас энэ дээр гишүүд ирцдээ бүртгэгдээдэхье? Баярлалаа.

Нэгдүгээр микрофон.

Ч.Ариунхур: Улсын Их Хурлын 126 гишүүнээс одоо ирцэд 10.9 гишүүн орсон байгаа 17 гишүүн өвчтэй, чөлөөтэй, дотоод болон гадаад томилолттой байгаа. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.20-д заасан шаардлагыг хангаж байгаа тул Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан шаардлага хангасан байна гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: Асуудлаа үргэлжлүүлэн хэлэлцье.

Жудгийн Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Энэ хуулийн 7 тиймээ өөрчлөгдчихөөд байгаа. 8.1.20-д зааснаас бусад тохиолдолд гээд. Энийг төсвийн тусгай шаардлага гэж үзэж байгаа юм байна аа. Тийм ч учраас энэ 8.1.20-д заасны дагуу бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдах ёстой гэж үзэж байгаа юм байна. Гэтэл нөгөө 6 сарын 25-нд яг энэ нөгөө 3 сар төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт хийж болохгүй гэдгийг болиулсан бас 2 заалт ороод батлагдчихсан явж байгаа.

Өөрөөр хэлбэл нөгөө тухайн харгалзах жилд төсвийн төсөл болон төсвийн тодотгол өргөн мэдүүлэхийг хориглоно гэдэг энэ заалт дээрээс нь 7.6 дээр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн түүнд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбоотойгоор 3 сарыг харгалзахгүйгээр өөрчлөлт оруулж болно гэсэн ийм 2 ноцтой заалт орчихсон явж байгаа.

Тэгэхээр энэ 2 заалт чинь яг энэ 7.7-г барьсан юм уу, өөрөөр хэлбэл бүтэц, бүрэлдэхүүн бүрэн байсан юм уу гэдэг асуудал яг одоо энэ дээр сөхөгдөөд гараад ирлээ. Тэгэхээр 1 ширхэг тасалсан хүн байх ёсгүй болж хувирч байна шүү дээ. Тэр чөлөө, гадаад дотоод томилолт тусдаа. Тэгэхээр энэ 6 сарын 25-нд энэ 2 заалтад өөрчлөлт оруулахдаа энэ 7.7-г үл харгалзаад шийдчихсэн болбоос энэ 7.5, 7.6-д орсон өөрчлөлт чинь хууль бус болох гэж байна аа.

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбоотойгоор хууль батлагдвал 3 сарыг үл тооно гэдэг нь өөрөө Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт гэдэг чинь ердөө 1 яамны нэг нэр өөрчлөгдөхөд л Засгийн газрын бүтэцэд өөрчлөлтөд орно гэсэн үг болох уу? Өөрөөр хэлбэл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг хөдөлмөрийг нь авахад л, жишээлбэл, бүхэлдээ өөрчлөлт ороод нөгөө 3 сарыг барихгүй ийм нөхцөл байдал үүсэх үү гэдгийг асуумаар байна. Тэгээд одоо уг нь хөөрхөн хавар энэ 6 сарын 30-нд манай Гантөмөр дарга юу яасан байгаа юм л даа.

Дандаа алдагдалгүй төсөв батлуулахаар 2026, 2027 оны энэ төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж өгсөн байгаа юм. Гэтэл харамсалтай нь энэ орж ирж байгаа шинэ 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлд дандаа алдагдалтай байхаар болчихлоо.

Гэтэл би сая эндээс шүүлгэж үзсэн чинь 2020 оноос хойш 2016, 2017 оноос хойш бол ерөөсөө манай жилийн төсвүүд дандаа алдагдалтай батлагдаж ирсэн жил болгон 2023 онд нэг алдагдалгүй нэмэхдээ гарсан эсэх нь тодорхойгүй байна. Тэгэхээр сүүлийн 4, 5 жил гэхэд л нөгөө 120 их наяд төгрөг бид бид нар зарцуулсан гээд байгаа. Тэгээд 1 ширхэг цахилгаан станц баригдав уу? Нэг ширхэг Монгол Улсад хэрэгтэй том мега төсөл хөдлөв үү. Би өнгөрсөн хугацаанд ярьж байна шүү дээ. Энэ шинэ парламент бүрэлдсэнээс хойшхыг яриагүй байна.

Тэгэхээр энэ төсөв төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн гүйцэтгэл, эргээд Монгол Улсад орж байгаа хөгжил дэвшил чинь ерөөсөө уялдаатай хөгжил дэвшлийг л санхүүжүүлэх зорилготой байдаг биз дээ энэ төсөв чинь. Гэтэл энэ их олон наядыг ингээд зарцуулаад байдаг, зарцуулаад байдаг орлого нь асар ихээр ороод байдаг тэгсэн мөртөө үр дүн байхгүй. Үгүй нэг ч цахилгаан станцгүй л сууж байна шүү дээ

бид нар. Хүний гар хараад л 100 хувь хараад. Тэгээд яг энэ чигээрээ энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульдаа энэ мэтээр бараг сар тутам өөрчлөлт хийгээд байна гэдэг чинь цаадах тэр үр дагавар нь юун дээр тусах вэ гэвэл нөгөө л төсвийн сахилга бат, нөгөө л төсвийн хариуцлагагүй байдал чинь л нэмэгдээд байх юм аа. Энэ хуулийг харахаар ерөөсөө ингээд л 2023 оны 5 сар, 2024 оны 6 сар, 2024 оны одоо ингээд 7 сар гээд ингээд өөрчлөлт орох нь л дээ. Тэгээд би хэлээд байгаа шүү дээ. Эс бөгөөс энэ хуулийнхаа нэрийг соль. Төсвийн тогтворгүй байдлын тухай хууль болго. Зөвхөн.

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Ямар ч реформ шинэчлэл төсвийн бодлоготойгоо уяж явах ёстой. Тэгээд шинэчлэл реформууд нь өөрөө төсвийн бодлоготойгоо уяж явахгүйгээсээ болоод бид нэг ийм байдалд хүрлээ л дээ. Тэгэхээр төсвийн тогтвортой байдлын энэ хууль хэрэгжиж эхлээд төсвийн хүрээ болоод ирэх оны төсвийн төсөөллийг өргөн мэдүүлэхэд энэ тусгай шаардлагуудыг барих ийм эрх зүйн шаардлагатай болсон нь бол хамгийн том дэвшил юм.

Тэгэхээр зүгээр Баярмаа гишүүний асуултад хариулахад бол энэ төсвийн бодлого дээрээ бид нар би түрүүн хэлсэн энэ эдийн засгийн агшилтын үед тэлэх халалтын үедээ хумих ийм мөчлөг сөрсөн бодлого л авч хэрэгжүүлэх ёстой. Тэрнээс биш төсвийн тэнцэл алдагдалтай байх эсэх бол үл хамаараад төсвийн бодлого чинь өөрөө үнэхээр ийм эдийн засаг агшиж байна гэвэл тэр тэлэх бодлогыг явуулж байж нөгөө хувийн хэвшил дэмжих, баялаг бүтээгчдээ дэмжих дүрэм журам, саад тээгүүдийг арилгах, нөгөө хувийн хэвшлийн ажлын байруудыг хадгалж авч үлдэх зарчим руугаа хазайхгүй бол зүгээр бүхэлд нь ингээд нэг хэмнээд эсвэл зүгээр ингээд алдагдлыг алдагдалтай батлах нь чухал байна. Чухал биш байна гэдэг дээр тойрч яриад бол үр дүнд хүрэхгүй.

Зүгээр үйлдвэрлэлийн зөрөө буюу 2025 оны эхний улирлын байдлаар -0.6 хувь буюу эдийн засгийн нийт үйлдвэрлэл потенциал түвшнээсээ 0.6 хувиар бага түвшинд бол ийм байгаа. Тэгэхээр үүнд бол мэдээж зэсээс бусад металл буюу хүдэр болон нүүрс олборлох үйл ажиллагаа саарсан уул уурхай тээврийн салбарын нийт үйлдвэрлэл потенциал түвшнээсээ нэг 0.7 нэгж хувиар доогуур гарсан нь бол нөлөөлсөн гэж ингэж бол хэлж болно.

Тэгэхээр бид төсвийн тэнцлийг тодорхой алдагдалтайгаар баталснаараа эдийн засгийн агшилтын үед тэлэх бодлого бариад энэ нь дунд хугацаандаа үйлдвэрлэлийн зөрөө эерэг болгох хүлээлттэй байгаа гэж тооцвол нэгдсэн төсвийн зарлагын хэмжээг дунд хугацаанд давхар бууруулаад алдагдлыг хумьснаар мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг үе шаттай хэрэгжүүлэх ийм боломж бол байна л гэж ингэж харж байгаа юм.

Тийм учраас бид өнгөрсөн 12 сард баталсан тэр төсвийн хүрээгээрээ өнөөдөр төсвийг төлөвлөө гэхээр 5 дугаар сарын 30-ны чинь төсвийн хүрээнд энэ тоонууд нь хоорондоо уялдахгүй байсан учраас Засгийн газрын бүтцийн хуулийг дагуулаад энэ оны төсвийн хүрээг ч тэр ирэх оны төсвийн хүрээг ч тэр тоог нь уялдуулаад барьсан боловч Их Хурлаас мэдээж Их Хурал онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд хуулийг төсөл санаачлагчид нь буцаачихсан.

Тэгэхээр .9 дүгээр сарын 1-нд нөгөө хуулиараа Төсвийн тогтвортой байдлын хуулиараа ирэх оны төсөв барих гээд байгаа учраас үүнийг тоонуудыг нь уялдуулахгүй бол алдагдалгүй төсөв барина гээд бүрдэхгүй орлого 33.5 их наядаар бүрдүүлээд бол.

Д.Амарбаясгалан: Учрал сайд гүйцээж хариулъя.

Тэгэхээр 33.5 их наядын орлого орно. Төдий хэмжээгээрээ зарлагадна гээд ийм төсөв ирэх онд оруулж ирнэ гэх боломж байхгүй л дээ. Ер нь 13-аас 30 нүүрс чинь угаасаа буух хандлага тэр 14 байгууллагын үзүүлэлтээс харагдчихлаа. Эдийн засгийн өсөлт ч гэсэн ер нь ч тэр Дэлхийн банк ч тэр ер нь 6.3, 6.6 хувьтай буурна гээд ингээд төсөөлөл гаргаад өгчихсөн.

Монгол банк ч гэсэн бид нарт өчигдөр 5.9 хувь гээд ийм тоо өгчихсөн байхад бид хэт их өөдрөгөөр төсвөө бололцоогүй тэгээд ер нь олсныхоо хэрээр зардаг энэ байдалд чинь л өнөөдөр ийм байдалд хүрсэн байхгүй юу. Нүүрс өндөр үнэтэй байх үед бид нар хэрвээ хумих бодлого хэрэгжүүлсэн бол хуримтлал үүсгэсэн бол өнөөдөр ийм байдалд орохгүй л байсан.

Тэгэхээр ирэх онд төсвийг төлөвлөхдөө үнэнээр нь бодит нөхцөл байдалтайгаа нийцүүлээд ингээд төлөвлөөд явна л гэдгийг хэлье ээ.

Д.Амарбаясгалан: Баярмаа гишүүн тодруулж асууя.

Ж.Баярмаа: Байна уу? Үгүй харин тиймээ. Тийм байж ирсэн байна. Мөчлөг дагасан байна мөчлөг сөрөх ёстой байсан байна гээд байх юм. Үгүй энэ чинь одоо сүүлийн 8 жил Ардын нам засаглаж байгаа шүү дээ. Тэгээд яагаад энэ 8 жил энэ мөчлөгөө дагаач та минь ээ, биш мөчлөгөө сөрөөч мөчлөг сөрсөн бодлого яваач гээд энэ Төсвийн тогтвортой байдлын байдлын зөвлөл хөөрхий тийм бичиг болгон дээрээ бичсэн байна лээ шүү дээ. Тэгээд яагаад өнөөдрийг хүртэл тэрийгээ барихгүй дээрээс нь жил болгоныхоо төсвийг алдагдалтай батлаад тэгээд хийсэн үр дүн гэвэл нэг цахилгаан станцгүй сууж байгаа юм бэ л гээд байгаа шүү дээ. Түүнээс биш би тантай санал нэг байна. Би түрүүн ч гэсэн хэлж байсан төсвийг нэг алдагдалгүй батлах гээд байгаадаа биш. Хэрвээ үнэхээр ийм хэрэгтэй Монгол Улсад хэрэгтэй төсөв төсөл арга хэмжээ байгаад тэрэнд нь мөнгө дутаад байх аваас зээлээ ав, ашигла, алдагдалтай гарга. Үгүй тэгээд харамсалтай нь тэгэхгүй байгаад байгаа байхгүй юу. Өнөөдрийг хүртэл сүүлийн 6, 7 жилийн дүнг авч үзэхэд дандаа алдагдалтай мөртөө таны хэлээд байгаа шиг тэр үр дүн.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүн хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Баярмаа гишүүний асуусан зарим асуултад нь хариулт өгье.

Энэ одоогийн орж ирж байгаа асуудал маань бол нөгөө тусгай шаардлагад өөрчлөлт орж байгаа биш тусгай шаардлага хэрэгжих нөхцөлд өөрчлөлт орчихоод байгаа байхгүй юу. Нөгөө төсвийн хүрээний бүртгэл батлагдсанаас хойш 3 сарын дотор гэдэгт өөрчлөлт ороод байна шүү дээ. Энэ нөгөө тусгай шаардлага хэрэгжих нөхцөл. Тийм учраас бид нар бол яг энийг тэгээд энэ тогтвортой байдлын хуульд байгаа шаардлагыг бүрдүүлж байж ирцээ бүрдүүлж байж энэ асуудлыг шийдэхээс өөр аргагүй. Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орвол яах вэ гэж байна тэ.

Нэр өөрчлөгдөж байгаа учраас заавал төсвийн тодотгол хийнэ. Угаасаа нөгөө 3 шаардлагын нэгж нь байхгүй юу. Нэр нь өөрчлөгдчих юм бол тэр төсвийн ерөнхийлөн захирагчийн өөрчлөгдсөн төсөв ашиглах боломжгүй болчхож байгаа юм.

Тийм учраас төсвийн хуульд заавал өөрчлөлт ороод явдаг. Өмнө тэр Засгийн газар.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн гишүүний нэг минут нэмье.

Ц.Даваасүрэн: Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орсон бол энэ заалт хамаарахгүй гээд байсан нь бол яг энэ ирцийн шаардлага хангах шаар шаардлагатай байсан гэсэн үг. Тэгэхээр ямар эрчтэй байсныг би мэдэхгүй байна. Тэгэхээр энэ бол Тамгын газар хариулах байх гэж ингэж бодогдож байна. Тэр ер нь зүгээр одоо бид нар төсвийг нэг өдөр алдагдалтай алдагдалгүй байх ёстой гээд л хэдхэн сарын өмнө тэгцгээгээд л тиймээ ер нь хэмнэлттэй байх, алдагдалгүй байх ёстой гээд. Тэгсэн хэдхэн сарын дараа нөгөө нөхөр маань төсөв алдагдалтай байх ёстой эдийн засаг тэлэх ёстой гээд ингээд солиороод унаж байгаа байхгүй юу. Энэ болохгүй шүү дээ. Ийм байр суурьгүй байж болохгүй байхгүй юу. Хэдхэн сарын дараа нөгөө ярьж байсан юмаа өөрсдөө дайраад унаж байгаа байхгүй юу. Алдагдалгүй байна гэхээр зүгээр алга ташаад л алдагдалгүй байх ёстой гээд л ингэж ингэж ярьж байснаа 6 сарын дараа өө эдийн засагт хэлэх ёстойИ Хурлын гишүүд ер нь.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Золжаргал гишүүн байхгүй байгаа учраас ингээд дууслаа.

Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалтад бэлдье. Саналын томъёолол танилцуулъя.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулан танхимд 80 гишүүн байна.

Санал хураалт

59 гишүүн буюу 54.1 хувиар хэлэлцэхийг дэмжье гэсэн санал дэмжигдлээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Сайнзориг гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Дараачийн асуудлын санал хураалт.

Нийтийн өмчийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн санал хураалт байгаа. Нийт 45 орчим санал хураалт байна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан байгаа.

Гишүүд санал хураалтад бэлдье.

Санал хураалт.

Саналын томъёолол танилцуулъя нэг.

Нийтийн өмчийн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

59 гишүүн буюу 54.1 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Нийтийн өмчийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа. 63 гишүүн буюу 57.8 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

64 гишүүн буюу 58.7 хувиар санал дэмжигдлээ

4.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

59 гишүүн буюу 54.1 хувиар дэмжигдлээ

5.Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

61 гишүүн буюу 56 хувиар санал дэмжигдлээ.

6.Гадаадын иргэн иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

66 гишүүн буюу 60.6 хувиар санал дэмжигдлээ

7.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

64 гишүүн буюу 58.7 хувиар санал дэмжигдлээ.

8.Генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

63 гишүүн буюу 57.8 хувиар санал дэмжигдлээ.

9.Геодези зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

60 гишүүн буюу 55 хувиар санал дэмжигдлээ.

10.Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

62 гишүүн буюу 56.9 хувиар санал дэмжигдлээ.

11.ЕБС-ийн Хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

68 гишүүн буюу 62.4 хувиар санал дэмжигдлээ.

12.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

62 гишүүн буюу 56.9 хувиар санал дэмжигдлээ.

13.ЖДҮ Үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

63 гишүүн буюу 57.8 хувиар санал дэмжигдлээ.

14.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

65 гишүүн буюу 59.6 хувиар санал дэмжигдлээ.

15.Кибер аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

66 гишүүн буюу 60.6 хувиар санал дэмжигдлээ.

16.Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

63 гишүүн буюу 57.8 хувиар санал дэмжигдлээ.

17.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

66 гишүүн буюу 60.6 хувиар санал дэмжигдлээ.

18.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

64 гишүүн буюу 58.7 хувиар санал дэмжигдлээ.

19.Музейн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

59 гишүүн буюу 54.1 хувиар санал дэмжигдлээ

20.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

63 гишүүн буюу 57.8 хувиар санал дэмжигдлээ

21.Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

62 гишүүн буюу 56.9 хувиар санал дэмжигдлээ.

22.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

61 гишүүн буюу 56 хувиар санал дэмжигдлээ

23.Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

60 гишүүн буюу 55 хувиар санал дэмжигдлээ.

24.Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

60 гишүүн буюу 55 хувиар санал дэмжигдлээ

25.Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 63 гишүүн буюу 57.8 хувиар санал дэмжигдлээ

26.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

62 гишүүн буюу 56.9 хувиар санал дэмжигдлээ

27.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

60 гишүүн буюу 55 хувиар санал дэмжигдлээ

28.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

59 гишүүн буюу 54.1 хувиар санал дэмжигдлээ.

29.Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

64 гишүүн буюу 58.7 хувиар санал дэмжигдлээ.

30.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

31.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

66 гишүүн буюу 60.6 хувиар санал дэмжигдлээ

32.Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

63 гишүүн буюу 57.8 хувиар дэмжигдлээ

33.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

60 гишүүн буюу 55 хувиар санал дэмжигдлээ

34.Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

61 гишүүн буюу 56 хувиар санал дэмжигдлээ

35.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

64 гишүүн буюу 58.7 хувиар санал дэмжигдлээ

36.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

63 гишүүн буюу 57.8 хувиар санал дэмжигдлээ

37.Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

63 гишүүн буюу 57.8 хувиар санал дэмжигдлээ

38.Шинжлэх ухаан технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

63 гишүүн буюу 57.8 хувиар санал дэмжигдлээ.

39.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

65 гишүүн буюу 59.6 хувиар санал дэмжигдлээ

40.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

66 гишүүн буюу 60.6 хувиар санал дэмжигдлээ

41.Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

42.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

63 гишүүн буюу 57.8 хувиар санал дэмжигдлээ

43.“Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

64 гишүүн буюу 58.7 хувиар санал дэмжигдлээ

44.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэ бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

62 гишүүн буюу 56.9 хувийн санал дэмжигдлээ.

Нийтийн өмчийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон ХЗБХ-нд шилжүүллээ.

Дараачийн асуудлын санал хураалт.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа.

Байнгын хорооны саналаар Замын хөдөлгөөний аюулгүй байлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье.

Санал хураалт.

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт

73 гишүүн буюу 67 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

72 гишүүн буюу 66.1 хувиар санал дэмжигдлээ

3.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

70 гишүүн буюу 64.2 хувиар санал дэмжигдлээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухайд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүллээ.

Дараагийн асуудалд оръё.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгасан санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “бүсэд” гэсний дараа “нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц барилга байгууламжаас бусад” гэснийг “бүсэд” гэсний дараа “Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8-д заасан зааснаас бусад” гэж өөрчлөх.

Санал гаргасан ТББХ.

Санал хураалт.

66 гишүүн буюу 60.6 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар ТББХ-нд шилжүүлээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэлэлцэх эсэх асуудал чуулганаар шийдэгдсэн учраас Төсвийн байнгын хороо хуралдаж дараачийн хэлэлцүүлгийг хийнэ.

Улсын Их Хурлын чуулган үргэлжилж дараагийн асуудлыг хэлэлцэж эхэлнэ ээ.

Дараагийн асуудалд оръё.

“Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний талаарх 24 дэх илтгэл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаар ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ухнаагийн Отгонбаяр танилцуулна.

Индэрт урьж байна

У.Отгонбаяр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ХЭҮК-оос 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг Улсын Их Хурлын 2025 оны 5 сарын 1-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хуралдаан даргалагчаас ХЭҮК-оос дэвшүүлсэн 6 бүлэг саналыг Байнгын хороодоор хэлэлцүүлж холбогдох тогтоол шийдвэрийг боловсруулж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж хэлэлцүүлэхийг Улсын Их Хурлын ХЗБХ-нд үүрэг болгосны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо, Инновац цахим бодлогын байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо, Ёс зүй, дэнгийн байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд уг илтгэлийг хэлэлцэж холбогдох санал дүгнэлтээ ХЗБХ-нд ирүүлсэн.

ХЗБХ 2025 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Энхбаяраар ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг, Сайнзориг, Тэмүүжин, Уянгахишиг нарын бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж бусад Байнгын хороодоос ирүүлсэн санал, дүгнэлтийг нэгтгэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулсныг ХЗБХ-ны 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар шүүхийн ил тод байдлын чиглэлээр гаргасан зөвлөмжүүд шат шатдаа хэрхэн хэрэгжиж байгаа талаар, ХЭҮК-оос гаргасан тодорхой зөвлөмжүүдээс хэрэгжээгүй, анхааралд өртөөгүй байгаа асуудал байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг Сонгуулийн санхүүжилтийн ил тод байдал, зардлыг бууруулах, тэгш өрсөлдөөнийг хангах зорилгоор гаргасан зөвлөмж болон цэцийн дүгнэлтүүдийг хэрэгжүүлэх, мөн тойргийн сонгогчдын тооны харьцааг тэнцвэржүүлэх зэрэг асуудлуудад улс төрийн намууд манлайлан Улсын Их Хурлын түвшинд шийдвэрлэх нь зохимжтой бөгөөд эдгээр асуудлуудыг Засгийн газарт даалгах нь хэр зохистой талаар, Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал тогтоолын төсөл дэх бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах талаарх асуудлыг гэр бүл хүүхдийн шүүх байгуулахтай холбогдуулан уялдаа холбоог хангаж салбар дундын зохицуулалтыг тогтоолд тусгах тодорхой чиг үүргээр даалгах боломжтой эсэх талаар тус тус асуулт асууж хариулт авсан болно.

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2024 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх хууль ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Сүнжид ХЭҮК-ын дарга, Батзэвэгийн Энхболд ХЭҮК-ын гишүүн, Жаргалсайханы Хунан ХЭҮК-ын гишүүн, Ядамжавын Цэлмүүн ХЭҮК-ын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүн, Шагдарын Үнэнтөгс ХЭҮК-ын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

2 гишүүн нэр ирлээ. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя. Үг хэлье.

Х.Баасанжаргал: Үг асуулт хамтдаа дэг байгаа ХЭҮК-ынхноос нэг асуулт асууя. Өмнөх жилүүдийн хэрэгжилтийн тайлан ер нь хэдэн хувьтай явдаг вэ. Тэгээд хэрэгжилт ер нь би хангалтгүй гэж ойлгодог. Хангалтгүй байгаа үндсэн шалтгааныг та хэд маань комиссын зүгээс юу гэж хардаг вэ? Цаашид илүү яг энэ хэрэгжилтийг хангах механизм тал дээр ямар санал байдаг вэ гэдэг ийм 3 асуулт асууя. Ажлын хэсэг Энхбаяр гишүүнээс нэг асуулт асууя.

Бид нар яах вэ ер нь бол манай энэ удаагийн тогтоол жаахан Ерөнхий л гарчихлаа гэж хараад байна. Тэгээд бид нар дараа жил хойтон жил дахиад хэрэгжилтийг нь үнэлнэ, дүгнэнэ. Хэрэгжилт хангалттай хангалтгүй хаанаа асуудал гараад байна гээд ингээд хэрэгжилтийг нь дүгнэнэ. Тэгэхээр ер нь бид нар энэ механизм цаашид энэ тогтоолыг тогтоолыг сайжруулах, тогтоолын хэрэгжилтийг хангах тал дээр бид нар ингээд тогтоол гаргаад орхиод энэний мөрөөр ямар арга хэмжээ авах ёстой гэж харж байгаа вэ? Ажлын хэсгийн ахлагчийн хувьд нэг ийм 2 асуулт.

Сүнжид дарга хариулт өгье. 3 дугаар индэр.

Д.Сүнжид: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Өмнөх тогтоолуудын хэрэгжилтийг дүгнэж үзсэн. 19, 20 дахь тогтоолын хэрэгжилт 71 хувьтай, 21 дэх тогт ил тогтоолын илтгэлийн мөрөөр гарсан 49 дүгээр тогтоолын хэрэгжилт нь 62. 22 дахь илтгэлийн мөрөөр гарсан 35 дугаар тогтоолын хэрэгжилт 60 хувьтай, 23 дахь илтгэлийн мөрөөр гарсан 37 дугаар тогтоол хэрэгжилт 51 хувьтай гээд. Тэгээд хэд хэдэн шалтгаан байгаа.

Нэгдүгээрт нь хууль тогтоох хууль, эрх зүйн шинэчлэлийг хийх ёстой зохицуулалтыг хийх ёстой гэдэг зарим заалтууд хэрэгжээгүй. Жишээлбэл Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль иргэний оролцоог зохицуулсан ТББ-ын тухай хууль, мөн эрүүдэн шүүх гэмт хэргийг мөрдөн шалгах ийм нэгжийг байгуулах ёстой гэдэг ийм тогтоол энэ заалтууд жишээ нь хэрэгжээгүй явж байгаа юм.

Хоёр дахь хэсэг нь энэ уялдаа холбоо зохион байгуулалттай холбоотой асуудлууд явдаг аа. Өөрөөр хэлэх юм бол байгууллага институт хоорондын чиг үүргийн дунд хаягддаг уялдуулагддаггүй, зохицуулагдахгүй үлдсэнээс болоод хэрэгжилт хангалттай биш асуудал байна.

Гурав дахь том шалтгаан бол төсөвтэй холбоотой байна аа. Үе шаттай хэрэгжүүлдэг асуудлууд байдаг. Жишээлэх юм бол дотуур байрыг шинэчлэх үе шаттай шинэчлэх ийм асуудлууд орж ирдэг. Төсөв хөрөнгө оруулалттай холбоотой энэ дээр тодорхой төсөв хөрөнгө оруулалт шийдэгдэхгүй бол энэ Их Хурлын тогтоол хэрэгжихгүй байх нэг үндэслэл болдоггүй. Ийм 3 шалтгааныг хэлье.

Тэгэхээр цаашдаа бол энэ тогтоолын хэрэгжилт дээр нэг энэ нөхцөл байдал хүчин зүйлүүдийг заавал харгалзаж байж бид нар үр дүнтэй гүйцэтгэл ийм шаардах ёстой байгаад байгаа юм аа.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж үг хэлье. Энхбаяр гишүүн хариулт өгье.

Б.Энхбаяр: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя аа.

Үнэхээр энэ ХЭҮК-ыг байгуулснаас хойш Улсын Их Хурал дээр жил болгон нэг тайлан илтгэл хэлбэрийн төдий сонссон болоод ингээд явдаг байсан. Энэ явдаг байсан гэж ярьж байгаа нь түүх болсон.

2 жилийн өмнөөс Улсын Их Хурал дээр ХЭҮК-ын тайланг 1 дүгээрт сэдэвчилж хэлэлцдэг болсон. ХЭҮК-ын тайлан ч гэсэн нэлээн ажил хэрэгч тодорхой кэйсүүдтэй мөн санал зөвлөмжтэй шийдэлтэйгээр Улсын Их Хуралд танилцуулагддаг болсон.

2 жилийн өмнө Хүний эрхийн Комиссыг анх удаа 2 өдөр, 4 сэдвээр сонсгол, хагас сонсгол хэлбэрээр зохион байгуулж байсан. Ингээд 2 жилийн өмнөөс эхлээд Улсын Их Хурал энэ комиссын.

Д.Амарбаясгалан: Энхбаяр гишүүн гүйцээж хариулъя.

Б.Энхбаяр: Хүний эрхийн Комиссын тайлан илтгэлийг ийм сэдэвчилж сонсгол хэлбэрээр авч үзээд тэнд хөндөгдсөн асуудлуудыг шуурхай шийдэх хүрээнд тогтоол гаргаж Засгийн газар холбогдох байгууллагад чиглэл зөвлөмж өгдөг болсон.

Энэний үр дүнд ч гэсэн бид нар сая 2 7 хоногийн өмнө ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулаад энэ эрүүдэн шүүхийн эсрэг ялангуяа энэ өмгөөлөгчийн эрх зүйн статусыг дээшлүүлэх чиглэлээр Их Хурал тогтоол гаргаж байсныг хэрэгжүүлээд хууль болгоод гаргасан.

Одоо бид нар мөн 7 хуудас тогтоол гаргах гэж байгаа юм 5 сэдвийн хүрээнд. Энэнийхээ хэрэгжилтийг одоо хянаж хангаж ажиллах бол Их Хурлын гишүүн ард түмний төлөөлөгч хүн нэг бүрээс хамаарна. Энэ нь нэг хүнээс хамаарахгүй. Ялангуяа ХЗБХ, Хүний эрхийн дэд хороо араас нь нэлээн сайн шахаж шаардаж ажиллах ёстой болох байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн тодруулж асууя.

Х.Баасанжаргал: Яах вэ тодруулаад энэ нөгөө тогтоолын 7 дугаар хэсгийн г дээр Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөрийг протоколд нийцүүлэн боловсруулах гээд энийг болохоор нөгөө эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх

асуудлаар гээд энэ хэсэг дээр тавьчихсан байна. Энийг чинь бол нөгөө ХЭҮК-ын өөрийнх нь бүрэн эрхийн асуудал байгаад байгаа. Тэгэхээр энийг энэ хэсгээс редакцын санал гэх юм уу юу гэх юм? Энийг нэг юун дээр тавихгүй бол яг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар гэдэг хэсэгт орж байгаа нь өөрөө энэ дээр бол буруу болох гээд байна.

Хоёрдугаарт гэвэл бас нэг энэ нөгөө даалгаж байгаа субъектүүд байгаа. Монгол Улсын СЕХ болон Засгийн газар гээд. Энэ нөгөө хүүхэд гэр бүлийн шүүх байгуулагдах гэж байгаатай холбоотой салбар дундын уялдааг хангах маш чухал ажил бид нарын өмнө байгаа. Тэгээд энэ бол зөвхөн Засгийн газраас гадна Улсын дээд шүүх, ШЕЗ гээд ингээд салбар дундын маш хариуцлагатай уялдааг хангах ийм ажил байгаад байгаа. Тэгээд энийг нөгөө хариуцах этгээд дээр нь давхар нэмэх гэсэн ийм саналтай байна.

Д.Амарбаясгалан: Санал хэллээ.

Улсын Их Хурлын Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд асуулт асууж үг хэлье.

С.Эрдэнэболд: Сая Энхбаяр гишүүний хэлсэнчлэн бас яах вэ нэр төдий илтгэл танилцуулаад өнгөрдөг биш нэлээн ийм ажил хэрэгч байгаа гэж ХЭҮК хичээж ажиллаж байгаа гэдэгтэй би санал нэгдэж байгаа.

Яах вэ Ерөнхий мэдээлэл авахад бид нар ингээд Хүний эрхийн үндэсний 2 дугаар хөтөлбөр намрын чуулганаар орох байх. Парламент өөрөө Хүн төвт стратеги гээд ноднин 11 сард баталсан ингээд явж байгаа. Шулуухан хэлэхэд бол тэр стратегийн 5 шалгуураа Их Хурлаар баталж байгаа. Их Хуралд оруулж ирж байгаа энэ хууль тогтоолууд тэр болгон шалгуур үзүүлэлт болохгүй байгаа. Ийм зүй тогтол ажиглагдаад байгаа. Энэ дээрээ бид нар анхаарах ёстой юм байна.

Асуулт нь болохлоороо энэ тогтоол маань 7 бүлэг нэгд нь сонгох сонгогдох эрхийн талаар.

Хоёрт нь хүний эрхийг хамгаалагч.

Гуравт нь хүний эрх ба цахим технологи.

Дөрөвт нь цахим орчинд үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийллээс хамгаалах.

Тавд бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах.

Зургаад нь шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтийн талаар.

Долоод нь болохлоор эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх талаар гээд энэ 7 зүйлтэй байгаа. Тэгэхээр ХЭҮК-оос асуух гэж байгаа нь ер нь ингээд үндэсний 2 дугаар хөтөлбөр 282 орчим зүйл заалттайгаар төсөл орж ирж байгаа. Энэ 7 зүйл заалтад бол ер нь энэ зохицуулалтын шинж чанартай зүйлүүд ер нь бүрэн хамрагдаж орж чадсан уу? Энэ дээр тухайлбал боловсрол ба хүний эрхийн холбоотой асуудал эрүүл мэнд ба хүний эрхийн холбоотой асуудлууд орох байсан уу? Ер нь орохгүй байх нь зөв байсан юм уу? Сая жишээлбэл утааны сонсгол энэ

оны 2 сарын 3, 4-нд боллоо. 4 ийм дэд хэлэлцүүлэг болсон. Энэ дээр жишээлбэл яг эрүүл мэнд ба хүний эрхтэй холбоотой бие даасан хэлэлцүүлэг явагдсан байгаа.

Улирлын чанартай асуудал биш энэ хүний заяамал эрх амьд явах эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэнд заналхийлээд байна гэдэг тэр төрийн бодлогын шийдвэр гаргалт болгон салбар салбарт явагдахдаа нэг цэг дээр төвлөрч тэр хэмжүүр нь өөрөө Монгол хүний эрх, эрх чөлөө түүнийг хамгаалсан мэдрэмжтэй байх гэдэг агуулга яваад байгаа.

Тэр энэ дээр жишээлбэл ер нь энэ орох ёстой байсан уу, орох ёсгүй байсан уу? Одоогийн энэ ингээд тогтоол ингээд яг энэ хүрээндээ гарчихад бол хангалттай гэж үзэж байгаа юм уу? 1 дүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт нь ер нь цаашлаад байгаа хуулийн хууль, эрх зүйн тогтолцоонд мэдээж үндэсний 2 дугаар хөтөлбөрөөс гадна ийм дахиад ийм тогтоолын шаардлага хэрэгцээ ер нь байгаа юу? Тусгайлсан энэ 2 дахь асуулт.

Гуравдугаар асуулт нь 11 сард НҮБ дээр 5 жил тутам танилцуулдаг хүний эрхийн Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлын талаарх илтгэл танилцуулгыг хийнэ ээ. Энэ дээр ер нь бол бид нар өмнөхөөсөө хэр ахисан байгаа. Мэдэхгүйдээ асууж байгаа юм биш л дээ. Яах вэ энэ парламент дээр энэ тогтоол яригдаж байгаа учраас олон нийтэд энэ талаар мэдээлэл өгмөөр байна.

Тэгээд 4 дүгээр асуулт нь болохлоороо энэ нэг хүний эрхийн 2 дугаар хөтөлбөрийн зэрэгцээгээр дагаж гарах олон хуулиуд байгаа. Энэ хуулиуд дээр одоо яг хамгийн яаралтай шийдэх ёстой.

Д.Амарбаясгалан: 3 дугаар индэр Сүнжид дарга хариулт өгье.

Д.Сүнжид: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя.

1 дүгээр асуулт. Энэ 24 дэх Хүний эрх эрх чөлөөний илтгэлийн мөрөөр гарч байгаа Улсын Их Хурлын тогтоолд 7 бүлэг асуудал орж байгаа юм. Энэ нь яг энэ илтгэл дээр тусгасан сэдэвтэй л холбоотой. Ийм асуудлууд юм байгаа юм аа. Өөрөөр хэлэх юм бол бид нар энэ дээр сонгуулийн эрхийг авч үзлээ. Сонгох сонгогдох эрхийг хүний хүний эрх хамгаалагчийн хувьд нь бид нар өмгөөлөгч сэтгүүлчийн тухай авч үзлээ. Хүүхдийн эрхийн асуудлыг технологи ашиглан үйлдэгдэж байгаа жендерийн хүчирхийллийн асуудлыг тэгээд технологи ба хүний эрхийн асуудлыг мөн шударга шүүхээр шүүлгэх эрхийн асуудлыг авч үзсэн. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа тусдаа өөрсдийн тайлангаа танилцуулсан.

Тэгэхээр таны асуулттай холбоотой эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх иргэний болон улс төрийн эрх эдийн засгийн эдийн засаг, нийгэм, соёлын, бусад эрхтэй холбоотой асуудлуудыг шийдэх ёстой юу гэвэл тийм. Өнгөрсөн 23 дахь илтгэлийн 1 дүгээр бүлэг дээр яг энэ асуудлыг авч үзээд тодорхой үүрэг даалгаврыг Засгийн газар чиглэл болгон өмнөх 23 дахь илтгэлийн мөрөөр тогтоолд тусгасан. Одоо бид нар илүү хэрэгжилтэд нь анхаарал хандуулах шаардлагатай байгаа. Тэрний өмнө 22 дахь илтгэл жишээлэх юм бол иргэний болон улс төрийн чиглэлээр Хэвлэлийн эрх чөлөөний хууль жагсаал цуглаан ТББ-ын тухай хуулийг үзэл

баримтлалын хувьд шинэчлэн найруулахгүй бол бид нар энэ орон зайг хамгаалж чадахгүй ийм эрсдэл байна гэдгийг нь дүгнэсэн байдаг.

Тийм болохоор бид нар энэ өмнөх тогтоолуудынхаа хэрэгжилтийг хангах үр дүнд чиглэх яг хүний эрхэд эерэг үр нөлөө үзүүлэхүйц ийм байдлаар эрх зүйн зохицуулалтыг хийх бол хууль эрх зүйн ийм хууль тогтоомжийг шинэчлэх шаардлагатай байгаа гэдгийг дахин хэлье.

Тэгээд бусад асуудлуудын тухайд хүний эрхийг хангах 2 дугаар хөтөлбөрийн хүрээнд бид нар яг таны сая санаа зовж байгаа асуудлуудыг бүлэглэж авч үлдсэн.

Өөрөөр хэлэх юм бол иргэний болон улс төрийн эрхийн хүрээнд бид нар авч үзэж байгаа. Түүнээс гадна эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хүрээнд тулгамдсан шийдэх ёстой асуудлыг авч үзсэн. Мөн зорилтот бүлгүүдийн хувьд бид нар ямар асуудлыг авч үзэх ёстой вэ гэдгээ тусгасан. Шинээр үүсэж байгаа хүний эрхийн асуудлуудыг бид нар хэрхэн авч үзэх вэ гэдгийг нь тусгасан байгаа. Олон улсын гэрээ конвенцын хороодын өгсөн зөвлөмжийн хүрээнд бид нар ямар асуудлыг Монгол Улс тухайлан авч үзэж эрэмбэлж шийдэх ёстой вэ гэдгийг нь тусгасан. Тийм болохоор хүний эрхийг хангах 2 дугаар хөтөлбөр дээр энэ асуудлууд цогцоороо орсон ийм ийм байдлаар саналаа боловсруулаад явж байгаа. Цаашид бас Улсын Их Хурлын ажлын хэсэг энэнд анхаарал хандуулна гэж найдаж байна.

Гурав дахь нь UPR буюу хүний эрхийн ээлжит төлөв байдлын хэлэлцүүлгийн үр дүн нэгдсэн байдлаар бид нарт ГХЯ-аас энэ тайлан нь ирээгүй байна. Явцын тайлантай танилцахад ахисан үзүүлэлт байна, ахиагүй үзүүлэлт ч байна аа. Тэгээд энэ дээр яг саяын хэлдэг тэр санаа зовниж байгаа зарим асуудлууд хэвээрээ байгаа. Өөрөөр хэлэх юм бол бид нар арга хэмжээ авсан гэж тайлагнаад байгаа юм. Тодорхой ийм арга хэмжээ авлаа, сургалт хийлээ, үйл ажиллагаа хий лээ гээд харин үр дүнд хүрсэн. Энэ хэрээрээ бид нар хүний эрхийг хангачихсан ч гэдэг юм уу ийм үзүүлэлтийг зарим талаар илтгэж чадахгүй байгаа ийм асуудлууд бий.

Танилцуулж дууслаа.

Д.Амарбаясгалан: Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: Тэгээд яах вэ мэдээж энэ хүний эрхийн асуудал ингээд л бэрхшээл дуулиан шуугиан гарахаар нөгөө муу л баруун хойд талын хар овоохой гэдэг шиг Үндэсний комиссыг ингээд л сошиалаар ч тэр амтай болгон шүүмжилж байдаг аа. Тэгэхдээ яах вэ чуулганы танхимд хариуцлагатайгаар хэлэхэд бол манай ХЭҮК гишүүд бол нэлээн хичээж ажиллаж байгаа. Ялангуяа олон нийтэд энэ хүний эрхийн боловсролыг түгээх энэ чиглэлээр олон үйл ажиллагаа сургалт явуулах энэ мэт ажил дээр хичээж байгаа. Гэхдээ яах вэ тодорхой хэмжээнд төсвийн хязгаарлагдмал нөөц бололцооноос болоод яг бүтэн зургаар нь ажлууд бүрэн дүүрэн явж чадахгүй байгаа талууд байгаа. Мөн энэ эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн манай Тэлмэн ажлын албаныхан, Үнэнтөгс гээд хамгийн сайнаараа л хичээж ажиллаж байгаа. Тэгээд та бүхэнд онцгойлж талархал дэвшүүлж амжилт хүсэж байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа. Санал хураалтыг түр хойшлуулна.

3 тогтоолын төслийг цувруулж хэлэлцээд санал хураалтыг нэг дор зохион байгуулна аа.

Дараагийн асуудалд оръё. Байнгын Төсвийн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо хуралдаж байгаа гишүүд байнгын хорооны хуралд орж саналаа хэлэхийг хүсье ээ.

Дараагийн асуудалд Оръё.

“Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх ТББХ-ны танилцуулгыг Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярмагнайн Баярбаатар танилцуулна аа.

Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 173 дугаар захирамжаар төрийн үйлчилгээг хүнд төвтэй болгох бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй процессын дахин инженерчлэлийн үйл ажиллагааг нэгдсэн арга зүйгээр хангах санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажилласан бөгөөд ажлын хэсгээс төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх аргачлалыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

ТББХ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.6-д заасны дагуу 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийг хэлэлцлээ. Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар процессын дахин инженерчлэл хийх явцад өмнө нь хэрэглэж байсан чиг үүргийн шинжилгээ болон ажлын байрны шинжилгээний аргачлалууд ашиглагдаж байгаа эсэх, өмнөх аргачлалуудтай харьцуулахад ямар давуу тал онцлогтой талаар болон мэргэшсэн хүний нөөцийг хэрхэн бэлтгэх зохион байгуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар процессын дахин инженерчлэлийн хүрээнд хүний нөөцийн бодлого чиг үүргийн шинэ зохион байгуулалт, хамрагдах эсэх, зөвхөн үйл ажиллагааны түвшинд хийгдэж байгаа эсэхийг тодруулаад ТӨК-удын бүтцийг оновчлох заримыг нь нээлттэй болгох хувьчлах зэрэг бодлогод тусгагдсан эсэх талаар тус тус асуулт асууж хариулт авсан болно оо.

Түүнчлэн Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар төрийн үйлчилгээний үр ашиг, хүнд суртлын бууруулах, цахим шилжилтийг үр дүнтэй хэрэгжүүлэх чухал арга хэмжээ бөгөөд төрийн байгууллагуудын үйл ажиллагааг бүтцийн түвшинд нарийвчлан шинжилж иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг хялбар ойлгомжтой болгох мөн төрийн байгууллагуудын чиг үүргийн онцлогийг харгалзан арга зүй, хүний нөөц, сургалтын зохион байгуулалт зэрэг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдаа холбоотойгоор хэрэгжүүлэх талаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир төрийн бүтцийн оновчлол орон тооны цомхотголын нарийвчилсан судалгаанд үндэслэн хийхэд ач холбогдолтой бөгөөд төрийн байгууллагууд ижил хандлагаар

цомхотгол хийх гэж байгаа нь бодит ачаалал хүний нөөцийн хэрэгцээг харгалзаагүй үндэслэл багатай байж болзошгүйг анхааруулаад процессын дахин инженерчлэлийн хүрээнд шинжилж илүү нарийвчилсан бодитой шийдэлд хүрэх талаар үг хэлсэн болно оо.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх “Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд “Төрийн үйлчилгээний процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Намуугийн Цэрэндаваа судлаач, Ундраагийн Хосжаргал судлаач.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье өө.

Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

А.Ариунзаяа: Ажлын хэсгийг Анар гишүүн ахалсан. Золжаргал, Батнайрамдал, Мөнхбат, Түвшин, Ундраа, Уянгаа, Хэрлэн, Цэнгүүн, Энхтүвшин, Лувсанжамц нар 2024 оны 10 сараас хойш ажилласан байгаа. Ер нь бол энэ процессыг нь дахин инженерчлэл нь яг яагаад чухал юм бэ гэхлээр яг өнөөдөр Засгийн газар 12 мянган төрийн албан хаагчийг цомхотгоно гэж байгаа энэ цаг үед уг нь бол давхардсан чиг үүргийг арилгах, автоматжуулах боломжтой чиг үүргүүдийг гаргаж ирэх. Ийм ухаалаг өөрчлөлтийг хийсэн бол төрийн албан хаагчдыг хохироохгүй, төрийн албан хаагчдыг хэлмэгдүүлэхгүй ийм боломж байсан юм аа. Тэгээд яах вэ хожимдсон ч гэсэн энэ тогтоол батлагдаж байгаад баяртай байна. Энэнийхээ дагуу төрийн үйлчилгээг илүү ухаалаг болгож иргэддээ илүү түргэн шуурхай үйлчлэх боломжийг бий болгоно гэдэгт итгэлтэй байна аа. Ажлын хэсэгт талархлаа дэвшүүлье ээ. Баярлалаа.

Үг хэллээ.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууж үг хэлье.

Ц.Идэрбат: Энэ асуудлыг бүрэн дэмжиж байгаа. Энэ бол ерөнхийдөө яах вэ зүгээр ард иргэдийн дунд яригддаг нөгөө хүнд суртлын хэрхэн яаж багасгах вэ гэдэг нэг асуудал.

Хоёрдугаарт сая Ариунзаяа гишүүний хэлж байгаа орон тооны цомхотголын асуудал. Уг нь энэ асуудал эхэлж явагдчихаад дараа нь тэр орон тооныхоо асуудлуудыг ярьсан бол их зөв дараалалтай болох байлаа.

Гурав дугаарт ер нь бид нар цахим үндэстэн болж хөгжих энэ эхлэлүүд бас амжилттай тавигдаад ингээд явж байна. Одоогоор бид нар яах вэ цаасаар хэвлэх байсан юмыг цаасаар авах байсан тодорхойлолт мэдээллийг бид нар цахимаар авдаг боллоо гэдэг энэ зүйлийг ингээд хэлж яриад явж байгаа. Тэдний хэмжээний цаас хэмнэлээ, тэдэн төгрөг хэмнэлээ гэдэг ийм агуулгаар одоохондоо үнэлэгдээд яриад байна. Ер нь цаашдаа энэ цахим үндэстэн болох эхлэл маань энэ инженержилттэй би туйлын салшгүй холбоотой гэж ингэж харж байгаа. Тэгээд амьдрал дээр олон зүйлүүд яригддаг. Би энэ чуулганы танхимд ингээд ярьж байсан. Энэ баялаг бүтээгч нар ялангуяа төрийн худалдан авалтад бүтээн байгуулалтын ажилд оролцоод гүйцэтгэлээ 20, 30 хувиа хийчхээд мөнгөө гаргаж авахын тулд 20 гаран хүний гарын үсгийг цуглуулж хүлээж байж өнөөхийг нь авдаг. Өнөөх нь ээлжийн амралттай янз бүр байдаг. Өчнөөн сар хүлээдэг тэр хэрээр ажил хойшилдог гэх мэтийн ингээд олон зүйлүүд байдаг.

Саяхан надад нэрээ хэлэхийг байгууллагаа хэлэхийг бол битгий цааш нь хэлээрэй гэсэн. Юу яригдаж байна вэ гэхээр одоо ингээд бидний хийж байгаа ажил маань лабораторийн үйл ажиллагаа явуулдаг. Үндэсний хэмжээний лабораторийн үйл ажиллагаа явуулдаг. Гэтэл одоо манай лаборатори дээр цомхотголын асуудал яригдахад яг лабораторийн үйл ажиллагаанд ямар нэгэн зүйлээр орлуулах бололцоогүй зүйлийг хийдэг тэр мэргэжлийн ажилтнуудын дунд цомхотголын асуудал яригдаад, дээд захиргааны байгууллагатай бол цомхотголын асуудал нь яригдахгүй иймэрхүү байдалтай яваад байна гэж байгаа юм. Тэгэхээр ер нь энэ Анар гишүүний ахалсан энэ асуудал бидний байнга ярьдаг хүнд суртал, бидний байнга ярьдаг тэр орон тооны хэтрэлтийн асуудлууд, чиг үүргийн давхардлын асуудлууд бидний байнга ярьж байгаа тэр цахим үндэстэн болох асуудлын гол үндэслэл нь, гол барих чиглэл нь энэ тодорхой болох гэж байна гэж ингэж би харж байгаа.

Тийм учраас дэмжиж байгаагаа илэрхийлж үг хэлж байгаа юм аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Дараачийн асуудалд оръё.

Санал хураалтыг түр хойшлуулъя.

Хоёр Байнгын хороо хуралдаж байгаа учраас санал хураалтаа түр хойшлуулж байна аа.

“Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал танилцуулна индэрт урьж байна.

О.Батнайрамдал: Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос боловсруулж 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан.

“Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн чуулганаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсэгт заасны дагуу Байнгын хороогоор дахин хэлэлцүүлэхээр буцаасан.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 7 сарын 7-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийг дахин хэлэлцээд тогтоолын төсөлд дараах өөрчлөлтүүдийг нэмж тусгалаа.

Үүнд:

Нэгдүгээрт банкны системийн тухай хугацааны дундаж хүүгээс өндөр хүүтэйгээр тооцож байгаа хугацаатай хадгаламж нь банкнуудын эх үүсвэрийн өртөг зээлийн хүүг тогтооход хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаа хийж танилцуулах,

2 дугаарт банкнаас эрсдэл багатай зээлдэгчид олгох зээлийн хүүгийн мэдээллийг ил тод, нээлттэй зарладаг байх асуудлыг холбогдох журамд тусгах.

3 дугаарт банк эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээг үл хөдлөх эд хөрөнгийн барьцаанд тулгуурлан тооцох өнөөгийн журмыг зээлжих чадварын зэрэглэлээс харгалзаж боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж танилцуулахыг тус тус холбогдох албан тушаалтанд даалгах асуудал болно.

Мөн дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэх асуудлыг Монгол банк, СЗХ-нд даалгахын зэрэгцээ санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд даалгах нь зүйтэй гэж үзлээ.

Ийнхүү боловсруулсан төслийн эцсийн хувилбарыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхэд хуралдаанд оролцогч гишүүдийн олонх уг тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

“Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэндээ хүргүүллээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эдийн засгийн байнгын хорооноос боловсруулсан Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэн тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Түндэвийн Жамбаажамц СЗХ-ны дарга Өлзийбатын Мөнх-Ундарга Монгол банкны Банк санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал, Бэгзийн Итгэлсүрэн СЗХ-ны Банк санхүүгийн байгууллагын газрын дарга, Жаргалсайханы Мөнх-Оргил СЗХ-ны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Баттулгын Дөлгөөн СЗХ-ны үнэт цаасны газрын дарга. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлнэ. Нэрээ өгье. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууж үг хэлье.

Ц.Идэрбат: Энэ зээлийн хүү бууруулна гэдэг асуудал олон 10 жил яригдаж байгаа. Мөн Монгол Улсад бизнес эрхлэх бусад олон нийгмийн харилцаанууд дээр маш их хүндрэлүүдийг дагуулдаг. Ийм л зүйл. Тэгэхдээ зээлийн эх үүсвэрийн асуудал өөрөө нэг номерт зээлийн хүү буурахын үндэс шалтгаан болдог гээд олон зүйлүүд хүчин зүйлүүд байгаа. Гэхдээ би зүгээр үүнийг Монголбанкнаас төлөөлж байгаа хүнээс асуух гээд байгаа юм.

Нэгдүгээрт энэ зээлийн хүү бууруулах энэ олон шат дараалсан арга хэмжээнүүдийн дундаас та бүхэн энэ Улсын Их Хурал дээр Мэдээллийн сангийн тухай хуулийг хүртэл яригдаж байх үед энэ тэтгэврийн зээл буюу эх үүсвэр нь зээлийн эргэн төлөлт нь маш найдвартай ийм зээлийн нэг бол тэтгэврийн зээл юм. Тэтгэврийн зээлийн хүүг бууруулахад хамгийн түрүүнд боломжтой юм гээд л ингээд л ярихад та бүхэн яриагүй шүү.

Ингээд гишүүд ингээд ярихад тийм тийм хамгийн түрүүнд буулгах боломжтой гэж ингэж ярьдаг. Тэгж ярьснаас хойш үндсэндээ бараг 3, 4 сар боллоо л доо. Тэгэхээр заавал ингээд тогтоол гаргахгүйгээр Монголбанкны зүгээс энэ зээлийн хүүгийн асуудал дээр анхаарал хандуулаад тэтгэврийн зээлийг ядаж буулгах тал дээр анхааръя гэдэг ер нь тийм алхмууд энэ хугацаанд хийв үү, нэг.

Өнөөдөр бодит байдал дээр бол тэтгэврийн Монгол Банкны Мөнгөний бодлогын хороо, Улсын Их Хурлын Байнгын хороо, Их Хурлын гишүүд, Ерөнхий сайдын түвшинд энэ асуудал яригдаж байгаад ингээд нэг зээл олголт Хаан Банкнаас авхуулаад ингээд шуурхай олгогдоод ингээд явж байна. Гэхдээ зөрүүлээд нөгөө зээлийн хүү нь өсөж байгаа байхгүй юу. Өсөж байгаа. Тэгэхээр ер нь яах вэ та нар ингээд энэ танхимд орж ирээд ярихад бол Их Хурлын гишүүдийн амыг дагуулаад нээрээ тийм шүү яг тийм шүү, зөв зүйтэй санал байна шүү гэдэг юм ярьдаг хэрнээ яг тийм үйлдэл ердөө гаргадаггүйг би энэ Монголбанкны зүгээс гайхаад байдаг байхгүй юу тэ? Энэ салбарыг мэддэг хүмүүс нь ярихаар яг зөв ярьж байна гээд байдаг. Яг хариу үйлдэл яг бие даагаад хийсэн зүйл байна уу гэдэг тал дээр би энэ Монголбанкнаас асуух гээд байгаа юм.

Хэрвээ бид ингээд энэ зээлийн хүүгийн өнөөдрийн энэ Их Хурлын тогтоолыг ч гэсэн батлаад энэ ба тогтоол ямар нэгэн байдлаар хий хоосон зүйл болохгүй байвал одоо Монголбанкны зүгээс энэ нэлээн том ажил болох байх. Гэхдээ би түрүүнд хэлсэн энэ зээлийн хүү гэдэг чинь ингээд зээлийн эх үүсвэрээсээ авхуулаад олон юмнаас шалтгаалдаг учраас хүндрэлүүд гарах л байх. Гэхдээ яг энэн шиг энэ тэтгэврийн зээл шиг зүйлээс эхлээд хийж эхэлсэн алхам байна уу төлөвлөгөө байгаа юм уу гэж би тодруулж асууя гэж ингэж бодож байгаа юм.

Монголбанк 4 дүгээр индрээс хариулт өгье.

Ө.Мөнх-Ундрах: Гишүүний асуултад хариулъя аа. Яг таны дурдсан асуудал бол өнөөдрийн байдлаар тогтоолын 3 дугаар заалт дээр орж ирсэн байгаа. Энэ дээр бол бизнесийн болон хэрэглээний зээлийн бүтээгдэхүүн тус бүрээр нь эх үүсвэр болон бусад төрлийн тэр зардлыг тооцоод бүтээгдэхүүн тус бүр дээр нь судалгаа хийж эх үүсвэрийн зардлыг бууруулахыг бол буцаагаад Их Хурал болон Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахаар ийм үүрэг өгөгдөж байгаа.

Одоогийн байдлаар бол хэрэглээний зээл дээр тухайлах юм бол таны ярьж байгаа тэтгэврийн зээлтэй холбоотой хэсэг дээр манай өмнөх удирдлагууд хэлсний

дагуу нийгмийн даатгалын сангийн банкнууд дээр байршиж байгаа чөлөөт үлдэгдлүүдтэй уялдуулаад энэ эх үүсвэрийн зардлыг бууруулах бололцоо байна уу гэдэг дээр бол холбогдох бодлогын яамдуудтай бол яриа хэлэлцээрүүд бол эхэлж байгаа гэж ойлгож байгаа.

Д.Амарбаясгалан: Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: Яах вэ ойлгож байгаа таныхыг? Тэр нөгөө эх үүсвэр нь нийгмийн даатгалын шимтгэлийнхээ тэр хөрөнгө дээрээ явах юм зээл буурах, тэтгэврийн зээл буурах боломжтой гэж. Гэхдээ одоо бодогдож байгаа энэ зээлийн хүүгийн бүрэлдэхүүн дотор эрсдэлийн үнэлгээнүүд чинь бас нэлээн тодорхой хувийг эзэлдэг юм байна лээ шүү дээ. Гэтэл бизнесийн зээл эрсдэлтэй. Тэтгэврийн зээл 2-ын эрсдэл маш багатай, бараг байхгүй шахуу гэж үздэг. Тэгэхээр байхгүй эрсдэлийн төлөө эрсдэлтэй зээлүүдтэй адилхан хүү төлөөд байх нь шударга бус юм биш үү гэдэг зүйлийг хөндсөн байхгүй юу. Би тэрийг л хөндөөд байгаа юм.

Тэгэхээр яг энэ тэтгэврийн зээл гэдэг энэ ангилал дээр эрсдэл гэдэг юм нь ядаж байхгүй учраас тэр зээлийн бүрэлдэхүүн дотор байгаа эрсдэлийнх нь хүчин зүйлд таарсан зээлийнх нь хүүг буулгах бололцоо одоогоор хамгийн амархан. буулгах нэг ганц 2 функтээр ч гэсэн буулгах бололцоо байна гэж хараад байгаа байхгүй юу. Би тэрийг л тодруулж асуугаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгье 4 дүгээр индэр.

Ө.Мөнх-Ундарга: Зээлийн эрсдэлийн зардал өнөөдрийн тооцоогоор болоод нийт зардлын 13-аас 15 орчим хувь нь бол зээлийн эрсдэлийн зардал байна гэж ерөнхийдөө тооцоо гарч байгаа. Энэ зээлийн эрсдэлийн зардлыг бүхэлд нь аваад үзэх юм бол хууль, эрх зүйн зардал буюу зээл чанаргүйдэхэд болон гэрээ хэлцлийг хэрэгжүүлэхдээ явцтайгаар гарч байгаа зардлууд ойлгогдож байгаа. Үүнтэй холбоотойгоор Засгийн газраас суурь хуулиуд дээр бол нэмэлт, өөрчлөлт орох шинэчилсэн найруулгууд гэх мэтчилэн хуулиудыг болбол Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн байгаа.

Тухайлах юм бол Шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийг гээд шинэчилсэн найруулгууд орж ирж байгаа. Харин тэтгэврийн зээлийн хувьд бол 2 талтай байгаад байгаа. Тантай санал нэг байна. Гэхдээ өнөөдрийн байдлаар тэтгэврийн зээлийг олгоход олгохдоо анхнаасаа банк нөгөө татан төвлөрүүлсэн эх үүсвэрээсээ энэ зээлийг олгоод дараа нь нийгмийн даатгалын сангаас авч байгаа тохиолдол байгаа. Удирдлагуудын бодлогын яамтай ярьж байгаагаар бол энийг нь нийгмийн даатгалын сангийн банкнууд дээр байгаа чөлөөт үлдэгдэл

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

А.Ариунзаяа: Санхүүгийн зах зээлийг аваад үзэх юм бол 3 тулгуурт байдаг. Банк, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл тэ? Тэгээд манайх бол банкны салбар бол бараг энэ санхүүгийн зах зээлийнхээ 85, 90 хувийг эзэлж байгаа. 8 орчим хувийг хөрөнгийн зах зээл эзлээд 2 орчим хувийг манай даатгалын салбар эзэлдэг. Би буруу яриагүй л бол. Тэгээд бид хэтэрхий их энэ зээлийн хүү гэхлээр ер нь банкаа л бариад явчихдаг. Монголбанк, СЗХ адилхан л Улсын Их Хурлын харьяа байгууллагууд, адилхан л ажлаа тайлагнадаг. Жилдээ төсөв төсвийн бодлого Улсын Их Хурлаар хэлэлцдэг. Мөнгөний бодлогыг бас Улсын Их Хурлаар хэлэлцээд

байдаг. Гэтэл дэлхийн бусад бүх улс орныг аваад үзэхээр Монголбанкны мөнгөний бодлогыг Улсын Их Хурлаараа хэлэлцэж баталдаг улс орнууд бол бараг байхгүй дээ цөөхөн.

Тэгээд бид нар өөрсдөө нийгэмд буруу дохио өгөөд байдаг. Тэгээд энэ СЗХ-ны хариуцаж байгаа энэ салбарыг ердөөсөө нэг тийм ач холбогдол өгөхгүй орхичхоод байдаг. Зөвхөн банкаа л яриад байдаг. Гэтэл яг иргэдийн амьжиргаанд хамгийн ихээр нөлөөлж байгаа банк бус ломбард энэ жижиг өдөр тутмын зээлүүд эдгээр бүхий л асуудлууд, СЗХ-ны эрхлэх асуудалд орчихдог.

Тэгэхээр яг энэ зээлийн хүүг бууруулах арга хэмжээг бол банкнууд гэхээсээ илүүтэй СЗХ-ны хийх ёстой ажлууд нэлээдгүй өндөр ач холбогдолтой гэж харж байгаа юм аа. Тэгээд үүн дээр ойрын хугацаандаа энэ 11 сар хүртэл ямар ажлууд ер нь хийж болохуйц байна вэ? Үүн дээр нэг хариулж өгөөч.

Монголбанкнаас гадаадын банк Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх талаар бид нар сүүлийн миний мэдэхийн л арваад жил ярьж байна. Тэгээд ердөөсөө гаднын банкнуудыг ердөөсөө оруулдаггүй хаачихдаг. Гэтэл банкнууд бол дэндүү. энэ хөрөнгийн зах зээлээ үгүйсгээд энэ санхүүгийн зах зээлээ бүүр ингээд хэтэрхий одоо үгүйсгээд, боймлоод гэдэг юм уу тэгээд өөрсдөө л зөвхөн энэ хөрөнгийн санхүүгийн зах зээл дээрээ ч үйл ажиллагаа явуулахгүй банкнууд бол бусад бүхий л боломжит даатгал хоолны салбар юу л байна аялал жуулчлал бүхий л салбар руу орж байна шүү дээ тэ? Тэгэхээр уг нь бол энэ банкнуудын үйл ажиллагааг нь салбарыг нь бол жоохон хумимаар байгаа юм. Хуулиараа ч тэр. Гаднын банкуудыг оруулж ирмээр байна. Тэгээд энэн дээр ойрмог ажил төлөвлөгдөж байна уу үгүй юу? Санхүүгийн зохицуулах хороо яг одоо банк бус энэ салбар дээр ойрын хугацаанд хийх боломжтой ажлуудыг юу гэж харж байна вэ?

Д.Амарбаясгалан: СЗХ-ны дарга Жамбаажамц хариулт өгье. 4 дүгээр индэр.

Т.Жамбаажамц: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. 3 чиглэлээр товчхон хариулъя гэж бодлоо.

1 дүгээрт нь ерөнхийдөө энэ хөрөнгийн зах зээл дээр ялангуяа энэ тогтоолын төслийн 2 дугаар хэсэг дээр байгаа хөрөнгийн зах зээл дээр эх үүсвэр татах дэд бүтцийн байгууллагуудын зардал шимтгэлийг бууруулах гэсэн ийм ажлууд байгаа.

2020 оны Улсын Их Хурлын 21 дүгээр тогтоолоор баталсан Зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд хөрөнгийн зах зээл дээрх дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл хураамжийн хэмжээ 50 хувиар, зарим шимтгэлүүд 70хүртэл хувиар буусан ийм үзүүлэлттэй байдаг. Энэний хүрээнд хөрөнгийн зах зээл дээр нэлээдгүй шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ санхүүгийн хэрэгслүүд гарсан. Компаниуд бондын хэлбэрээр санхүүжилт татах ийм бололцоо нэлээдгүй нэмэгдсэн.

Өнгөрсөн 2024 онд хөрөнгийн бирж дээр нийтдээ 1 их наяд төгрөгийн бондын арилжаа хийгдсэн. Компанийн бондын арилжаа биржийн бус зах зээл дээр сүүлийн 2 жилийн хугацаанд 3.8 их наядын 150 орчим компанийн бондын арилжаа хийгдэж өөрөөр хэлбэл банкнаас бусад энэ хөрөнгийн зах зээл дээр шууд санхүүжүүлж, татаж, бизнесээ санхүүжүүлэх энэ боломж энэ хүрээнд нээгдсэн.

Тэгэхээр цаашид бол бид бүхэн энэ хөрөнгийн зах зээл дээр ялангуяа энэ үндэсний томоохон ААН-үүд компаниуд, түүний дотор энэ топ 100 компаниудыг хөрөнгийн бирж дээр шалгуур багатай өөрөөр хэлбэл баталгаа батлан даалтгүйгээр маш хурдан шуурхай богино хугацааны 5 хүртэл тэрбум төгрөгийг богино хугацаанд татаж бизнесээ санхүүжүүлэх энэ боломжийг бодлогоо гаргаад хэрэгжүүлээд ингээд явж байгаа.

Сүүлийн үед бол хөрөнгийн зах зээл дээр энэ ногоон гэдэг юм уу нийгмийн бондын төрлүүд нэлээдгүй их гарч байна. 2024 оны Дэлхийн банкны судалгаагаар дэлхийн хөрөнгийн зах зээл дээр 6.2 их наяд долларын хэмжээний сошиал буюу нийгмийн бонд, тогтвортой байдлын бонд, жендер бонд гэсэн ийм шинэ бүтээгдэхүүнүүд гарч байгаа. Энэ трендийг Монгол Улсад яг энэ хэлбэрээр нь ОУСК-тай СЗХ хамтарч ажиллаад анхны бүтээгдэхүүнүүд хөрөнгийн зах зээл дээр гараад маш эрэлттэй ийм бүтээгдэхүүнүүд гарч байгаа. Өөрөөр хэлбэл банкнаас гадна бусад ийм санхүүгийн олон төрлийн хэрэгслүүдээр хөрөнгийн зах зээл дээрээс хөрөнгө бат татан төвлөрүүлж үйл ажиллагаагаа санхүүжүүлэх энэ боломжийг нээж байгаа.

Хоёрдугаарт нь бол энэ банк бус санхүүгийн байгууллагууд дээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, өөрийн хөрөнгө, итгэлцэл, татах хэмжээн дээр СЗХ тодорхой хэмжээний үе шаттай өөрийн хөрөнгийн хүрэлцээгээ нэмэгдүүлэх өөрийн хөрөнгийн чадвар нэмэгдүүлэх энэ чиглэлээр зохистой харьцааны бодлогоо нэлээн өөрчлөөд ажиллаж байгаа. Энэ хүрээнд энэ тогтоолоор бол хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг хотод үйл ажиллагаа явуулдаг банк бус санхүүгийн байгууллагуудаар ялгаатай ийм зохистой харьцааны бодлогыг хэрэгжүүлэх нь эх үүсвэрийн зардалд чухал нөлөөтэй юм гэж ажлын хэсгийн зүгээс үзсэн. Тэр хүрээнд бол энэ тодорхой заалтууд бол энэ 2 дахь заалтын 2 дахь хэсгээр орж ирж байгаа. Энэ хүрээндээ бид бүхэн энэ жилдээ энэ ББСБ буюу бичил санхүүгийн институцийг энэ хүрээнд нэлээдгүй өөрчлөлт оруулаад ингээд явна гэж харж байгаа юм.

Гуравдугаарт нь нийлүүлэлтийн сүлжээний Банк санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг СЗХ-ноос боловсруулчихсан байж байгаа. Энэ хүрээнд бол нөгөө факторингийн буюу нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн энэ тогтолцоог дараагийн шатад гаргахаар хуулийн төслийг боловсруулчихсан.

Өөрөөр хэлбэл бэлтгэн нийлүүлэгч нар худалдан авагч нар зөвхөн зээлээс гадна өр авлагаа худалддаг шилжүүлдэг факторингийн үйл ажиллагаагаар санхүүжүүлдэг. Ингэснээр эх үүсвэрийн зардал нь тэр хэмжээгээр багасах ийм боломжийг олгоод явж байгаа.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя. Нэмж нэг минут. Гаднын банкны асуудлаар СЗХ. Монгол банкнаас хариулт өгөх үү?

4 дүгээр индэр

Ө.Мөнх-Ундрах: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя за.

Гадаадын банктai холбогдуулаад өнөөдрийн байдлаар бол яг албан ёсоор хүсэлтээ ирүүлсэн зүйл бол байхгүй байна. Харин энэ чиглэлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхээр Монголбанкнаас ерөнхийдөө 3 чиглэлээр бол ажиллаж байна. Энэ

нь нөгөө Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн нэг дэх хэсэг болох банкны хувьцаа эзэмшлийн 20 гэдэг тоон дээр бол судалгаанууд хийгээд эхэлсэн байна. Энэ эдээр бол гадаадын хөрөнгө оруулагчид орж ирэх нөхцөл бололцоог нэмэгдүүлэх шаардлагатай гэдэг ийм хэлэлцээрүүд явагдаж байна.

Хоёр дахь нь бол суурь эрх зүйн тогтолцоо өөрөө хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх буюу эх үүсвэр татахад бол нэлээн ийм төвөгтэй асуудлууд байгаад байгаа учраас энийг бол цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай байна гэдэг дүгнэлтийг Зээлийн хүү бууруулах стратегийн дүгнэлтэд Монгол банкнаас тусгаж өгсөн байгаа. Энэ нь юуг хэлж байгаа гэхээрээ эх газрын эрх зүйн тогтолцоотой улсад банкны салбар илүү хүчтэй буюу давамгайлсан ийм нөхцөл байдал бол олон улсын судалгаагаар тогтоогдсон.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Гадаадын банк санхүүгийн байгууллагуудыг Монгол Улсад үйл ажиллагаа явуулах эрхийг нь нээхэд маш олон жил яригдаж байгаа гэж би түрүүн хэлсэн тиймээ. Тэгээд ер нь банкны эзэмшигчид бодлого шийдвэр гаргаж байгаа хүмүүст нөлөөлдөг байх вий дээ гэдэг ийм болгоомжлол бол надаа байдаг. Үнэхээрийн энэ ажлыг гацаагаад хойшлуулаад удаашруулдаг. Нөгөө талдаа бол СЗХ-нд бид нар одоо Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурал ч гэсэн яг СЗХ-ны үйл ажиллагаандаа дэмжлэг үзүүлж энэ байгууллагын статусыг дээшлүүлэхгүй бол ердөөсөө л Монголбанк л хамгийн чухал юм шиг ийм буруу ойлголттой бид нар яваад яг хамгийн чухал салбараа бол орхигдуулаад байдаг гэдгийг энд давхар энд давхар давхар хэлмээр байна. Дахиад нэг зайлшгүй хэлэх ёстой асуудал маань өөрөө юу юм бэ гэхээр энэ мөнгө хүүлэлт банкны банк өөрөө банк бустай байх банкны ажилчид банк бустай байж үйл ажиллагаа явуулж байна гэдэг мэдээ мэдээллүүд яваад байдаг тиймээ?

Энэ дээр эдийн засгийн гэмт хэрэг.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя, 4 дүгээр индэр.

Ө.Мөнх-Ундрах: Гадаадын банк, Гадаадын хөрөнгө оруулагч Монгол Улсад орж ирэхэд бол Банкны тухай хууль болон санхүүгийн салбарын хуулиуд харьцангуй нээлттэй. Дүгнэлтээр бол суурь эрх зүйн орчин буюу суурь хуулиуд тухайлах юм бол иргэний хууль, Иргэний хэрэг, шүүхэд хянан шийд шийдвэрлэх тухай хууль, Шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль гэх мэтчилэн хөрөнгө оруулагч өөрөө ашгаа хүртээд ... хийх бололцоо бол одоогоор бол харьцангуй хумигдмал байгаад байгаа учраас энийг цогцоор нь дүгнээд цогцоор нь шинэчлэх шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах шаардлагатай байна гэдэг дүгнэлтийг Монголбанкнаас энэ зээлийн хүү бууруулах стратегийн дүгнэлтэд бол тусгасан явж байгаа.

Банкнаас банк бус болон бусад салбар руу бол мөнгө хүүлээд байгаа асуудалтай холбоотойгоор сүүлийн энэ онд 2 байгууллагаас бол албан ёсны шийдвэр гарсан байж байгаа. Банкнаас бусад мэргэжлийн оролцогчид эх үүсвэр олгохгүй байхтай холбоотой СЗХ-ны шийдвэр болон.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Ө.Мөнх-Ундрах: Тийм, гарсан байгаа. Харин тантай хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх буюу СЗХ-ны эрх зүйн байдлыг нэмэгдүүлэх зохицуулалтын байгууллагын эрх зүйн орчныг сайжруулахдаа санал нэг байна. Энэтэй холбоотойгоор Монголбанкнаас зээлийн хүү бууруулах стратегийн хэрэгжилтийн дүгнэлтэд энэ чиглэлээр эрх зүйн орчныг сайжруулах зайлшгүй шаардлага байна гэдэг дээр дүгнэлтээ тусгаад хүргүүлсэн байж байгаа. Эдийн засгийн байнгын хороонд

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууж үг хэлье.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Зээлийн хүүг бууруулах чиглэлээр авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэж байна. Яг энэ тогтоол батлагдлаа гэхэд Монголбанк хэчнээн төрлийн арга хэмжээг урт болон богино хугацаанд авч хэрэгжүүлэх вэ? Зээлийн хүү өнөөдөр арилжааны бизнесийн зээл 17, 18-аас 21, 22 хувийн хүүтэй зээл авч байгаа юм. Энэ зээлийн хүү яг ямар хугацаанд, хэзээнээс, хэдэн хувиар, хэдэн нэгжээр буурах юм. Энийг маш тодорхой хэлж өгөөч. Ямар ямар арга хэмжээ авч байж энэ зээл буурах юм бэ, хүү буурах юм бэ? Маш тодорхой хариулж өгөөрэй. Худлаа бөөрөнхийлөөд ингээд ерөнхий юмнууд яриад баймааргүй байна хэзээнээс яг буурах юм бэ?

Нөгөө талаар энэ арилжааны банкнууд чинь ер нь энэ Монголбанкны бодлогод орж байна уу үгүй юу? Захирагдаж байна уу үгүй юу? Монголбанк хяналтаа тавьж чадаж байна уу үгүй юу? Яагаад ингэж асууж байна гэхээр өчигдөр уржигдархан Ерөнхий сайд Монголбанкны удирдлагатай уулзаж энэ ахмадын тэтгэврийн зээлийн асуудлаар уулзаж үүрэг чиглэл өгч Мөнгөний бодлогын хороо нь хуралдсан байна лээ. Гэтэл өнөөдөр өчигдөр ингээд салбарын энэ Голомт банкнаас авхуулаад энэ банкнууд чинь зээлээ тэр 50, 50 хувиар нь өгнө өө л гэж тэр хамаагүй л гэж байна гэж байх жишээтэй. Энийг юу гэж үзэж байгаа юм.

Хэрвээ ингэвэл Монголбанк ямар арга хэмжээ авах вэ? Арилжааны банкнууд дээр. Та бүхэнд ямар эрх үүрэг байна. Хяналт тавих ямар эрх үүрэг байна. Тэгээд тухайн арилжааны банк нь өөрөө л мэдээд яв даа гэх юм уу. Энд ингээд л яриад байдаг. Засгийн газрын түвшинд яриад байдаг. Үүрэг чиглэл өгөөд байдаг, бодлогын хороо нь хуралдаад байдаг. Арилжааны банкнууд нь асуудалд ингэж хандвал үгүй энэ чинь тэгээд яах юм ахмадуудаа хуурсан болж таарах юм уу? Энд асуудлыг нь шийдчихсэн гээд яриад байдаг. Яг газар дээрээ арилжааны банкнууд нь тийм юм байхгүй ээ, манайд хамаагүй ээ, ингээд сууж байна гэж ийм байж болдог юм уу? Энийг нэг та бүхэнд тодруулж өгөөч. Ийм 2 асуултад маш тодорхой хариулт өгөөч.

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индрээс хариулт өгье.

Ө.Мөнх-Ундрах: Гишүүний асуултад хариулъя аа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад Монголбанканд нийтдээ 5 арга хэмжээ туссан байж байгаа. Тухайлах юм бол банкны системийн тухайн хугацааны дундаж хүүгээс өндөр хүүтэй хугацаатай хадгаламжийг банкны эх үүсвэр болон заавал ялах нөөцтэй холбоотой судалгаа хийгээд эргээд танилцуулах асуудлууд туссан байж байгаа. Энэ дээр бол Өмнөх манай удирдлагууд энэ чиглэлээр бас тодорхой байр суурийг илэрхийлсэн. Энэ тогтоолыг бол дунд хугацааны арга хэмжээ гэж үзэж байгаа.

Тэгэхээр ойрын хугацаанд шууд зээлийн хүү буух бололцоо бол тун хязгаарлагдмал байгаа. Энэ дунд хугацааны ийм арга хэмжээ байгаа. Тэтгэврийн зээлийн хувьд бол нэг дэх өдрийн мөнгөний бодлогын хорооноос гарсан шийдвэр бол өмнө нь 2020 онд гараад хэрэгжээд явж байсан 25 оныг хүртэл.

Тэгэхээр 2020 оноос хойш бол банкнууд өөрсдийнхөө бодлогын хүрээнд бол ахмадуудад зээлээ тэтгэврийн зээлээ бол өөрийн бодлого журмаар бол зээлээ гаргаад явж байсан. Тухайн үед бол ахмадуудаас тэтгэврийн зээлтэй холбоотой төдийлөн гомдлууд гарч байгаагүй. Тэгэхээр энэ нэг дэх өдрийн шийдвэрийн дагуу энэ хэвийн үргэлжлээд явна гэдэг ийм тооцоо байгаа. Харин тухайлсан нэр заасан банкнуудаас хэрвээ энэ 50, 50-тай холбоотой шийдвэрийг хэвээрээ гэдэг ийм бүтээгдэхүүнийг санал болгож байгаа чиглэл дээр Төв банк болон Банкны тухай хуульд заасны дагуу хяналт шалгалтуудаа ороод тухай бүр нь шийдвэрлээд явах боломжтой. Энэ чиглэлээр танд албан бичгээр хариу хүргүүлье.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Төсвийн байнгын хороо болон Нийгмийн бодлогын байнгын хорооны хурлууд дуусаагүй байна.

Өнөөдөр бид 3 асуудлыг зайлшгүй хэлэлцэж дуусгах шаардлагатай байгаа учраас өнөөдрийн хэлэлцэх асуудлуудаа хэлэлцэж санал хураалтаа дуустал чуулганы хуралдаанаа үргэлжлүүлье гэсэн ийм саналтай байна. Гишүүд дэмжиж байна уу? Чуулганы хуралдаанаа үргэлжлүүлье.

Ингээд 2 Байнгын хорооны хурлыг дуустал чуулганы хуралдааныг түр завсарлуулъя.

Улсын Их Хурлын чуулганаа үргэлжлүүлье. Гишүүд танхимдаа орж ирье.

Дараагийн асуудалд оръё. [Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.](#)

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Да.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсынх Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын дээд, доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг нэгэн зэрэг бууруулах өөрчлөлт орсонтой холбогдуулан жилийн төсөв төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх батлах нөхцөл бүрдэх, мөн хуулийн хэрэгжих хугацааг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал дагаж мөрдөх нь зүйтэй гэсэн санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал. Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Лангааны Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга.

Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа.

Батжаргал гишүүн алга байна. Бадамсүрэн гишүүн алга байна. Заяабал гишүүн орж ирээгүй байна. Тэмүүлэн гишүүн сая энд сууж байсан чинь хаачихав. Алга байна. Сая Байнгын хороон дээр асуултуудаа асуучхаж дээ тиймээ.

Пүрэвдаваа гишүүн алга байна. Байнгын хороон дээр асууцгаачихсан уу? Тэгвэл Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж дууслаа.

Байнгын хорооноос 2 санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрөөтэй 2 санал байна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж түүнийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно.

Улсын Их Хурлын гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүдийг санал хураалтад бэлтгэж байх хооронд дараагийн 10 дахь асуудлыг танилцуулж байна.

Санал хураалтын ирц бүрдэхээр санал хураалтдаа орно.

Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэнэ ээ.

Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабал танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Заяабал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Төсвийн байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна аа.

Төсвийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэгт Байнгын хорооны даргыг сонгохдоо Улсын Их Хуралд сонгогдон ажилласан хугацаа, туршлагыг нь харгалзан тухайн Байнгын хорооны гишүүдээс сонгох бөгөөд түүнийг улируулан сонгож болно гэж заасны дагуу Төсвийн байнгын хорооны даргад Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийн нэрийг дэвшүүлсэн болно.

Хассуурийн Ганхуяг нь 1977 онд Улаанбаатар хотод төрсөн. Эхнэр 3 хүүхдийн хамт амьдардаг. 1994 онд Монгол Оросын хамтарсан 3 дугаар дунд сургууль, 1999 онд Монгол Улсын Их сургуулийн ОУХДС-ийг төгссөн, 2014 онд АНУ-ын Харвардын их сургуулийн захирлуудад зориулсан Бизнесийн удирдлага ерөнхий менежментийн чиглэлээр, 2018 онд Канад улсын Бритиш Колумбийн Их сургуулийг уул уурхайн инженер, тогтвортой хөгжлийн засаглал чиглэлээр эчнээгээр суралцсан байна. 2003 оноос Херо группийн удирдах зөвлөлийн дарга, 2008-аас 2014 онд Ремикон ХК-ийн ТУЗ-ийн дарга, 2010-аас 2014 онд уул уурхайн ассоциацийн удирдах зөвлөлийн гишүүн, 2020 оноос Улсын Их Хурлын гишүүнээр 2 дахь удаагаа сонгогдсон.

Төсвийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн ТББХ-ны дарга Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

Гишүүд санал хураалтад бэлдэж байгаарай

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь заалт мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ХЗБХ-ны даргыг сонгох тухай асуудлыг Байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

ХЗБХ-ны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.25.7 дахь хэсэгт заасны дагуу ХЗБХ-ны даргад Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Улсын Их Хурлын гишүүн ХЗБХ-ны дарга Дамдины Цогтбаатарыг нэр дэвшүүлж нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг танилцуулсан болно.

ХЗБХ-ны даргад Улсын Их Хурлын гишүүн ХЗБХ-ны дарга Дамдины Цогтбаатарыг улираан томилуулахаар нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

ХЗБХ-ны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Өмнөх асуудал буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулах өөрчлөлтийг түр хойшлуулсан байгаа.

Тэгэхээр нэр дэвшигчид буюу Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшсэн Хассуурийн Ганхуяг, ХЗБХ-ны даргад улиран нэр дэвшсэн Дамдины Цогтбаатар нарын танилцуулга хийгдлээ.

Нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Алга байна.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна аа.

Гишүүд санал хураалтад бэлдье.

Зарим Байнгын хорооны даргад нэр дэвшигчдийг дэмжих асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье.

Нийгмийн бодлогын байнгын хорооны хурал явагдаж байна. Танхимд байгаа гишүүд нэг санал хураалтдаа бэлтгэлээ хангаад ирцээ дахиж бүртгүүлээд үзье.

БОХХАА-н байнгын хороо түр завсарласан байна.

Гишүүд танхимд орж ирээд санал хураалт.

Байнгын хорооны хурал түр завсарласан байна. Гишүүд санал хураалтад бэлдье. 5 санал хураалт явуулахаар байгаа. Санал хураалтад бэлдье.

Байнгын хорооны саналаар Байнгын хорооны даргад нэр дэвшигчдийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Санал хураалт.

1.Төсвийн байнгын хорооны даргаар Хассуурийн Ганхуягийг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор. Бүртгэл байгаа байгаа.

Төсвийн байнгын хорооны даргаар Хассуурийн Ганхуягийг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

64 гишүүн буюу 58.7 хувиар санал дэмжигдлээ

2. ХЗБХ-ны даргаар Дамдины Цогтбаатарыг улируулан сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт

63 гишүүн буюу 57.8 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны даргаар сонгох саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул “Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай”, “Байнгын хорооны даргыг улируулан сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолуудыг баталсанд тооцлоо.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол Байнгын хорооны даргыг сонгох чөлөөлөх тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны даргаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийг сонгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2025 оны 7 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дараачийн тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол Байнгын хорооны даргыг улируулан сонгох тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарыг Монгол Улсын Их Хурлын ХЗБХ-ны даргаар улируулан сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2025 оны 7 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Байнгын хорооны даргыг сонгох чөлөөлөх тухай, байнгын хорооны даргыг улируулан сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолуудын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

19.24 цаг

Дараачийн асуудал руу оръё.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явагдахаар байгаа.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Төсвийн байнгын хороо дэмжсэн санал

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “дээд хэмжээг” гэснийг “дараа нэгэн зэрэг” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн.

Санал хураалт. Уучлаарай санал хураалтаа цуцалъя. Санал хураалтад бэлдье. Шинэ асуудал эхэлсэн учраас гишүүд санал хураалтад бэлдэх ёстой. Санал хураалтад бэлдье. Санал хураалтад бэлтгэх ажлыг дахин эхлүүлье.

Дэлгэц дээр гацсан дүрс гарсан байгаа юм байна. Хурууны хээ уншуулахад зүгээр юм байна.

Тэгэхээр гишүүд хурууныхаа хээг уншуулаад санал хураалтын бэлтгэл хангая. Би энэчээнээс бүртгэлийг харчихъя. Туршаад ирц бүртгэлийн нэг санал хураалт явуулаадахъя.

Ирц бүртгэлийн санал хураалт.

Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “дээд хэмжээг” гэсний дараа “нэгэн зэрэг” гэж нэмэх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн.

Санал хураалт.

72 гишүүн буюу 66.1 хувиар санал дэмжигдлээ

2.Төсөлд доор дурдсан агуулга бүхий зүйл нэмэх:

“2 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн.

Санал хураалт 69 гишүүн буюу 63.3 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

19.28 цаг

Дараачийн санал хураалтад оръё.

Найм дахь асуудал Монгол Улс дахь Хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүнд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа.

Санал хураалт явагдана. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд санал хураалтад бэлдье.

Санал хураалт.

1.Байнгын хорооны саналаар “Монгол Улс дахь Хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт 70 гишүүн буюу 64.2 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа

Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье ээ.

19.32 цаг

Дараагийн асуудалд оръё. “Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа.

Санал хураалт явагдана. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Санал хураалт.

1.Байнгын хорооны саналаар “Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

73 гишүүн буюу 67 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье.

19.34 цаг

Дараагийн асуудалд оръё 11 дэх асуудал.

“Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа. Шууд санал хураалтад орно.

Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Санал хураалт.

Байнгын хорооны саналаар “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

67 гишүүн буюу 61.5 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа. Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье ээ.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдааныг өндөрлүүлье.

Маргааш өглөө хаврын ээлжит чуулганы сүүлчийн отгон өдөр. Өглөө 8 цагаас чуулганы хуралдаан эхэлнэ ээ.

19.35 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА